United Nations Educational, Scientific and Cultural Organization

APCEIU

Asia-Pacific Centre of Education for International Understanding under the auspices of UNESCO

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН

MONGOLIAN INSTITUTE FOR EDUCATIONAL RESEARCH

# ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ

*Багшид зориулсан гарын авлага*

2018

# ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ

## БАГШИД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

*(ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН БАГШ НАРЫН АЖЛЫН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАВ)*

УЛААНБААТАР 2018

ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ

*Багшид зориулсан гарын авлага*

*Боловсруулагчид:*
С.Санжаабадам
Б.Болорсайхан
Б.Баярмаа
У.Мягмаржав
Д.Пунцагсүрэн
Б.Эрдэнэчимэг
С.Отгонтуяа
Р.Золзаяа
Н.Мөнхбаяр
С.Гантулга
Б.Алтанцэцэг
Ж.Жавзан
Ч.Алтанчимэг
Н.Батсайхан
А.Дөлгөөн
Х.Эрдэнэтулга
*Хянан тохиолдуулсан:*
Н.Бэгз
Д.Тунгалаг

*Хэвлэлийн эх бэлтгэсэн:* Г.Ганчимэг
*Хэвлэлийн хуудас:* 19хх
*Хэвлэсэн тоо:* 200ш

© Зохиогчийн зөвшөөрөлгүй хувилан олшруулахыг хориглоно.

# АГУУЛГА

**ӨМНӨТГӨЛ** 4

ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫГ МОНГОЛЫН НӨХЦӨЛД БИД ХЭРХЭН АВЧ ҮЗСЭН БЭ? 5

**АРД ТҮМЭН**

- МАТЕМАТИК 11
- СУРГАЛТЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАГ 26
- НИЙГМИЙН УХААН 32
- БИОЛОГИ 35
- ДИЗАЙН ТЕХНОЛОГИ 60

**ГАРИГ ДЭЛХИЙ**

- МОНГОЛ ХЭЛ 76
- НИЙГМИЙН УХААН 87
- АНГЛИ ХЭЛ 89
- БИОЛОГИ 104

**ЭНХ ТАЙВАН**

- МОНГОЛ ХЭЛ 114
- НИЙГМИЙН УХААН 119
- НИЙГМИЙН УХААН 125
- АНГЛИ ХЭЛ 134
- БИОЛОГИ 142

# ӨМНӨТГӨЛ

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Тогтвортой хөгжлийн Инчоны тунхаглалын 9 дэх зүйлийг үндэс болгон Монгол-Солонгосын боловсролын хамтын ажиллагааны хүрээнд хүүхэд, залуучуудын Дэлхийн иргэний боловсрол (**ДИБ**)-ын агуулгыг хөгжүүлэх олон улсын судалгаанд оролцох зорилгоор БСШУС-ын Сайдын А/24 тоот тушаал гарсан. Судалгаа нь Монгол улсын ерөнхий боловсролын суралцагчдын дэлхийн иргэний боловсролыг дэмжихэд чиглэсэн бөгөөд **Дэлхийн иргэний боловсрол–багшид зориулсан гарын авлага** боловсруулах ажлыг Боловсролын хүрээлэн хэрэгжүүлэв.

Гарын авлага нь ДИБ-ын талаарх ойлголтын хүрээг Монгол улсын хувьд гарган тавьж, дэлхийн иргэн байхтай холбоотой ямар чадваруудыг өнөөгийн суралцагчдад хөгжүүлэх боломжтойг бага, суурь, бүрэн дунд боловсролын тодорхой ангиудын, тодорхой хичээлүүдийн агуулгад тулгуурлан сургалтын арга зүйн шийдлээр гарган танилцуулах зорилготой.

**Энэхүү зорилгын хүрээнд:**

- Дэлхийн иргэний боловсролын талаар ойлголттой болох, ойлголтоо гүнзгийрүүлэх,
- Суралцагчдын дэлхийн иргэн байх чадварыг багш өөрийн заадаг хичээлийн чиглэлээр хэрхэн дэмжих талаар анхаарч, арга зүйгээр дэмжиж хөгжүүлэх,
- Суралцагчдын дэлхийн иргэн байх чадварыг багш өөрийн заадаг хичээлээс гадна бусад хичээлүүдтэй арга зүйн хувьд уялдуулан хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх,
- Тодорхой насны хүүхдэд дэлхийн иргэний боловсролыг түгээхэд ЮНЕСКО-гийн санал болгосон агуулга, суралцахуйн зорилтыг өөрийн анги, суралцагчдын түвшинд хэрхэн ашиглах болон арга зүйн бүтээлч хувилбарыг боловсруулан ашиглахад багшийн үйл ажиллагаа чиглэх ёстой юм.

## Гарын авлагыг хэрхэн ашиглах вэ?

### Сургуулийн удирдлага

Сургуулийн түвшинд бага, дунд, ахлах ангийн суралцагчдын дэлхийн иргэний чадварыг хөгжүүлэхэд багш нарын хамтын үйл ажиллагааг дэлхийн иргэний боловсролд төвлөрүүлэн, менежментийн дэмжлэг үзүүлэх. Үүний тулд хичээл болон хүүхэд хөгжүүлэх бүхий л төрлийн үйл ажиллагаанд дэлхийн иргэний боловсролын танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл, зан байдлын домэйны тодорхой чадваруудыг хэрхэн хөгжүүлэх боломжтойг багш нарын түвшинд хэлэлцэн, өөрийн сургуулийн бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.

Багш

Гарын авлагыг судалж, дэлхийн иргэний боловсролын талаарх ойлголтод тулгуурлан, суралцагчдын дэлхийн иргэн байх чадварыг хөгжүүлэхэд сургалтын арга зүйгээ чиглүүлэх, мөн арга зүйн хувилбараа хэрхэн сайжруулахаа тодорхойлох. Үүний тулд өөрийн заадаг хичээлээс гадна бусад хичээлүүдээр гарын авлага боловсруулагчдын санал болгосон арга зүйн хувилбаруудын **нийтлэг болон ялгаатай шийдэлд** анхаарлаа хандуулна.

Багш бие даан ажиллахаас гадна ижил мэргэжлийн болон өөр мэргэжлийн багш нартай хамтран зөвлөх, хичээлийн төлөвлөгөөг хамтран боловсруулах, суралцагчдад илэрч буй хандлагын өөрчлөлтийг ажиглах, тэмдэглэх, үнэлэх улмаар уг мэдээллийг сургах зүйн зорилгоор бүтээлчээр ашиглаж, багш-сурагч-эцэг эхийн хамтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Гарын авлагад **Ард түмэн, Гариг дэлхий, Энх тайван** гэсэн сэдвийн хүрээнд ерөнхий боловсролын монгол хэл, англи хэл, математик, биологи, нийгмийн ухаан, дизайн технологийн хичээлүүдийг жишээ болгон сонгож, хичээлийн төлөвлөлтөөс гадна тухайн судлагдахууны агуулгын ерөнхий хүрээнд дэлхийн иргэний чадварыг хөгжүүлэх шийдэл, арга зүйн бүтээлч хувилбаруудыг тусгав.

**Багш нар тухайн хувилбарын хувьд:**

- Суралцагчдын дэлхийн иргэний ямар чадвар хөгжүүлэхийг зорилго болгосон.
- Ямар арга ашигласан.
- Хичээлийн бүтэц, зохион байгуулалтын ямар хувилбарыг санал болгосон.
- Агуулгын босоо болон хэвтээ холбоог хэрхэн боловсруулсан.
- Үнэлгээний ямар даалгавруудыг ашигласан.
- Мэдээллийн ямар нэмэлт эх сурвалжийг заасныг тодорхой болгосноор өөрийн хувилбарыг боловсруулах боломжтой болно.

## Дэлхийн иргэний боловсролыг Монголын нөхцөлд бид хэрхэн авч үзсэн бэ?

*Боловсрол хөгжилтэй уялдах нь*

Дэлхийн I, II дайны туршлагаас улс орнууд энх тайван, хөгжил, хүний сайн сайхны төлөө нэгдэх хэрэгтэйгээ хүлээн зөвшөөрч, Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) байгуулсан төдийгүй хөгжлийг эдийн засгийн үзүүлэлтээр хэмжихээр зорьсон ч өсөлт, дэвшил, хөгжлөө харилцан ялгахгүй явсаар ирсэн юм. Үүнтэй уялдан XX зууны II хагасаас хүнийг хөгжлийн төвд тавих, хүний эрх, эрх чөлөөний асуудлыг байнга тусгах санаачилга эхэлсэн байна. Удалгүй НҮБ-аас 1986 онд Хөгжих эрхийн тунхаглал баталж, "хөгжил бол хүний эдлэх эрх; хөгжлийн үр шимийг хүртэгч нь хүн; боломж, сонголт бий болгохгүйгээр хөгжил байхгүй; хөгжил нь нийгмийн баялгийг шударга хуваарилах, түүний үр шимийг хүртэхэд хүмүүс сайн дураар утга учиртай оролцох нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын тасралтгүй үргэлжлэх үйл явц" хэмээн тодорхойлсон бол НҮБ-ын Хүрээлэн буй орчин, хөгжил хариуцсан Дэлхийн Комиссоос 1987 онд баталсан "Бидний дундын ирээдүй"

тайланд тогтвортой хөгжлийг "ирээдүй хойч үеийнхээ хэрэгцээгээ хангах чадварыг бууруулахгүйгээр одоогийн хэрэгцээгээ хангаж байх"-аар тодорхойлсон ажээ *(Зургийг: НҮБ-ын БШУСБ, Махатма Гандигийн Энх тайван, тогтвортой хөгжлийн боловсролын хүрээлэн).* Ялангуяа дайны хөлөөс дайжсан шилжин суурьшигч, цагаач, дүрвэгсэд, ажилгүй, орон гэргүй зэрэг хүмүүс, хүүхэд, эмэгтэйчүүдийн амьдралыг сайжруулахын тулд эдийн засгийн үзүүлэлтийг чухалчилсан бол XX зууны төгсгөлд хүний сайн сайхныг




эрх, эрх чөлөөгүйгээр цогцлоох боломжгүйг хүлээн зөвшөөрч, НҮБ 2000-2015 онд Мянганы хөгжлийн зорилтууд (МХЗ)-ыг бодит үйл хэрэг болгохоор улс орнуудын хамт хичээн зүтгэсэн болно. Үүнтэй уялдан нийгэмд тулгамдаж буй асуудлуудыг шийдэхийн тулд хандив эсвэл хандиваас татгалзаж, хэрэгцээнээс илүүтэйгээр **хүний эрхэд суурилсан байдлаар улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлох хандлага** түгсэн ба 2015-2030 онд Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ыг хэрэгжүүлэхдээ өмнөх МХЗ-ын ахиц дэвшлийг цааш ахиулах, "хэнийг ч ардаа үлдээхгүй", "Ард түмэн; Гариг дэлхий; Хөгжил цэцэглэл; Энх тайван; Түншлэл"-д тулгуурлан бодит биелэл болгохоор төлөвлөсөн юм.

Дэлхий даяар ТХЗ-ыг хэрэгжүүлэхдээ Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилгыг чухалчлан үзэж, чанартай боловсрол, тэр дундаа 4.7 дахь зорилтыг хэрэгжүүлэх нь хүний хөгжлийн үндэс, бусад зорилтыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх тулгуур болно. Тодруулбал, энэхүү зорилтыг хэрэгжүүлэх тулгуур болох иргэн хүн Дэлхийн иргэн байх чадвар, түүнийг хөгжүүлэх асуудалд энэхүү гарын авлагын агуулга чиглэсэн болно.

**Тогтвортой хөгжлийн 4.7 дахь зорилт**

2030 он гэхэд бүх суралцагчид боловсролоор дамжуулан тогтвортой хөгжпийг дэмжихэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадварыг тухайлбал, тогтвортой хөгжил, тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жендэрийн тэгш байдал, энх тайван, хүчирхийллийг үл дэмжих, дэлхийн иргэн байх, тогтвортой хөгжилд соёлын оруулж буй хувь нэмэр, соёлын олон төрөл, зүйлд эерэгээр хандах зэрэг хандлагад суралцсан байна.

*Дэлхийн иргэний боловсрол, Иргэний боловсролын уялдаа*

Хөгжлийг тодорхойлж байгаатай уялдан дэлхий иргэний боловсролын агуулга, ач холбогдлыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай. Иргэн зүй (Civics[1]) нь иргэний амьдралын суурь болох орон нутгийн удирдлага хэрхэн ажилладаг, тухайн хот сууринд амьдарч байгаа иргэдийн эдлэх эрх, хүлээх үүргийг тусгайлан судалдаг[2] бол иргэний боловсрол (Civic Education) нь илүү өргөн хүрээг хамардаг. Тодруулбал, тухайн орны улс төрийн нөхцөл байдал, төрийн тогтолцоо, сонгуулиар сонгогддог албан тушаалтны эрх мэдэл, мөн чанар, тухайн үндэстэнд тулгарч байгаа эдийн засаг, нийгэм, улс төрийн асуудал, ардчиллын үнэ цэн, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, энх тайван, эвлэрүүлэн зуучлахын ач холбогдлыг таниулдаг онцлогтой[3]. Мөн орон нутгийн болон үндэсний түвшинд ардчилал, хөгжлийн үйл явцад үр дүнтэй оролцоход суралцахыг ойлгох ба ил тод байдал, оролцоо, хариу үйлдэл үзүүлдэг чадавх, эгэх хариуцлага, эрх мэдэлжих үйл явц, тэгш боломж гэсэн үнэт зүйлс, зарчимд тулгуурладаг[4].

Иргэн байх тухай (Citizenship) ойлголтын хувьд хууль зүй, улс төрийн, нийгэм судлалын бүрэлдэхүүн шинжийг агуулсан, гишүүнчлэл, амин чанар (identity), төрөөс шаардах эрх, бусдын өмнө хүлээх үүргийг илэрхийлэх ч нийтлэгээр иргэдийг цаг ямагт ардчиллын үндэс хэмээн үздэг билээ. Иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, шилжин суурьшигч гэсэн нэр томьёогоор тухайн хүнийг илэрхийлэх нь хууль зүйн болон улс төрийн ойлголтод багтана. Аливаа ардчилсан улсын иргэн[5] болсон[6] хүн бүрт хамаарах хүрээг:

- Улс төрийн нөхцөл байдалд тухайн этгээдийн эзлэх байр суурь
- Ардчилалд иргэний хувиар гүйцэтгэх үүрэг
- Ардчилалд иргэний хувиар эдлэх эрх, хүлээх үүрэг
- Иргэний амьдрал, улстөр, төрд иргэний хувиар оролцох боломжоор тодорхойлсон байна[7].

Үүний зэрэгцээ 1990-2003 онд иргэн байх тухай боловсролын талаар хийсэн судалгааг нэгтгэн харахад эх оронч үзэл, эх орныхоо төлөө зүтгэх, эх орноо гэсэн сэтгэлийн хамт хувь хүний эрх, эрх чөлөөг хангах талаар өгүүлсэн байдаг[8]. Өнгөрсөн зуунд иргэний, улс төрийн, нийгмийн эрх улам хөгжихийн хэрээр иргэн байх тухай ойлголтын хүрээ улам өргөжиж, дэлхий дахинд хүн төрөлхтний хүй олны нэг гишүүн хэмээн "дэлхийн иргэн"

---

*1 Мэдээлэл зүй (Informatics), Ёс зүй (Ethics), Гоо зүй (Aesthetics) гэх мэт*

*2 Харвардын их сургууль, Американа нэвтэрхий толь бичиг, Нью-Йорк 1920 он, 726 дахь тал.*

*3 Жендэрийн асуудал, эмэгтэйчүүдийг чадавхжуулах асуудал хариуцсан Тусгай зөвлөхийн газар, "Эмэгтэйчүүд ба сонгууль: Сонгуульд эмэгтэйчүүдийг оролцоог хөхиүлэн дэмжих гарын авлага", НҮБ 2005 он, 56-57 дахь тал.*

*4 НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хөгжлийн бодлого хариуцсан товчоо, Ардчилсан засаглалын бүлэг, "Иргэний боловсрол" Өдөр тутам ашиглах зааварт удирдамж, НҮБ 2016 он, 5 дахь тал.*

*5 Иргэний харьялал нь үндэстнээс бүрэлдсэн улетай холбоотой, төрсөн газар, эцэг эх, харьяалал зэргээс хамаардаг хууль зүйн ойлголтоос илүү ергежиж, "дэлхийн иргэн байх" гэсэн ойлголттой уялдан өргөжүүлэн хэрэглэх болжээ. Дэлгэрэнгүй: www.ids.ac.uk/ids/bookshop/db/db19.pdf*

*6 Херсний (jus soli) эсвэл цусны (jus sanguinis) зарчмаас үл хамаарна.*

*7 НҮБ-ын БШУСГ, сэтгүүлчдэд зориулсан цуврал, Факсан Банда," Хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдэд зориулсан иргэний боловсрол: Сургалтын гарын авлага" НҮБ, 2009 он, 32 дахь тал*

*8 НҮБ-ын БШУСГ, Махатма Гандигийн Энх тайван, тогтвортой хегжлийн боловсролын хүрээлэн, Жилл Кояама, Аризонагийн их сургууль, "Ярвигтай, бусдаас ялгарах дэлхийн иргэн", Шинэ Дели 2015 он, 6 дахь тал.*

гэсэн нэр томьёог хэрэглэх болжээ. Дэлхийн иргэн байх гэдгийг үндэстний хэмжээнээс тэлэн гарч, хүн төрөлхтний нэг хэсэг гэж тодорхойлж байна. Энэ нь орон нутгийн, үндэсний, олон улсын түвшинд улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын хоорондын хамаарал, харилцан холбоотой байдлаас үүдэлтэй[9]. Дэлхийн иргэний боловсрол нь хувиран өөрчлөгдөж байгаа дэлхий ертөнцийн асуудалтай нүүр тулах, шийдэх, илүү амгалан, хүлцэн тэвчсэн, бүгдийг тэгш хамруулсан, аюулгүй ертөнц бий болгоход угтан хувь нэмрээ оруулдаг бөгөөд найман настай балчраас наян настай өтгөс хүртэл бүх насны суралцагчдад зориулсан юм. Дэлхийн хэмжээний асуудлууд болон шударга ёс, тэгш байдал, эрхэм чанар, хүндлэл зэрэг хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлсийн талаар гүнзгий мэдлэгтэй, шүүн тунгааж, эрэмбэтэй, бүтээлчээр сэтгэх, асуудлыг олон талаас төрөл бүрийн орчинд харилцан адилгүй өнцгөөс харж чаддаг олон чигт хандлагатай, нинжин сэтгэл, зөрчилдөөнийг шийдвэрлэх зэрэг танин мэдэхүйн бус, нийгмийн шинжтэй ур чадвар, өөр өөр туршлага, үндэс гарвал, соёл, үзэл санаатай хүмүүстэй харилцах, холбоо тогтоох ур чадвар, хандлагатай байх, зан байдлын тухайд бусадтай хариуцлагатайгаар хамтран ажиллаж, нийтийн сайн сайхны (Үнэт зүйл) төлөө зүтгэж байгааг (зан үй) дэлхийн иргэний боловсролтой хүн гэж үзэх боломжтой.

Үнэт зүйлсийг тодорхойлохдоо НҮБ-ын дүрэм, хүний эрхийн талаарх улс орнуудын түгээмлээр нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд тулгуурлан боловсруулав. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ки Мүн 2012 онд эхэлсэн "Боловсролыг эн тэргүүнд" Дэлхийн санаачилгыг нээхдээ хэлсэн үгэндээ "Бид дэлхийн иргэн байхуй гэсэн үзэл баримтлалыг өсгөн бойжуулах ёстой. Боловсрол бол уншиж сурах, тоо тоолоход суралцахаас гүнзгий иргэн ёсны тухай ойлголт билээ. Боловсрол нь хүмүүст илүү шударга, тайван, хүлцэн тэвчсэн нийгмээ цогцлоон бэхжүүлэхэд туслахуйц амин чухал үүрэг гүйцэтгэх ёстой билээ." хэмээн онцолсон юм. Дэлхийн иргэний боловсрол нь илүү амар амгалан, хүлцэн тэвчсэн, тэгш хамруулсан ертөнцийг бий болгоход иргэд оролцох, идэвхтэй үүрэг гүйцэтгэхийн тулд эрх мэдэлжүүлэх зорилготой. Ялангуяа8 дэлхийн хамтын нийгэмлэгт хамаарахын сацуу хүн төрөлхтний нэг хэсэг гэсэн мэдрэмжийг хүртэл бий болгоно. Мөн дор зурагт үзүүлсэн хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлсийг хүндэтгэх явдлыг хөхиүлэн дэмждэг. Үүнтэй уялдан мэдлэг хэсэгт дурдсан энх тайван, хүний эрх, соёлын харилцан ойлголцол, иргэний боловсрол, ялгаатай байдлыг хүндэтгэх, хүлцэн тэвчих, тэгш хамруулах ойлголт ч багтдаг.

Тухайн улсын зүгээс өөрийн үндэстний амин чанарт тулгуурлан нэгэн Дэлхий дээр амьдрах хүн төрөлхтний хүй олны идэвхтэй гишүүн байхын тулд суралцагчдын чадамжийг тусгайлан анхаарах ёстой. Монголчуудын талаар эрт дээр үеэс өгүүлсэн түүхийн эх сурвалж, түүхчдийн тодорхойлолтоос үндэстний амин чанарт багтах цөөнгүй эерэг шинжийг олонтаа дурдсан байдаг[10]. Үүнд:

*9 НҮБ-ын БШУСГ, Махатма Гандигийн Энх тайван, тогтвортой хөгжлийн боловсролын хүрээлэн, Жилл Кояама, Аризонагийн их сургууль, "Ярвигтай, бусдаас ялгарах дэлхийн иргэн", Шинэ Дели 2015 он, 14 дэх тал.*
*10 Монголын нууц товчоо, Б.Ренчин, "Залуучуудын үнэн" сонин 1968 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн №48 дугаар, "Монголын За андгаар буй" Улаанбаатар хот; Л.Н.Гумилев, Ритмы Евроазии: Эпохи и цивилизации, "Экопресс" 1993 гэх мэт.*

*Хатан зориг:* Өөртөө итгэлтэй, тэвчээртэй, бие даасан, хараат бус;

*Үнэнч байдал:* Хэлсэндээ хүрдэг, тангарагаас няцдаггүй, тууштай, урваж шарвадаггүй, шударгуу;

*Саруул ухаан:* Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, шийдвэр гаргах, урьдчилан төлөвлөх;

*Байгальтай эвсэн амьдрахуй:* Нөөцөд шунадаггүй, ихээр хураадаггүй, зохистой хэрэглэдэг, ариг гамтай харьцдаг, хайрладаг, тусч, ажилсаг;

*Дасан зохицохуй:* Хурдан суралцдаг, ажигч, сониуч, шинийг санаачилдаг хэмээн цохон тэмдэглэжээ.

Ийнхүү тус гарын авлагын хүрээнд дэлхийн иргэний боловсролын агуулгыг тодорхойлохдоо үндэсний амин чанарын зарим сайн шинжид тулгуурлан хувь хүний хөгжилд шаардлагатай чадварыг дараах байдлаар тодорхойлов:

- Орчин цагийн нүүдэлчин (Modern Nomads) - Байгальтай эвсэн амьдарч, орчин цагийн шинжлэх ухааны ололт, дэвшлийг амьдрал, аж ахуйдаа нэвтрүүлэн ашигладаг, нүүдлийн соёлын өвийг тээгч байна.
- Тэсвэртэй хүй олны гишүүн (Resilient Community Member) - Нийгэм, эдийн засаг, улс төр, байгаль, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийг давж, эргэн амьдрал ахуйгаа сэргээн босгох чадвартай нийгмийн бүлгийн төлөөлөл байна.
- Эгэх хариуцлагатай, идэвхтэй иргэн (Accountable and active citizen) - Төрийн үйл хэрэгт хуулийн дагуу хүчирхийллийн бус аргаар сайн дураар чөлөөтэй оролцож, өөрийн амьдралд хамаарах шийдвэр гаргахад утга учиртай шууд оролцдог иргэн байна.
- Хүлцэн тэвчдэг хувь хүн (Tolerant Person) - Ялгаатай байдлыг ямар нэгэн ташаа бодол, ялгаварлан гадуурхалтгүйгээр хүлээн зөвшөөрч, хүндэтгэж, бусадтай зэрэгцэн амьдарч чаддаг нэгэн байна.

Бид гарын авлагад дэлхийн иргэний боловсролын 3 домэйнээс дараах чадваруудад илүү анхаарлаа хандуулсан юм. Ялангуяа орчин цагт нийгэм-сэтгэл хөдлөлийн чадвар нь Тогтвортой хөгжлийн 4.7 дахь зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой төдийгүй хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлсийг өөрийн болгоход гол тулгуур, цаашид бусад хүнтэй харилцахад шаардлагатай хандлага тогтох үндэс билээ.

*Хүснэгт 1. Дэлхийн иргэний боловсрол багшийн гарын авлагад онцолсон ур чадварууд*

| Танин мэдэхүй | Нийгэм-сэтгэл хөдлөл | Зан байдал |
|---|---|---|
| Дэлхий, бүс нутаг, үндэстэн, орон нутгийн асуудлаар болон харилцан адилгүй улс, хүн амын хоорондын харилцан холбоот байдал, харилцан хамаарлын тухай мэдлэг олж авах, ойлгох, шүүн тунгаах | Тухайн хүн өөрийгөө дундын үнэт зүйлстэй, хариуцлагаа хуваалцсан, нинжин сэтгэлтэй, эв санааны нэгдэлтэй, бусдын ялгаа, ялгаатай байдлыг хүндэтгэсэн нийтлэг хүн төрөлхтний нэг хэсэг гэж мэдрэх | Илүү амгалан, тогтвортой ертөнцийн төлөө орон нутаг, үндэстэн, дэлхийн түвшинд идэвхтэй, оролцоотой, үйлдэл хийдэг, хариуцлагатай байх |

## Дэлхийн иргэний боловсрол–багшид зориулсан гарын авлагын шалгуур

| Ерөнхий шалгуур |
|---|
| Орон нутаг, үндэстэн, бүс нутаг, олон улсын ард иргэдийн харилцан хамаарал, уялдаа холбооны талаарх мэдлэг, ойлголт суралцагчид чухал болох талаас нь ойлгоход чиглэсэн эсэх |
| Хүн төрөлхтөн олон улс, бүс нутаг, үндэстэн, орон нутгийнхаа түвшинд тогтвортой, энх тайван, амар амгалан амьдрахад суралцагчийн үүрэг хариуцлага чухал болохыг ухамсарлахад чиглэсэн эсэх |

| Домэйн | Тусгай шалгуур |
|---|---|
| Танин мэдэхүй | Суралцагчийн “Дэлхийн иргэний” талаарх мэдлэг ойлголтыг эзэмшүүлэхэд чиглэсэн эсэх |
| Нийгэм-сэтгэл хөдлөл | Суралцагчийн ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн эсэх |
| | Суралцагчийн ялгаатай байдалд хундэтгэлтэй хандах чадварыг хөгжүулэхэд чиглэсэн эсэх |
| | Суралцагчийн хүрээлэн буй орчиндоо хундэтгэлтэй хандах чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн эсэх |
| | Суралцагчийн хүлээцтэй байх чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн эсэх |
| | Суралцагчийн олон талт соёлыг ойлгох чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн эсэх |
| Зан байдал | Суралцагчийн аливаа зүйлийг ёс суртахууны нийтлэг хэм хэмжээнд нийцүүлэн ойлгох чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн эсэх |
| | Суралцагчийн нээлттэй байх чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн эсэх |
| | Суралцагчийн оролцогч байх чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн эсэх |
| | Суралцагчийн хариуцлагатай байх чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн эсэх |

# ДЭЛХИЙН ИРГЭНИЙ ЗАРИМ ЧАДВАРЫГ СУДЛАГДАХУУНААР ДАМЖУУЛАН ХӨГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙН ХУВИЛБАРУУД

## АРД ТҮМЭН

### МАТЕМАТИК

**Зорилго:** Сурагчдад математикийн бага, суурь, бүрэн дунд боловсрол олгох явцдаа тэдний дэлхийн иргэний боловсролын чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн арга зүйн зарим санааг багш нарт өгөхөд оршино.

**Агуулга:** Дэлхийн иргэний боловсрол (ДИБ) ба математикийн бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгыг дараах бүдүүвчээр харуулав.

*Зураг 1. ДИБ ба математикийн мэдлэг, чадвар уялдуулах боломж*



Дэлхийн иргэний боловсролын агуулгад тулгуурлан орон нутаг, үндэстэн, бүс нутаг, олон улсын ард иргэдийн харилцан хамаарал, уялдаа холбоо болон тогтвортой, амар амгалан, энх тайван амьдралыг бий болгохын чухлыг ойлгоход чиглэсэн ахуй, амьдралын асуудлыг математикийн сургалтын хөтөлбөрийн холбогдох агуулгатай уялдуулан сонгон, тухайн асуудлыг ойлгох, хэлэлцэх, шийдвэрлэх явцдаа математикийн болон ДИБ-ын мэдлэг, чадвараа хөгжүүлэх байдлаар агуулгыг хэрэгжүүлнэ.

*Хүснэгт 1. Математикийн болон ДИБ-ын агуулгыг уялдуулж болох зарим сэдвийн санаа*

| Математик | | Дэлхийн иргэний боловсрол |
|---|---|---|
| Тоо тоолол, алгебр | Олон оронтой тоо | Хүн ам, хүн амын бүлгийн тоо, амьтны тоо толгой, барааны үнэ ханш, дотоодын нийт бүтээгдэхүүн, жиших, эрэмбэлэх, тоймлох, үйлдэл гүйцэтгэх гэх мэт. |
| | Энгийн ба аравтын бутархай, харьцаа, пропорц | Хувь хүн, өрх, орон нутаг, үндэсний орлого, зарлагын тооцоо; тоо, хэмжээний хэсгийг тооцох, эдийн засаг, нөөцийн тэгш, тэгш бус хуваарилалт, газрын зургийн хэрэглээ (масштаб), хоолны орц, жорын дагуу тодорхой тооны хүнд хоол бэлтгэх гэх мэт. |
| | Процент | Цалин, барааны үнийн өсөлт, бууралтын хувь, зээлийн хүү, татвар, орон нутаг, улс оронд тодорхой нөөцийг хүртэж чадаж байгаа хүн амын эзлэх хувь, сургуульд хамрагдалтын хувь, тодорхой процентод ногдох тоо, хэмжээгээр уул тоо, хэмжээг олох гэх мэт. |
| | Функц, хамаарал | Эрүүл мэнд; хүн амын өсөлт, ирээдүйн прогноз; нөөцийн хэрэглээ, хамгаалал; уур амьсгалын өөрчлөлт; орчны бохирдол гэх мэт. |
| Геометр, хэмжигдэхүүн | Дүрс, биет | Олон соёлын: барилга, гудамж, зам талбайн архитектор (дүрсээр хээлэх, тэгш хэм гэх мэт), тусгай хэрэгцээтэй хүмүүст зориулсан тэрэг, нэвтрэх гарцын загвар гэх мэт. |
| | Хэмжигдэхүүн | Хүний авах илчлэг, шим тэжээлийн хэмжээ, хоол хүнсний зохистой хэрэглээ, биеийн жин, улс орнуудын газар нутгийн хэмжээ, нөөцийн хэмжээ, хэрэглээ, тодорхой үйлд зарцуулах хугацаа нас, хүйс, газар нутгаар, хүнс, барааг үйлдвэрлэх явц, дамжлага, өртөг гэх мэт. |
| | Байршил, хөдөлгөөн | Гэрээс сургууль явах зам, орон нутаг дахь аюулгүй орчин, замын зураглал, план зураг, маршрут, газрын зургийн хэрэглээ, хээ, барилгын үзэмж, дизайн гэх мэт. |
| Магадлал, статистик | Өгөгдөлтэй ажиллах, өгөгдлийн шинжилгээ | Хоол хүнс, газар тариалан; ядуурал; өлсгөлөн; эрүүл мэнд; нөөц (ус, цахилгаан гэх мэт), түүний хэрэглээ, хамгаалал, экологийн ул мөр; худалдаа, үйлдвэрлэл; бохирдол, эдийн засаг, байгаль орчинд баяр, аялал зугаалгын үзүүлэх нөлөө; ажил эрхлэлт; боловсрол; хувь хүн, улс, үндэстэн, соёлын ялгаатай байдал; орон нутаг, улс орон, бүс нутаг, олон улсын нийгэм, эдийн засаг, байгаль орчны хөгжил; тэгш бус байдал, нийгмийн халамж, үйлчилгээ гэх мэт. |
| | Магадлал | Өмнөх тэмцээний дүнгээр дараагийн тэмцээний үр дүнг таамаглах, хожиход юу нөлөөлж болох, энэ нь шударга, шударга бус эсэхийг хэлэлцэх, тоглоом, сугалаанд хожих магадлалыг тооцох, тухайн улирал дахь цаг агаар, байгалийн үзэгдлийн илрэх боломж, магадлалыг тооцох гэх мэт. |

Сонгосон асуудлаас хамаарч сургалтын агуулга нь математик болон бусад хичээл (судлагдахуун) хоорондын агуулгын босоо, хэвтээ залгамж холбоонд тулгуурлан өргөсөх буюу гүнзгийрэх ба энэ үед эдгээрийг тооцон залгамж холбоогоо гаргаарай.

## Арга зүй

Сурагчийн нас, хөгжлийн онцлог, суралцах хэв маягийг харгалзан сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ дараах зүйлсийг анхаараарай. Үүнд:

- Сургалтын зорилгыг сурагчид төлөвших чадварт баримжаалан тодорхойлох
- ДИБ-ын агуулгад тулгуурлан орон нутаг, үндэстэн, бүс нутаг, олон улсын түвшний асуудлыг математикийн холбогдох агуулгатай уялдуулан сонгох
- Агуулгыг тогтолцооны шинжилгээ, дидактик нэгжийг томсгох аргаар нягтруулах
- Сурагч өөрийн идэвхтэй, оролцоотой үйл ажиллагааны явцадмэдлэг бүтээх, асуудал шийдвэрлэх хэрэгцээ, сонирхолтой болох, хувиран өөрчлөгдөхөд нь хөтлөх сургалтын материаллаг, сэтгэл зүйн, үйлийн таатай орчин бүрдүүлэх
- Танин мэдэхүйн ерөнхийлөх, тусгайлах, зүйрлэх, загварчлах, задлан шинжлэх, эвлүүлэх зэрэг ерөнхий болон тооцоолох, батлах зэрэг тусгай аргууд, математик үг хэллэг, тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэн учир зүйг үндэслэх
- Мэдээлэл харилцааны технологийг хэрэглэх
- Сурагчийн мэдлэг, чадварыг гүйцэтгэж буй танин мэдэхүйн үйл, үйлдлийн үр дүнгээр үнэлэх, хөгжүүлэх явцын үнэлгээний арга, хэлбэрүүдийг хэрэглэх

*Багшийн эргэцүүлэх асуулт:*

Сургалт нь мэдээлэл дамжуулахад чиглэх ёстой юу?

Эсвэл сурагч тухайн мэдлэг, чадварт суралцах, сурсан мэдлэг, чадварт суурилан хувь хүний хувьд хандлага, зан үйл нь хувиран өөрчлөгдөхөд хөтлөх ёстой юу?

***Арга зүйн хөгжлийн чиг хандлага***

| | |
|---|---|
| Багшлахуй | Суралцахуй (сурагч, багш) ⟶ насан туршдаа |
| Мэдээлэл дамжуулах | Мэдлэг бүтээх |
| Категоричилсан суралцахуй | Судлан шинжлэхэд чиглэсэн интеграцчилсан суралцахуй |
| Цээжилж суралцахуй | Бүтээлчээр сэтгэж, хэрэглэж хувиран өөрчлөгдөхөд суралцахуй |
| Нэгжид төвлөрөх | Системт сэтгэлгээг хөгжүүлэх |
| Бие даан ажиллах, өрсөлдөх соёл | Хамтран ажиллах, харилцан бие биенээ хүндэтгэх соёл |
| Үнэлгээ нь сургалтад хяналт шинжилгээ хийх хэрэгсэл | Үнэлгээ нь урамшуулан дэмжих, суралцахуйг оношлон өөрчлөх хэрэгсэл |

Сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахдаа суралцахуйн зорилт, суралцахуйн гурван хүрээний агуулга (мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйлс) зэрэгтэй уялдуулан, сурагчид "үлдэх гол санаа юу вэ", "юуг өөрчлөх вэ (мэдлэг, чадвар, хандлага)" гэдгийг тооцон орон нутаг, үндэсний, бүс нутгийн, дэлхийн хэмжээний асуудлыг сонгон, сурагчид уг асуудлыг ойлгох, математикаар загварчлах, тооцоолох, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн, энгийнээс гүнзгийрсэн, сурагчид бие даан, хосоор, багаар ажиллах, идэвх сонирхолтой, оролцоотой, нээлттэй байх боломж олгох идэвхтэй сургалтын арга, дасгал, тоглоом сонгохыг эрмэлзээрэй.

## Зохион байгуулж болох зарим үйл ажиллагааны санаа

**Үйл ажиллагаа.** Бидний хэрэгцээ, хүсэл

**Зорилго:** Хэрэгцээ, хүслийн талаар эргэцүүлэх, ялгах

Холбогдох агуулга:

| | Мэдлэг | Чадвар | Хандлага |
|---|---|---|---|
| Математик | Өгөгдөлтэй ажиллах | • Юмсыг ялгах, эрэмбэлэх,<br>• Эргэцүүлэн бодох, дүгнэлт гаргах | Идэвхтэй оролцох |
| ДИБ | • Хоол хүнс<br>• Хүний эрх | Хүлээцтэй байх:<br>• Бусдын үзэл бодлыг хүндэтгэн сонсох<br>• Үзэл бодлоо илэрхийлэх | |

Хэрэглэгдэхүүн: Самбар, шохой, маркер, үзэг, харандаа, дэвтэр

Алхам 1: Дараах үгсийг хүснэгтийн хоёр баганад ялган бичих буюу байрлуулах

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Боловсрол | Интернет | Шатар | Цэвэр агаар | Зурагт | Хоол хүнс | Ухаалаг гар утас |
| Хөгжим | Сургууль | Дугуй | Мод | Ном | Хийжүүлсэн ундаа | Тоглоом |

| Бидний хэрэгцээ | Бидний хүсэл |
|---|---|
| | |

Алхам 2: Сурагчдын ялгаатай хэрэгцээ, хүслийн талаар хэлэлцэх

Сурагч бүр бие даан үгсийг дэвтэртээ ялган бичээд, дараа нь хосоороо, багаараа, анги нийтээрээ хэлэлцэх байдлаар зохион байгуулж болно.

Чиглүүлэх асуулт:

- Илүү хэрэгцээтэй зүйлсийг эхэнд нь бичих байдлаар эрэмбэлээрэй.
- Хүний хамгийн суурь хэрэгцээ, эрх нь юу вэ? Аль нь хамгийн чухал байна вэ?
- Хүн бүр эдгээр хэрэгцээгээ хангаж, эрхээ эдэлж чадаж байгаа болов уу? Яагаад?
- Хүнд хэрэгцээтэй зүйлсийн талаарх таны бодол өөрчлөгдсөн үү? Тайлбараа дэлгэрүүлэн бичнэ үү.

***Багшид***

Энэхүү үйл ажиллагааг бага, суурь, бүрэн дунд боловсролын аль ч түвшинд зохион байгуулж болох ба өгсөн үгсийг өөрчлөх, бусад хичээлийн агуулгатай уялдуулах, өөр асуулт, нэмэлт үйлээр баяжуулах зэргээр бүтээлчээр сайжруулан хэрэглээрэй. Багш хэлэлцүүлгийг асуултаар чиглүүлж, сурагчдын гаргасан санаанд тулгуурлан үйл ажиллагааг нэгтгэн дүгнэнэ.

Тухайлбал, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд “хоол хүнс” сэдвээр хооллох хэрэгцээг Үндсэн хууль (1992)-ийн хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлийн “хүн амьд явах эрхтэй” гэсэн нэгдүгээр заалт, “Хүний эрхийн түгээмэл тунхаг” (1948) зэрэг баримт бичгүүд дэх хүний эрхтэй холбон дүгнэж болох юм.

## Бидний хооллолт

**Зорилго:** Өөрсдийн хооллолтын хэв маяг, хооллолтын зөвлөмжийн талаар эргэцүүлэн, эрүүл мэнддээ хэрэгтэй сонголтыг хийхийг эрмэлзэх

Холбогдох агуулга:

<table>
<tr><th></th><th>Мэдлэг</th><th>Чадвар</th><th>Хандлага</th></tr>
<tr><td>Математик</td><td>Өгөгдөлтэй ажиллах</td><td>• Ангилах, задлан шинжлэх, нэгтэн дүгнэх<br>• Өөрийгөө илэрхийлэх</td><td rowspan="2">• Идэвхтэй оролцох<br>• Эерэгээр хувиран өөрчлөгдөх</td></tr>
<tr><td>ДИБ</td><td>• Хоол хүнс<br>• Эрүүл мэнд<br>• Ялгаатай байдал</td><td>• Хүлээцтэй байх<br>• Хариуцлагатай байх<br>• Ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах</td></tr>
</table>

Хэрэглэгдэхүүн: Хүнсний бүтээгдэхүүний зураг, хооллолтын зөвлөмж, сурах бичиг

**Үйл ажиллагаа 1.** Идэх дуртай хүнс (Бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд)

*Дэвшүүлэх асуулт:* "Бид ямар хоол, хүнсний бүтээгдэхүүнийг идэх дуртай вэ?"

- Сурагч бүр идэх дуртай хоол, хүнсний бүтээгдэхүүний нэрийг бичнэ.
- Багш тэдний бичсэн хүнсийг харж, шаардлагатай бол хүнсний төрлийг цөөлнө.
- Сурагчид эхлээд баг (эсвэл салаа)-аар ажиллан, дараа нь анги нийтийн хувьд өгөгдлийг бүртгээд, диаграмм байгуулж, дүгнэлт гаргаж ярилцана.

*Ярилцлагыг чиглүүлэх асуулт:*

- Эдгээрийг өдөр бүр идэх нь бидний эрүүл мэндэд хэрэгтэй юу? Яагаад?
- Ямар төрлийн хоол, хүнс эрүүл мэндэд сайн бэ? Яагаад?

**Үйл ажиллагаа 2.** Шим бодис (Суурь, бүрэн дунд боловсролын түвшинд)

Дараах асуултыг дэвшүүлж, сурагчдаар оюуны зураглал хийлгэх (жишээ 1), эсвэл жишээ 2, 3-т үзүүлсэн зураг, хүснэгттэй ажиллуулж болно.

- Хүний бие махбодод ямар шим бодис шаардлагатай байдаг вэ?
- Эдгээр шим бодис хүнсний ямар бүтээгдэхүүнд илүү агуулагддаг вэ?

Жишээ 1




Жишээ 2




Жишээ 3

| Шим бодис | Хүнсний бүтээгдэхүүн |
|---|---|
| Өөх тос | |
| Амин дэм | |
| Нүүрс ус | |
| Уураг | |
| Эслэг | |

Биологийн сурах бичгээс бэлтгэсэн шим бодисын талаарх мэдээллийг сурагчид уншин ялгаж болно. Уг үйл ажиллагаа нь дараагийн үйл ажиллагааг хийхэд хэрэг болно.

**Үйл ажиллагаа 3.** Миний хооллолтын гэр

Алхам 1. Сурагч бүр өчигдөр идсэн хоол, хүнсний бүтээгдэхүүнээ дуртай, дургүй гэлгүйгээр бичнэ. (Сурагчдаар хоёр, гурав гэх мэт хоногийн хувьд бичүүлж болно.)

*Хүснэгт 2. Миний хооллолт*

| Хоол хүнс | Хэмжээ | Хугацаа | | | Шим бодис | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өглөө | Өдөр | Орой | Өөх тос | Амин дэм | Нүүрс ус | Уураг | Эслэг |
| Боорцог | 2 ш | 1 | | | 1 | | 1 | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |

Жич: Бага боловсролын түвшинд "хоол хүнс, хэмжээ, хугацаа" бүхий хүснэгтийг хэрэглээрэй.

Алхам 2. Идсэн хүнсээ дараах төрлөөр ялган нэгтгээрэй.

| Жимс, жимсгэнэ | Хүнсний ногоо | Сүүн бүтээгдэхүүн | Үр тариа, гурил, будаа | Самар, шош буурцаг | Махан бүтээгдэхүүн |
|---|---|---|---|---|---|
|  |  |  |  |  |  |

Эдгээр нь идсэн нийт хүнсний хэдэн хувийг эзэлж байгааг ойролцоогоор гаргаарай.



Алхам 3. Бүтээгдэхүүнүүдийг хамгийн их хувь эзэлж байгааг гэрийн сууринд байрлуулахаас эхлэн гэрийн бусад хэсгүүдэд байрлуулж өөрийн “хоололтын гэр”-ээ барина.

Сүүлийн долоо хоногт идсэн хоол хүнсээ бүртгэвэл таны “хоололтын гэр” ямар болох вэ?

Алхам 4. (Суурь, бүрэн дунд боловсролын түвшинд)

Сурагч бүрт 1 хоног, 7 хоногт иддэг хоол хүнсэнд нь өөх тос, амин дэм, нүүрс ус, уураг, эслэгийн аль нь илүү зонхилж байгааг баримжаагаар олох даалгавар өгнө.

Алхам 5. Сурагчдыг амьдрах нөхцөлөөр нь ялгаварлах, эмзэглэх зэрэг байдал үүсэхээс сэргийлж, сурагчдын гүйцэтгэлээс сонголт хийж, сурагчид зохистой хооллож чадаж байгаа эсэх, түүний шалтгаан зэргийн талаар хэлэлцүүлэг өрнүүлнэ.

**Үйл ажиллагаа 4.** Хоололтын зөвлөмж, тэдгээрийн ялгаа

Алхам 1. “Өнчин цагаан ботго” үлгэрийг унших даалгаврыг урьдчилан өгнө.

Уншаагүй ирсэн сурагчид байж мэдэх тул багш, эсвэл сурагч уншин сануулж болно.

Чиглүүлэх асуулт:

- Ботго яагаад өнчирсөн бэ?
- Ботгонд хэн хэрхэн хандаж байсан бэ?
- Чоно, тас шувуу ботгыг яасан бол? Яагаад?
- Ботго эхтэйгээ хамт нутаг руугаа буцаж чадсан уу? Яагаад?
- Амьдралд үүнтэй төстэй байдал тохиолддог уу? Хариултаа тайлбарлана уу.

Алхам 2. Зургийг ажиглаад, асуултад хариулаарай.

*Зураг 2. Амьтад*



- Зурагт ямар амьтдыг дүрсэлсэн байна вэ?
- Эдгээрээс та нарт таалагдах амьтан байна уу? Яагаад? Сурагчдынхаа саналыг авч, өгөгдлөө бүртгэн, диаграмм байгуулж хараарай.
- Та нар өөр ямар амьтанд хайртай вэ? Яагаад?
- Зурагт үзүүлсэн амьтдын алийг зарим хүмүүс хүнсэндээ хэрэглэдэг вэ? Яагаад?
- Аль нэг амьтныг сонгоод, хүмүүс өөрт нь хэрхэн хандаасай гэж хүсэх бол гэдгийг төсөөлөн бичээрэй.

Алхам 3. Уургийн эх сурвалжийн талаар мэдээлэл цуглуулж, судлаад, зураглал хийнэ. Уураг нь хүний бие махбодод шаардлагатай шим тэжээлийн нэг юм. Уургийг ургамлын болон амьтны гаралтай гэж ангилдаг.

*Хүснэгт 3. Жинд эзлэх уургийн хэмжээ хувиар*

| Ургамлын гаралтай уураг | | | | Амьтны гаралтай уураг | |
|---|---|---|---|---|---|
| Буурцаг 10%-35%  | Буйлс, самар 14%-30%  | Дүпү 13%-16%  | Будаа 8.6%  | Мах 15-20%  | Өндөг 15%  |
| Гурил 13%, гурилан бүтээгдэхүүн 7.8%  | | Хүнсний ногоо: эрдэнэ шиш 13%, төмс 1.7%  | | Сүү 3%, сүүн бүтээгдэхүүн 3%-23%  | |

Алхам 4. Зарим улс орон, байгууллагаас гаргасан хооллолтын зөвлөмж, тэдгээрийн ялгаа, шалтгааны талаар эргэцүүлээд ярилцаарай.

*Зураг 3. Хүмүүсийн хоол хүнсний сонголт*




Эргэцүүлэх асуулт:

- Эдгээр зөвлөмж хоорондоо ямар ялгаатай байна вэ?
- Чиний "хооллолтын гэр" аль зөвлөмжид нийцэхээр байна вэ? Яагаад?
- Ихэнх монголчууд аль зөвлөмжийн дагуу хооллодог вэ? Яагаад?
- Бусад зөвлөмжийн дагуу хооллодог хүн манай улсад байдаг болов уу? Чи яаж мэдэж байгаа вэ?

- Зөвлөмж бүрийн онцлог, түүний шалтгааны талаар чи юу гэж бодож байна вэ? Энэ талаар илүү их мэдээлэл цуглуулан хэлэлцээрэй.
- Яаж хоолловол хүний эрүүл мэнд, дэлхийд ээлтэй гэж бодож байна вэ? Яагаад?

***Багшид***

Үйл ажиллагаа, тэдгээрийн алхмуудыг бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд тохируулан хэрэглэж болно.

Үйл ажиллагаа 4-ийн дүгнэлтэд хооллолтын ялгаатай хэв маягтай хүмүүс байдаг, тэдгээрийн сонголтод хүндэтгэлтэй хандах тухай дурдана.

Хооллолтын ялгаатай хэв маягтай хүмүүс байгаа тул үйл ажиллагаа 2-т хоол хүнсийг хүний бие махбодод хэрэгцээтэй шим бодисоор ялган бичих санааг гаргав.

Суурь, бүрэн дунд боловсролын түвшинд гэр зөвлөмжтэй уялдуулаад тухайн орны хоол хүнсний эх үүсвэр, нөөц, үйлдвэрлэл, гаднаас импортолдог хүнсний бүтээгдэхүүн зэргийн талаар мэдээлэл цуглуулах, боловсруулах, нэгтгэн дүгнэх, мэдээллээ хэрэглэн асуудал шийдвэрлэх даалгаврыг өгч болно.

**Үйл ажиллагаа.** Хүнсний бүтээгдэхүүний шим тэжээлийн мэдээлэл-шошго

**Зорилго:** Эрүүл хүнс сонгохын тулд хүнсний бүтээгдэхүүний шошгыг унших, ойлгох, үнэлэх

Холбогдох агуулга:

| | Мэдлэг | Чадвар | Хандлага |
|---|---|---|---|
| Математик | • Аравтын бутархай<br>• Процент<br>• Хэмжигдэхүүн | • Эерэг бүхэл тоо, аравтын бутархайн тоон утгатай хэмжээг унших, бичих, жиших<br>• Процентийг таних | • Идэвхтэй оролцох<br>• Эерэгээр хувиран өөрчлөгдөх |
| ДИБ | • Хоол хүнс<br>• Эрүүл мэнд | • Хүлээцтэй байх<br>• Хариуцлагатай байх | |

Хэрэглэгдэхүүн: Янз бүрийн бүтээгдэхүүний шошго (жигнэмэг, бялуу, чихэр, боловсруулсан мах, пицца, амттан, будаа гэх мэт)

*Асуулт:* Хүнсний бүтээгдэхүүн худалдан авахдаа юуг анхаарах хэрэгтэй байдаг вэ?

"Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай" Монгол Улсын хуулийн 12.4-т хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулсан байх мэдээллийн тухай заасан байдгийг багш дурдаж болно.

Эрүүл мэнддээ ээлтэй хүнсний бүтээгдэхүүнийг сонгон авахад шошго дахь найрлага, шим тэжээлийн мэдээллийг ойлгон унших чадвар хэрэгтэйг сануулна.

Өөх тос, давс, элсэн чихрийн хэмжээ их, бага байгаа эсэхийг гэрлэн дохиогоор илэрхийлэх аргыг багш сурагчдад тайлбарлана.

(Улаан) - "Их". Тухайн бүтээгдэхүүнийг хааяа л хэрэглэж болно. Ийм орцтой бүтээгдэхүүнийг хэр их хэрэглэж байгаагаа бодох хэрэгтэй.

(Улбар шар) - "Дунд зэрэг". Байж болох ч ногооныг сонговол илүү дээр.

(Ногоон) - "Бага". Эрүүл мэндэд тустай хэмжээ.

*Дадлага ажил.* Сурагчид хосоор ажиллана. Хос бүр хоёр бүтээгдэхүүний шошгыг судалж, үр дүнг "Хоолны шинжээч" ажлын хуудаст бичнэ.

## "Хоолны шинжээч" ажлын хуудас

Шинжээчийн нэр ..................................... Анги ........................

*Хүснэгт 4. 100 г хуурай хүнсэнд агуулагдах шимт бодисын хэмжээг өнгөөр ялгах шалгуур*

| Шим бодисын хэмжээ (Өнгө) | Бага (ногоон) | Дунд (улбар шар) | Их (улаан) |
|---|---|---|---|
| Нийт тос, г | ≤3.0 | 3.1-17.5 | > 17.5 |
| Ханасан тос, г | ≤1.5 | 1.51-5.0 | > 5.0 |
| Чихэр, г | ≤5.0 | 5.0-10.0 | > 10.0 |
| Давс, г | ≤0.3 | 0.31-1.5 | > 1.5 |

*Хүнсний бүтээгдэхүүн 1-ийн нэр:* ...........................................................................

Шошгоос тос, давс, чихрийн хэмжээг харж,

Нийт тос ○ Ханасан тос ○ Элсэн чихэр ○ Давс ○

Энэ бүтээгдэхүүнийг бид хэр их хэрэглэх хэрэгтэй вэ? Яагаад?

..................................................................................................................................

..................................................................................................................................

Хүнсний бүтээгдэхүүн *2*-ын нэр: ...........................................................................

Шошгоос найрлагыг хараарай.

Нийт тос ○ Ханасан тос ○ Элсэн чихэр ○ Давс ○

Энэ бүтээгдэхүүнийг бид хэр их хэрэглэх хэрэгтэй вэ? Яагаад?

..................................................................................................................................

..................................................................................................................................

Багш самбарыг гурван хэсэгт хуваахаар тооцон “Заримдаа идэж болно”, “Тогтмол идэх”, “Маш бага хэрэглэх” гэсэн бичиг байрлуулах буюу бичсэн байна. Сурагчид судалсан бүтээгдэхүүний шошгыг харгалзах баганад байрлуулж, тайлбарлана.

***Багшид***

Энэхүү үйл ажиллагааг бага, суурь, бүрэн дунд боловсролын аль ч түвшинд зохион байгуулж болох ба та бүтээлчээр өөрчлөлт оруулан хэрэглэх боломжтой. Түүнчлэн 1 өдөр, 7 хоног идсэн хүнсний бүтээгдэхүүний шошгыг үнэлэх даалгаврыг өгч болно.

Суурь, бүрэн дунд боловсролын түвшинд Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/221 дүгээр тушаалаар батлагдсан “Хүнсний сав боодлын нүүрэн хэсэгт шим тэжээлийн мэдээлэл байршуулах заавар”-ыг хэрэглэн хэмжээ нь 100 г-аас ялгаатай бүтээгдэхүүний 100 г-д агуулагдах тос, чихэр, давсыг тооцох даалгавар өгч болно.

**Үйл ажиллагаа.** Хоол хүнс, өлсгөлөн

**Зорилго:** Нөөцийн хуваарилалт, орон нутаг, дэлхийн түвшин дэх тэгш бус, тэнцвэргүй хуваарилалт, энэ нь зөрчилд хүргэх нэг шалтгаан болох зэргийн талаар ойлгох

Холбогдох агуулга:

| | Мэдлэг | Чадвар | Хандлага |
|---|---|---|---|
| Математик | • Өгөгдөлтэй ажиллах | • Мэдээллийг унших, ойлгох, хэрэглэх<br>• Хүснэгт, диаграммыг унших, ойлгох, хэрэглэх | • Идэвхтэй оролцох<br>• Нинжин сэтгэлтэй байх |
| ДИБ | • Хоол хүнс<br>• Ядуурал | • Хүлээцтэй байх<br>• Ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах<br>• Нээлттэй байх | |

Хэрэглэгдэхүүн: 1-6тоотой дугаар, 6 ширхэг цаасан таваг, 30 ширхэг жигнэмэгийн дүрс (суралцагчдын идэх дуртай өөр зүйлийн дүрс байж болно), цаас, харандаа, үзэг, өлсгөлөнгийн зураглал, боломжтой бол Дэлхийн газрын зураг

Алхам 1. Багш хүснэгтэд заасны дагуу нийт сурагчийн тоог харгалзан нэг багт байх сурагчийн тоог тооцоолон 1-6 хүртэлх тоог бэлтгэнэ. Сурагчдаар 1-6 хүртэлх тоог сугалуулж, сугалсан дугаартай ширээний дэргэд ялгарч зогсохыг хэлнэ. Ширээ бүрд дараах хүснэгтэд харуулсан тооны жигнэмэгтэй тавгийг тавьсан байна.



*Хүснэгт 5. Багуудад хуваарилах жигнэмэгийн тоо*

| Ширээ /багийн/ дугаар | Тив | Жигнэмэгийн тоо | Багийн гишүүдийн тоо /нийт суралцагчдын эзлэх хувь/ |
|---|---|---|---|
| 1 | Африк | 1 | 15 |
| 2 | Ази | 4 | 55 |
| 3 | Европ | 9 | 10 |
| 4 | Латин Америк | 1 | 10 |
| 5 | Хойд Америк | 10 | 5 |
| 6 | Австрали | 5 | 5 |

Багш баг бүрд жигнэмэг өгсөн байгааг хэлээд, 2 минутын турш сурагчдыг ажиглана.

Алхам 2. Хэлэлцүүлэг өрнүүлнэ. Чиглүүлэх асуулт:

- Өөрийн болон бусдын жигнэмэгийн тоог хараад танд ямар мэдрэмж төрсөн бэ?
- Жигнэмэгээ багийн гишүүддээ хэрхэн хуваарилсан бэ?
- Жигнэмэг нэмж авах, эсвэл өгөхийн тулд ямар нэгэн зүйл хийсэн үү?
- Бусад багийн зүгээс та нарт хэрхэн хандсан бэ?
- Энэхүү хуваарилалт шударга байна уу? Яагаад? Яавал шударга болох вэ?
- Зургаан ширээ юуг төлөөлж байгаа вэ? гэх мэт.

Алхам 3. Ширээ бүр нэг тивийг төлөөлж байгааг сурагчдад хэлнэ. Багаараа ярилцаад тэд аль тивийг төлөөлж байгааг таамаглахыг хүснэ. Дэлхийн газрын зураг байгаа тохиолдолд сурагчид төлөөлж буй тив дээр ширээний дугаарыг байрлуулж болно. Сурагчид таамаглалаа хэлсний дараа багш зөв хариултыг хэлэх буюу харуулна.

Багш хоол хүнсний хангамж, тэгш бус хуваарилалттай уялдуулж урьдчилан сонгосон зураг, мэдээллийн талаар сурагчидтай ярилцана. Тухайлбал,

*Зураг 4. Хоол хүнсний тэгш бус хэрэглээний нөлөө*





Дэлхийд 870 сая хүн хүнс тэжээлээр хангагддаг. Энэ нь өдөр бүр найман хүний нэг нь өлсгөлөн унтдаг гэсэн үг. 2008 онд 20 буюу түүнээс дээш насны 1.4 тэрбумаас дээш тооны насанд хүрэгчид жингийн илүүдэлтэй, 3 хүн тутмын 1 нь хэт илүүдэл жинтэй байв.

*Эх сурвалж: НҮБ-ын ХХГБ-ын 2006-2008 оны статистикийн дундаж*

Алхам 4. Дэлхийн "өлсгөлөнгийн зураглал"-ыг сурагчдад харуулж ярилцана.

*Чиглүүлэх асуулт:*

- Улс орнуудын өлсгөлөнгийн үзүүлэлт ямар байна вэ? Хамгийн бага үзүүлэлттэй нь ямар орнууд байна вэ? Хамгийн өндөр үзүүлэлттэй ямар орнууд байна вэ?
- Монгол Улсын өлсгөлөнгийн үзүүлэлт ямар байна вэ?
- Ийм үзүүлэлттэй болоход нөлөөлсөн шалтгаан нь юу байж болох вэ?
- Өлсгөлөнг арилгах боломж манай оронд байгаа болов уу? Үүнд чи ямар хувь нэмэр оруулж чадах вэ?
- Хүнс тэжээл нь улс орнууд зөрчилдөх шалтгаан болох уу? Яагаад? Тэдгээрийг шийдвэрлэх ямар боломжууд байж болох вэ?

*Зураг 5. Дэлхийн "өлсгөлөнгийн зураглал"*




*https://www.wfp.org/content/hunger-map-2015*

***Багшид***

Бага, суурь, бүрэн дунд боловсролын аль түвшинд зохион байгуулахаас хамаарч өгөх мэдээлэл, чиглүүлэх асуултыг өөрчлөөрэй.

Үйл ажиллагааг нэгтгэн дүгнэхэд хэрэг болох мэдээллийг бусад эх сурвалжаас олох буюу нэмэлт үйл төлөвлөх зэргээр бүтээлчээр ажиллаарай.

Жишээлбэл,

Дэлхийн хүнсний хөтөлбөр (WFP)-өөс гаргадаг "өлсгөлөнгийн зураглал"-д Монгол Улсыг хүн амын 20.5 хувь хүнс хоолны асуудалтай орны хэсэгт оруулсны үндэслэл нь манайд ядуурлын хамралт 29.8 хувь, хүн амын ядуу, нэн ядуу хэсгийн дотор хүнс хоолны хомсдол бодитой оршиж байгаатай холбоотой байна.[10]

Үндэсний статистикийн хорооны 2012 оны "Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаагаар Монгол Улсын нийт хүн амын 27,4 хувь, хөдөөгийн хүн амын 35,5 хувь ядуу амьдарч байна. Энэ нь нийт хүн амын 30 шахам хувь хоногийн хоолоор авах шаардлагатай илчлэг, шим тэжээлийн бодисыг авч чадахгүй, өдөр тутмын наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй ядуу амьдарч байгааг харуулна[10].

*10 Дамдинсүрэн,Л. (201). Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын төлөв байдал. Илтгэл. "Үндэсний аюулгүй байдал 25" сэдэвт онол практикийн бага хурал.*

*11 НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл. (2015). Хүнсний эрхийн хэрэгжилт. Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг. 22 дугаар хуралдаан. Монгол Улс.*

## *Ашигласан материал*:


БСШУЯ. (2003). Бага, дунд боловсролын стандартын зөвлөмж. Улаанбаатар: Экимто ХХК

БСШУЯ. (2014). Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Улаанбаатар

БСШУЯ. (2015). Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Улаанбаатар

БСШУЯ. (2016). Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Математик. Улаанбаатар

Жишсэн дундаж хүний илчлэг, шимт бодисын хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралт

Монгол Улсын Үндсэн хууль, 1992

Монгол Улсын Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, 2012

Орлуулан хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний жагсаалт. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалын 5 дугаар хавсралт

Хүнсний сав боодлын нүүрэн хэсэгт шим тэжээлийн мэдээлэл байршуулах заавар. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/221 дүгээр тушаалын хавсралт

Энхтогтох, А. ба бусад. (2017). Биологи VII. Сурах бичиг. Улаанбаатар

Lea L.Espallardo. (2017). Transformative Learning methods for GCED. Presentation.

Concern Worldwide. (2013). One in Eight. A Senior Primary Resource about Hunger, Food and our Role in the World. Published by Concern Worldwide

UNESCO MGIEP. (2017). Textbooks for Sustainable Development. A Guide to Embedding. Published by UNESCO MGIEP

http://www.nsc.gov.mn/?q=en/node/347

http://bhrpower.mn/

https://www.healthyschoollunches.org

https://www.hsph.harvard.edu/nutritionsource/healthy-eating-plate/translations/mongolian/

http://www.naturallifeenergy.com/vegan-food-pyramid-free-infographic/

https://www.PCRM.org

https://www.pinterest.pt

https://thehimalayantimes.com/health/kids-and-obesity

https://www.wfp.org/content/hunger-map-2015

## СУРГАЛТЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАГ

**Зорилго:** Бага боловсролын сургалтыг дэмжих үйл ажиллагааны цагийн агуулга арга зүйгээр дамжуулан дэлхийн иргэний чадварыг хөгжүүлэх

**Мэдээлэл**: Сургалтыг дэмжих үйл ажиллагаа нь цөм хөтөлбөрийн зорилго, зорилтын хэрэгжилт, хичээл судлагдахуунаар эзэмших чадварын хөгжлийг дэмжинэ[1] гэж бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрт томьёолсон бөгөөд сургалтыг дэмжих үйл ажиллагаа гэдгийн дор иргэний боловсрол, амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа, хичээлээс гадуурх үйл ажиллагааг ойлгоно гэж тодорхойлсон байна.




"Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа" нь суралцагчид хичээл тус бүрээр эзэмшсэн мэдлэг, чадвараа асуудал дэвшүүлэн шийдвэрлэхэд хэрэглэх ба дараах сурах арга барил, чадвар эзэмших үйл ажиллагааг багшийн дэмжлэгтэйгээр зохион байгуулахыг зөвлөмжилсөн. Үүнд:

1. Суралцагч бодит үйл ажиллагаанд оролцох явцдаа эрэл хайгуул хийх, асуудал олж харах, эргэцүүлэн бодох, илүү сайнаар шийдвэрлэх арга барил эзэмшинэ.
2. Суралцагч эрэл хайгуулын явцад бүтээлчээр хамтран ажиллах, өөрийн амьдрах арга ухааныг эргэцүүлэн бодох, суралцах хүсэл эрмэлзэл, бие даан ажиллах, суралцах, нийгэм, амьдралын өөрчлөлтөд зохицон амьдрах чадварт суралцана.

Эндээс харахад бодит үйл ажиллагаанд оролцонгоо асуудлыг олж харах, эргэцүүлэн бодох, шийдвэрлэх арга барилд суралцах, бүтээлчээр хамтран ажиллах чадварыг төлөвшүүлэхэд чиглэсэн болох нь харагдаж байна.

Харин ямар агуулгаар, агуулгаа хэрхэн сонгож, ямар үе шатаар, ямар арга зүйгээр зохион байгуулах вэ гэх мэтээр хичээл судлагдахуунаас ялгагдах ялгаа бий. Агуулгын сонголтыг сургууль, бүс нутаг, улс орон, дэлхийн хэмжээнд сонирхсон, тулгамдсан, хэрэгцээтэй агуулгыг хүүхэд, багш, сургууль өөрөө сонгох боломжийг цөм хөтөлбөрт оруулж өгсөн нь сургууль, орон нутгийн бие даасан байдлыг дэмжин мэдлэг мэдээллийг ашиглан шүүмжлэлтэйгээр асуудлыг шийдвэрлэх чадвартай, бусдыг ойлгож бусадтай хамтран хүндэтгэлтэй харьцах чадвартай, хүлээсэн үүргээ биелүүлэх хүсэл, зорилготой иргэнийг бий болгох онцлогтой цаг юм.

Бага боловсролын цөм хөтөлбөрт амьдрах чадварт суралцах цагаар эзэмших тусгай чадварууд болон хүүхдийн хүсэл сонирхолд тулгуурлан хэрэгцээтэй, тулгамдсан, сонирхсон агуулгаа сонгох уян хатан агуулгын хүрээг гаргасны үндэслэн дараах байдлаар суралцахуйн зорилтыг томъёолсон байдаг бөгөөд энэ нь дэлхийн иргэний боловсролын суралцахуйн зорилт, чадамжтай шууд холбогдож байна.

1 *Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр, Уб, ху-22*

## Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа

<table>
<tr><th colspan="2">Эрэл хайгуул хийх чадварт суралцах</th><th rowspan="2">Дэлхийн иргэний чадамж</th></tr>
<tr><th>Алхам</th><th>Арга барил</th></tr>
<tr><td>Асуудлыг сонгох буюу сэдвийг сонгох</td><td>Сургуулийн зорилго, гэр бүл, хамт олон, орон нутгийн онцлогтой уялдуулан хүүхдийн хэрэгцээ, тулгамдсан асуудлын хүрээнд сэдвээ сонгох</td><td rowspan="6">- Асуудлыг олж харах<br>- Бусдын үзэл бодлыг хүндэтгэн сонсох<br>- Өөрийн үзэл бодлыг зүй зохистойгоор илэрхийлэх<br>- Асуудлыг шийдэх аргын эерэг, сөрөг талыг тооцох<br>- Асуудлыг шийдэх арга замыг сонгох<br>- Асуудлыг шийдэх санал гаргах<br>- Бусдын байр сууринд өөрийгөө тавих<br>- Аливаа юмс үзэгдлийн харилцан холбоо хамаарлыг эрж хайж олохыг эрмэлзэх<br>- Аливаа асуудалд саад бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэх<br>- Зөрчлийн эх үндэс, шалтгааныг илрүүлэх<br>- Боломжит шийдлүүдийг эрэлхийлэх<br>- Орон нутаг, үндэстэн, бүс нутаг, дэлхий дахины асуудалд шийдэл хайх, турших үзэх<br>- Хүрээлэн буй орчноо мэдрэх<br>- Хариуцлагатай байх<br>- Оролцогч байх</td></tr>
<tr><td>Мэдээлэл цуглуулах</td><td>Асуудал, сэдвийн хүрээнд боломжтой эх сурвалжуудаас бодитой харж, мэдэрч суралцах үйл ажиллагаагаар мэдээлэл цуглуулах</td></tr>
<tr><td>Эмхлэн анализ хийх, эрэмбэлэх</td><td>Цуглуулсан мэдээллийг эмхлэн боловсруулалт хийж, асуудлыг эрэмбэлэх</td></tr>
<tr><td>Сонголтын үндэслэлээ тайлбарлах</td><td>Яагаад сонгосон учир шалтгаан, ач холбогдлыг тодорхой тайлбарлах</td></tr>
<tr><td>Дахин төлөвлөлт, сайжруулалт</td><td>Эрэл хайгуул хийх явцад шинээр үүсэн бий болсон нөхцөл байдал, мэдээллийн дагуу дахин төлөвлөлт хийж, сайжруулах</td></tr>
<tr><td>Нэгтгэх , дүгнэх, тайлагнах, дараагийн шинэ санаа гарах</td><td>Үйл ажиллагааны явцаа нэгтгэн дүгнэж бусдад ойлгомжтой тайлагнана. Таамаглал дэвшүүлсэн байдал, эрэл хайгуулын явцад хэрхэн батлагдсан болон өөрчлөгдсөнийг тодорхой жишээгээр гаргана.Нэг асуудлын шийдлийн үйл явц дараагийн асуудал, сэдвийн эхлэл болж дахин давтагдах зарчмаар алхмууд давтагдана.</td></tr>
</table>

Энэ цагийн онцлог нь бодит үйл ажиллагаанд оролцох, эрэл хайгуул хийн асуудлыг олж харах, хувь хүн, хамт олон, байгууллага, орон нутгийн хүрээнд хамтарч ажиллан, өөрийн амьдрах арга ухаан, суралцах үйлээ эргэцүүлэн шийдвэр гаргах чадварт сургах явдал юм.

Тайлбар

1. Нэг зүйлийн талаар зөвхөн ганц зүйлийг үзнэ гэж байдаггүй. Мөн нэг л эх сурвалжаас мэдээлэл цуглуулах нь хангалтгүй. Хэд хэдэн мэдээллийн эх сурвалжаас янз бүрийн өнцгөөс харсан мэдээлэл цуглуулснаар судалгааны үр дүн баяждаг. Үүнд үндэслэн боловсруулсан өөрийн санал ч гэсэн олон талаас нь харсан шинж чанартай болдог.
2. Нэг сэдвийн тухайд ямар эх сурвалжаас авсан, бусдаас юугаараа ялгаатай зэргийг харьцуулна. Дараа нь аль мэдээллийг ашиглавал өөрийн хэлэх гэсэн зүйлтэй илүү ойр холбогдох вэ гэдгийг нягтлуулна. Хэд хэдийг судлуулан, харьцуулах замаар тайлагнасан ч болно.
3. Мэдээллийн эх сурвалжуудад нэвтэрхий толь, ном, товхимол, сонин, интернэт зэрэг олон зүйл орно. Ярилцлага хийхэд зөвхөн нэг хүн бус хэд хэдэн хүнээс бас авч болно. Хүснэгт ашиглан ямар эх сурвалжаас авсан мэдээлэл вэ гэдгийг цэгцлэн, ангилснаар задлан шинжлэх, дүгнэлт гарган саналаа бичихэд амар болдог. Цаашлаад анги дэвшээд ирэхээрээ мэдээллийн эх сурвалжаасаа хамааран мэдээлэл хэрхэн өөрчлөгдсөнийг олж хардаг чадварыг эзэмшихэд суралцдаг.

## Дүгнэлт

Амьдрах чадварт суралцах цагийн мэдээлэл цуглуулах, мэдээллээ эмхэлж цэгцлэх үе шатанд багшийн арга зүй чухал байдаг. Тухайн асуудлын талаар багш урьдчилан бодит орчинд нь очиж судалгаа хийн танилцаж мэдээлэл цуглуулах, мэдээллийн хэмжээг тогтоох, мэдээлэл цуглуулах аргаа сонгох зэргийг өөрөө биечлэн хийж үзсэн байна. АЧСҮАЦ-ийн арга зүй нь багш өөрөө сэдвийг зааж хүүхдүүдээр шийдүүлэх биш харин хүүхдүүдийн сэдэл тэмүүллийг төрүүлж, бид чадах юм байна, миний бодож байснаас ийм зүйл нь ижил ийм зүйл нь өөр байлаа, дахиад хийж үзэх юмсан гэсэн бодол эргэцүүлэл, сэдэл тэмүүлэл, итгэл хандлага төрүүлж чадахуйц байхад анхаарах нь чухал байдаг.

Дэлхийн иргэний боловсрол танин мэдэхүй,
нийгэм сэтгэл хөдлөл, зан байдлын үр дүн



Эхлээд хувь хүн бүр бусдыг ойлгох сэтгэлтэй, үүрэг хариуцлагаа мэдрэх, дараа нь аливаа асуудлын учир шалтгааныг танин мэдэж зөв зохистой шийдвэр гарган, нийгмийн олон талт үйл ажиллагаанд идэвхтэй оролцогч байж энэ нь гэр бүл, найз нөхөд, анги, хамт олон,, сургууль, орон нутаг, улс орон, үндэстэн ястан, дэлхий нийтээр гэж хүрээгээ тэлэн давтамжтай эргэхдээ түвшин ахиж бид нэг дэлхий дээр амьдарч байгаа дэлхийн иргэн, миний оролцоо, миний үйл хэрэг, миний үзэл хандлага, миний үнэт зүйлээс маш олон зүйл хамаарч байдаг гэдгийг ойлгох нь дэлхийн иргэний боловсролын гол зорилго болно. Үүнийг багш бүр эхлээд өөртөө бий болгох, хэрэгжүүлэхийг эрмэлзэх хэрэгтэй.

**Дэлхийн иргэний ёс суртахууны үнэт зүйл, хандлагад хүрэх энгийн алхмууд**

Хүний оршин байхуйн нийтлэг шинжүүд, бусдыг ойлгох, харилцах, харилцан адилгүй онцлог байдалд хүндэтгэлтэй хандан бусдын байр сууринд өөрийгөө тавьж үзэх, хүлээсэн үүргээ биелүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх чадварыг хөгжүүлэх улмаар шүүмжлэлт сэтгэлгээ, шүүмжлэлтэй дүн шинжилгээ хийх замаар хариуцлага болон үнэт зүйлээ хуваалцах чадвартай иргэнийг төлөвшүүлэх нь чухал. Энэ алхам нь эхлээд зөв бодлыг төрүүлэх зөв бодлоос зөв үйлдэл гарах, зөв үйлдэл нь дахин давтагдаж зөв зуршил, хэвшил, дадал болж улмаар зөв хандлага, үнэт зүйл сууж эхэлнэ. Урт удаан хугацаанд дахин давтагдаж итгэл үнэмшил бий болж байж үнэт зүйл, өөрийн гэсэн үзэл хандлагатай болно. Үүнийг энгийн байдлаар ойлгуулахын тулд зураглан харуулбал:




Нийгмийн бүлэг, түүнд харьяалагдаж буй хувь хүмүүс, бүлэг хоорондын холбоо, ялгаатай байдалд хүндэтгэлтэй, зохистой хандах, ёс суртахууны хариуцлагатай зан төлөв бүрдүүлэх, үүрэг хариуцлагаа ойлгож ухамсарлах гэх мэтээр дэлхийн иргэний боловсролын сэдвийн хүрээ нь сургалтын дэмжих цагийн зорилго, агуулгын хүрээтэй хамааралтай байгаа нь харагдаж байна.

Дэлхийн иргэний ёс суртахууны хариуцлагатай зан төлөвийг бүрдүүлэхэд багшийн анхаарах зүйл




## ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ ЦАГ

**Зорилго**: Бага боловсролын иргэний боловсрол цагийн агуулга арга зүйгээр дамжуулан дэлхийн иргэний чадварыг хөгжүүлэх нь




**Зүрхнийхээ үгийг сонс**

Хэнд ч мөрөөдлийг тань хулгайлахыг бүү зөвшөөр.
Ямар ч үе байсан хамаагүй зүрхнийхээ үгийг чагна.

### Зүрхнийхээ үгийг сонс

Хүүг дунд ангид байхад нь багш нь: “Том болоод юу хийх, ямар мэргэжилтэй болохыг хүсч байгаа талаар зохион бичлэг бичиж ир” гэж гэрийн даалгавар өгчээ. Хүү шөнөжингөө сууж нэгэн өдөр адууны аж ахуйтай болох тухай 7 хуудас дүүрэн зохион бичлэг бичжээ. Мөрөөдлийнхөө бүр нарийн жижиг хэсгүүдийг ч бичсэн байлаа. Тэр ч бүү хэл 200 га талбайтай аж ахуйн байр, хашаа хороо, морьд давхих талбайг ч зурсан байлаа. Маргааш өглөө зүрхнийхээ үгтэй 7 хуудас зохион бичлэгээ багшдаа өглөө. Хоёр хоногийн дараа багш зохион бичлэгүүдийг тарааж өгөхөд түүний цаасан дээр томоос том “ТЭГ” бас “Хичээлийн дараа надтай уулз” гэж бичсэн байв.

- Хүү багшаасаа “Яагаад би тэг авч байгаа юм бэ? гэж асуулаа.

- Багш “Чиний насанд ийм мөрөөдөл тохирохгүй, бодит байдалтай нийцэхгүй байна”, “Чамд мөнгө байхгүй, чи тариачин айлын хүү шүү дээ. Адууны аж ахуйтай болоход чамд маш их хөрөнгө мөнгө шаардлагатай. Эхлээд чи газар авна. Дараа нь сайн хурдан удмын адуу авах хэрэгтэй. Үүнийг хийнэ гэдэг чинь боломжгүй. Хэрэв биелэгдэх бодитой зорилго шинээр бичиж ирвэл чиний дүнг өөрчилж болох юм” гэлээ.

Хүү гэртээ ирээд баахан бодсоны эцэст аавдаа хэлэв. Тэгтэл аав нь: “За хүү минь, үүнд чи өөрөө шийдвэр гарга. Энэ бол чиний хувьд маш чухал сонголт” гэлээ. Хүү хэдэн өдөр бодсоны эцэст зохион бичлэгтээ ямар ч өөрчлөлт оруулалгүй багшдаа өгөнгөө “Та надад тавьсан дүнгээ битгий өөрчлөөрэй. Би ч бас мөрөөдлөө өөрчлөхгүй... “ гэв. Одоо тэр 200 га газартай, адууны аж ахуйтай бас тансаг харшид амьдарч байна. Олон жилийн өмнө бичсэн тэр зохион бичлэг нь хойморын хананд нь өлгөөстэй...

### Дүгнэлт

Иргэний боловсрол цагийн гол зорилго нь хүүхдийн сэтгэлд сайн сайхан зан чанар, болох болохгүй зүйлийг ойлгуулах, зөв зан чанар, дадал хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн өөрөөр нь ухааруулж, эргэцүүлэн бодуулж өөрийн гэсэн шийдвэр гаргахад чиглэдэг. Эхийн гол санаа буюу агуулгыг сайн ойлгоогүй бол зорилгодоо хүрэх мэдрэмж, бодол эргэцүүллийг гүнзгийрүүлэн өрнүүлэх боломжгүй юм. Дараагийн шатанд зорилгоо болгосон ёс суртахууны үнэт зүйлийг хүүхэд өөрийн болгон хүлээн авах үйл явц юм. Өөрөөр хэлбэл эхээс гүнзгий мэдэрч сайн ойлгосон ёс суртахууны үнэт зүйл, сэтгэл хөдлөл, ухаарлаа өөрийнхөө амьдрал, туршлагаар өргөжүүлэн эргэцүүлэх, ярилцах үе шат гэж ойлгож болно. Суралцагчдыг зорилгоо болгож байгаа ёс суртахууны үнэт зүйлийг өргөжүүлэн гүнзгий утгаар нь эргэцүүлэн бодоход багшийн чиглүүлэг буюу асуулт их чухал.

## НИЙГМИЙН УХААН

***Багш та:*** *Асуултын карт ашиглах арга*

Асуултаа цаасан дээр бичиж, ангидаа байрлуулсан хайрцаг руу хийхийг суралцагчдад хэлж өгөөрэй. Завсарлагааны үеэр бүрээр хайрцгийг шалгаж, хоёр асуулт сонгож хариулт өгнө. Суралцагчдын өмнө асуулт тавьж чадахгүй байгаа суралцагчдыг зоригжуулж, урам өгөх зорилготой.

1974 онд Бангладешт сая гаруй хүн өлсгөлөнгийн улмаас амь насаа алдахад Эдийн засгийн ухааны доктор Юунус ядуу тосгодыг өөрийн биеэр явж, үзэж өөрийн зүгээс яаж тусалж, юу хийж болохыг олж мэдэхээр шийдэв. Зам дагуу хулсны мөчрөөр сагс нэхэж буй Бегум гэгч бүсгүйтэй таарав. Түүнтэй ярилцах зуур сагсыг худалдаж авдаг баян бизнесмэнээс хулс худалдаж авах мөнгөө зээлж авдгийг олж мэдэв. Бизнесмэн мөнгө зээлдүүлснийхээ төлөө доллар тутам 10 центээр нэмэгдэх өндөр хүү тооцож мөнгө зээлүүлдэг ажээ. Нэг сагснаас ердөө хоёр центийн ашиг олох бөгөөд бизнесмэн бүх ашгийг авч үлддэг ажээ. Бүсгүйд ердөө 12 доллартай бол хүүтэй мөнгө зээлэхгүйгээр илүү ашиг олж гэр бүлээ тэжээх боломжтой байлаа.

Хэрвээ Юунусын оронд та байсан бол хэрхэн туслах вэ?

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

*Эх сурвалж: Эрхэд суурилсан хандлага УБ., 2016 17 дугаар тал*

### Ёс суртахуунлагаар ойлгох чадварыг хөгжүүлэх даалгавар

1. Тохиолдлыг уншаад танд ямар сэтгэгдэл төрснөө бичээрэй.

2. Өлссөн, зовсон хүмүүст туслахад хүний ямар зан чанар чухал гэж та үзэж байна вэ?

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

3. Хүнд туслахын ач тус сэдвээр эргэцүүлэмж бичээрэй.

..........................................................................................................................................

Тэрээр идэх хоолгүй өлсөж үхэж байсан олон хүнд ингэж тусалсан юм. Юунусын байгуулсан Грамеен Банк Бангладешийн 36000 тосгодод үйлчилж, олон мянган гэр бүлийг идэх хоолтой болгожээ.

## Хүрээлэн буй орчиндоо хүндэтгэлтэй хандах чадварыг хөгжүүлэх жишиг даалгавар

| | |
|---|---|
|  “Өлсөж буй Судан охин” |  “Өнчин унага аварч буй хүү” |

1. Дээрх зурагт юу, юу байгааг нэрлээрэй.

| | |
|---|---|
| Зураг 1. | |
| Зураг 2. | |

2. Зураг дээр буй охин, унаганд аюул учруулж болох зүйлүүдийг тоочин бичээрэй

| Охин | Унага |
|---|---|
| - | - |

## Зөрчилдөөнийг шийдвэрлэх чадварыг хөгжүүлэх даалгавар




*Тайлбар:* Судан улсад болж буй их өлсгөлөнгийн үеэр зурагчин К.Картер “Өлсөж буй Судан охин” нэртэй хүний ертөнцийн сэтгэл эмзэглүүлэм дүр төрхийг дурандаа буулгажээ. (1994 он)

2. Зураг дээрх нөхцөл байдал яагаад үүссэн бэ?

| А. Хэм хэмжээг мөрдөхгүй байгаа (Үндэс нь юу вэ?) | Б. Төр засгийн тогтворгүй байдал (Үндэс нь юу вэ?) | В. Байгалийн хүчин зүйл (Үндэс нь юу вэ?) |
|---|---|---|
| 1. Хүнсний хомсдол үүсэх болсон гол шалтгаан нь юу вэ? (Нөлөөлсөн хүчин зүйлүүдээс аль нэгийг нь сонгон хоол, хүнстэй холбон тайлбарлана уу.) Зэвсэгт мөргөлдөөн, Эмх замбараагүй байдал, Ган гачиг, Газар хөдлөл .... | | |

Зураг дээрх үйл явдал хэрхэн өрнөсөн бол таамаглаж бичээрэй.

............................................................................................................................................

............................................................................................................................................

2. Дээрх зураг дээр хүүхдийн ямар эрхийг зөрчсөн бэ?

.......................................................................................................................................

.......................................................................................................................................

3. Одоо ийм нөхцөл байдал тулгарвал дэлхий даяар ямар арга хэмжээ авах бол .....(Чи юу гэж бодож байна вэ?)

| А. Өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүст туслах ... | Б. Зэвсэгт мөргөлдөөнийг зогсоох ... | В. Иргэдийг нүүлгэн шилжүүлэх ... | Г. Ажилгүйдэл ... |
|---|---|---|---|

4. Өлсгөлөн бидэнд хамааралтай юу?
   - Цөлжилт хуурайшилт ..... (Хоол хүнсний хүрэлцээ хамгамжид хэрхэн нөлөөлөх вэ?)
   - Ган, зуд .....(Хоол хүнсний хүрэлцээ хамгамжид хэрхэн нөлөөлөх вэ?) г.м

5. Үүсч буй нөхцөл байдал, эрсдлийг бид хэрхэн даван туулах вэ?
   - Өөрийгөө болон бусдыг хүндэтгэх
   - Байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах г.м

***Багш та:*** Монголчуудын амин чанар бол хүн, амьтан, байгалийг адил тэгшээр хүндэтгэн дээдлэх үзэл болохыг ярилцаарай.

## Тохиолдол

Болдоо хүү зудтай жилийн хаврын нэгэн өдөр  хонио хариулж явлаа. Бутны цаана нэг жижиг амьтан нүдэнд  зэрвэс хөдлөх нь үзэгдэв. Болд гүйж очвол эхээсээ төөрч, хаягдсан нялх унага байлаа. Ойр орчиндоо эхийг нь эрж, адуу мал хайсан боловч түүний нүдэнд харагдах зүйл үгүй байв. Болдоо ийм нялх амьтныг орхиод явбал өлсөж, цангаж үхэх байх гэж бодов. Гэвч гэртээ аваад очиход энэ нялх амьтныг юугаар хооллох билээ.

1. Унага яагаад өлсөж, цангаж үхэх аюул тулгарсан бэ?
2. Болдоо цаашид ямар шийдвэр гаргах нь зөв бэ? Дараах шийдлүүдийг гаргана.
   - Болдоо өлсөж цангасан унагыг гэртээ авч тэжээх нь зөв......
   - Энэ унагыг эзэн нь олоод тэжээх учир орхих хэрэгтэй...
   - Эх нь буцаж ирэх учир өлсөж үхэхгүй орхиод явах нь оновчтой ...
3. Дээрх шийдлүүдийн эерэг, сөрөг талыг бичнэ үү.

| | Эерэг тал | Сөрөг тал |
|---|---|---|
| 1. | | |
| 2. | | |
| 3. | | |

4. Та дээрх шийдлүүдээс сонгосон шалтгаанаа тайлбарлаарай.

.......................................................................................................................................

5. Чамд өөр шийдэл байна уу? Бусадтайгаа хуваалцаарай.

.......................................................................................................................................

# БИОЛОГИ

## БАГА АНГИ

**Зорилго:** Хүн төрлөхтний хоол хүнсний талаар байгалийн ухааны хичээлийн агуулгаар дамжуулан сурагчдад дэлхийн иргэний боловсролын чадваруудыг эзэмшүүлэхэд чиглэнэ.

**Түлхүүр үгс:** ард түмэн, хоол хүнс, хоол хүнсний найрлага, зохистой хэрэглээ, аюулгүй байдал

**Анги зохион байгуулалтын хэлбэр:** Бага ангийн суралцагчдыг багт хуваах аргууд

1. Эвлүүлэг 2.Төрсөн өдөр 3.Хөзөр 4.Дугаар сугалах 5.Чихрийн өнгө 6.Тараах материал ашиглах

**Багаар зохион байгуулахад анхаарах зүйлс:** Багийн дүрэм журмаа зохиож багийн гишүүдийг үйл ажиллагааг тодорхой болгох, үнэлэх аргаа суралцагчидтайгаа хамтран зохиох, багаар зохион байгуулаад ямар нэгэн өрсөлдөх сэтгэлгээг өрнүүлэхгүй, даалгаврыг бүтээлчээр гүйцэтгүүлэхэд чиглүүлнэ.

**Хэрэглэгдэхүүн:** Тус хичээлийн агуулгаар 4 сэдвийн хүрээнд даалгавар өгөгдсөн тул даалгавар тус бүрт өгөгдсөн зургуудыг олшруулах, тарааж өгөх материал болгон бэлтгэхээс гадна үзүүлэн, тохиолдлууд /бодит түүх, баримт, видео бичлэг, сурвалжлага, ярилцлага,туршлага болон туршилт явуулахад шаардлагатай шилэн аяга, давс, өндөг зэргийг урьдчилан бэлтгэнэ.

**Арга зүй:** Суралцагчдын хуримтлуулсан туршлага,танин мэдэхүйн хөгжлийн түвшинд тохируулан аргыг сонгоно. Суралцагчдын насны онцлогтой уялдуулан сургалтын аргын бүх хэлбэрүүдийг хослуулан хэрэглэх боломжтой.Тухайлбал:Суралцагчдын оролцоонд тулгуурласан, харилцан яриа, үзүүлэн таниулах, унших материал судлуулах, турших, тоглоомын арга, дүрд тоглох, эвлүүлгийн арга, булангийн арга, хэлэлцүүлэг, мэтгэлцээн гэх мэт идэвхтэй сургалтын аргуудыг ашиглах

**Үнэлгээ:** Тухайн хичээлээр эзэмших мэдлэг ойлголтоос гадна дэлхийн иргэний чадваруудтай холбон үнэлэхэд чиглэгдэнэ. Сурагчдад "Үнэлгээний хуудас"-ыг тараан өгч өөрийн үнэлгээ хийлгэнэ. Энэхүү үнэлгээний хуудас нь сурагчдын дэлхийн иргэний боловсролын чадваруудыг үнэлэхэд чиглэнэ.

| Түвшин | Судлаг-дахуун | Биологи | Газарзүй | Физик | Хими |
|---|---|---|---|---|---|
| Бага | Суралцахуйн зорилт | Бидний нэг өдрийн хоол хүнс, Биеийн бүтцийн хэсгүүд, хооллох үеийн эрүүл ахуйн энгийн дадал, хэвшил, сургуулийн үдийн цай, хоолны үеийн дэг соёл, өсөлтөнд нөлөөлөх хүчин зүйлүүдийг нэрлэх, амьд биеийн хооллох хэрэгцээ, улирлын ялгаа нь хоололтонд нөлөөлдөг эсэх, амьд биеийн амьдралын орчин, тэдгээрийн харилцан үйлчлэл, амьтдын үржил хөгжил, хог хаягдлыг багасгах<br>Хүн бий болох үйл явц, хүний өсөлт, хөгжил, буруу зуршилыг арилгах, хөдөлгөөн ба эрүүл мэнд | Уур амьсгал цаг уур,<br>байгаль дахь усны эргэлт, Улирлаас шалтгаалж өөр хүнс хэрэглэдгийг жишээгээр оруулж өгөх | Байгаль дахь усны<br>хувирал, конденсаци, Хоолны давс ихдэх, далайн усны шорвог байдаг тухай жишээ | Усанд уусдаг ба уусдаггүй бодисууд |
| | Цөм хөтөлбөрийн чадвар | Орчин тойрноо сонирхон судлах, дүрэм, журам, хэм хэмжээг сахих, харилцах, үнэт зүйлийг эрхэмлэх, таамаглал дэвшүүлэх туршилт, ажиглалт, үйл ажиллагаагаа төлөвлөх, төлөвлөсний дагуу хийж гүйцэтгэх,мэдээлэл боловсруулах, дүгнэлт гаргах, харилцах, хамтран ажиллах, асуудал шийдвэрлэх, нийгэм, түүхийн үйл явдлыг /үйл явцыг/ мэдэх, ойлгох, үнэт зүйлсийг эрхэмлэх | | | |
| | Дэлхийн иргэний боловсролын чадвар | Оролцогч байх<br>Өөрийгөө илэрхийлэх, Нээлттэй байх, Хариуцлагатай байх, Шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэх, Орчиндоо хүндэтгэлтэй хандах, асуудлыг шийдэх арга замыг сонгох | | | |

**Даалгавар 1:** Хүн төрөлхтний хэрэглэдэг хоол хүнсний онцлог хоол хүнсний ерөнхий ангилал

Аливаа юмс үзэгдлийн харилцан холбоо хамаарлыг эрж хайж олохыг эрхэмлэх, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах чадварыг хөгжүүлэхэд чиглэнэ.

Чи ямар төрлийн хоол хүнсэнд дуртай вэ?

Зургийг ажиглаад зураг тус бүрт холбоотой хүнсний бүтээгдэхүүнийг нэрлээрэй.


Үр тарианы төрөл


Махны төрөл


Ногооны төрөл


Жимсний төрөл


Сүүний төрөл


Тосны төрөл

*Манай дэлхийн хүмүүс ямар хоол иддэг вэ?*

Дараах үндэстнүүдийн үндэсний уламжлалт хоолыг нэрлэж, хоолны онцлогийг ярилцаарай



Мапо доуфу
Хятад



Кимбаб
Солонгос



Загасны шөл
Орос

*Хооллолтын ялгаатай байдалд нөлөөлсөн хүчин зүйлийн талаар ярилцаарай.*

| Үндэстэн | Үндэсний хоолыг нэрлээрэй | Хооллолтод нөлөөлсөн хүчин зүйлүүд | | |
|---|---|---|---|---|
| | | Газар зүйн байршил | Уур амьсгал | Эрхэлдэг аж ахуй |
| Монгол | | | | |
| Орос | | | | |
| Хятад | | | | |
| Солонгос | | | | |
| Англи | | | | |

***Багшид зөвлөмж:***

Сурагчдын идэх дуртай хоол хүнсийг нэрлүүлэх тоглоом тоглуулж нэрлэх явцад багш ангилан бичиж зохистой хооллолтын талаарх ойлголтыг өгөхөд анхаарна .

- Хүн төрөлхтөн хоол хүнсийг хэрэглэж ирсэн түүх,
- Монголчуудын болон дэлхийн улс орнуудын хоол хүнсний онцлог,
- Дэлхийн хүмүүсийн хоол хүнс болон хооллох соёлын ялгаатай байдал, түүнд нөлөөлдөг хүчин зүйлүүдийн тухай ярилцаж зохих даалгаврыг хийлгэнэ.
- Хоол хүнсний ялгаатай байдлыг орон нутаг, үндэстэн, бүс нутаг, олон улсын түвшинд авч үзэж ярилцаарай.

**Даалгавар 2:** Хоол хүнсний олон янз байдал, бүтэц найрлага, сонголт, хэрэглээ

Ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах, боломжит шийдлүүдийг илэрхийлэх, шийдэл бүрийн эерэг сөрөг талыг тодорхойлох, эцсийн шийдэл түүнийг сонгосон шалтгаанаа тайлбарлах, Асуудлыг олж харах, хариуцлагатай байх, Урьдчилан сэргийлэх,хүрээлэн буй орчноо мэдрэх, хүрээлэн буй орчинд сөрөг үзүүлж буй зүйлийг илрүүлэх чадварыг хөгжүүлэхэд чиглэнэ.

*Шувуудад өндгийг нь олж өгөөрэй. Таамаглал дэвшүүлж ярилцан тэмдэглэл хийгээрэй.*

| Шувууд | Шувуудын нэр | Өндөгний хэмжээ | Өндөгний онцлог |
|---|---|---|---|

| Шувууд | Шувууудын нэрийг бичээрэй. | Өндөгний хэмжээг бичээрэй. | Өндөгний онцлогийг ажиглаж тэмдэг-лээрэй. |
|---|---|---|---|
|  | | | |
|  | | | |
|  | | | |
|  | | | |




*Мэдээллийг уншаад өндөгний бүтцийн хэсгүүдийг нэрлэж ач холбогдлыг ярилцаарай.*

Өндөг нь шар уураг, цагаан уураг, шохойлог хальс гэсэн гурван үндсэн хэсгээс бүрдэх хүний амьдралд зайлшгүй шаардагдах тэжээлийн бодисуудыг агуулагч хүнс юм. Өндөгний химийн найрлага хальсыг эс тооцон дунджаар үзүүлбэл: 73,6% нь ус, 13% нь уураг, 12% нь өөх тос, 0,6% нь нүүрс ус, 1 % нь кальци, фосфор зэрэг эрдэс бодис байдаг.



| Шувууд | Уураг (%) | Өөх тос(%) | Нүүрс ус (%) | Эрдэс бодис (%) | Ус(%) | 100г тутам дахь калорийн хэмжээ ккал |
|---|---|---|---|---|---|---|
| Тахиа | 12.57 | 12.02 | 0.67 | 1.07 | 73.67 | 158.00 |
| Нугас | 12.77 | 15.04 | 0.30 | 1.08 | 70.81 | 184.00 |
| Галуу | 13.90 | 13.30 | 1.30 | 1.10 | 70.40 | 180.00 |

*Дараах савлагаатай өндөгнөөс алийг нь сонгон авах вэ?*



1



2




3




4



5

Өндөг сонгон авахдаа ямар хүчин зүйлийг харгалзан үзэх вэ?

| Өндөг сонгон авахад нөлөөлсөн хүчин зүйлүүд | Өөрийн сонголтоо (+) тэмдгээр тэмдэглэнэ үү | Сонгоогүй шалтгааныг тайлбарлана уу | Хэрхэн сайжруулах вэ? Өөрийнхөө бодлыг бичээрэй |
|---|---|---|---|
| Харагдах байдал | | | |
| Сав баглаа боодол | | | |
| Дотоодын үйлдвэрлэл | | | |
| Гадаад улс орнуудаас экспортолсон | | | |
| Хадгалах хугацаа | | | |
| Хэмжээ | | | |
| Өнгө | | | |
| Хадгалж буй орчин | | | |
| Ач холбогдол | | | |
| Шошгон дээрх мэдээлэл | | | |
| 1 ширхэг өндөгний үнэ | | | |

*Багшид зөвлөмж:*
Хоол хүнстэй холбоотой агуулгыг сурагчдын өдөр тутмын хэрэглээ болсон өндгөөр жишээ болгон ойлгуулаарай
Хоол хүнсний үйлдвэрлэл, сонголтод нөлөөлөх хүчин зүйлүүдийн тухай хэлэлцэхдээ дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзээрэй

- Цаг уурын ялгаатай байдал
- Газар зүйн байршлын ялгаатай байдал
- Насны ялгаатай байдал
- Хэрэгцээ, сонирхлын ялгаатай байдал
- Ёс заншил, уламжлалын ялгаатай байдал

**Даалгавар 3:** Хоол хүнсийг хадгалах, аюулгүй эсэхийг мэдэх

Зөрчлийн эх үндэс, шалтгааныг илрүүлэх, урьдчилан сэргийлэхийн талаар ойлголттой

болох, Хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалахад оролцох чадварыг хөгжүүлэхэд чиглэнэ.

Аяганд тасалгааны температуртай ус, 1 цайны халбага давс хийж уустал нь хутгасны дараа өндгийг хийж ажиглана.

*Өндөгний шинэ эсэхийг хэрхэн мэдэх вэ? Туршиж үзээд үр дүнг тайлбарлаарай .*



**1**



**2**

| Устай аяган дахь өндөгний байрлал | Муудсан эсэх | Тайлбар |
|---|---|---|
| Өндгийг усанд хийхэд өндөг шууд л аяганы ёроол руу живж, хөндлөн хэлбэрт байрлаж байвал шинэхэн өндөг | | |
| Өндөг аль ч хэсгээрээ аяганы ёроолд огт хүрэхгүй хөвж байвал маш удсан, муудсан өндөг | | |

Хоол хүнсийг аюулгүй байлгахад юуг анхаарах вэ? Ярилцаарай.

Аюулгүй хоол хүнсний 5 түлхүүр:

- Болсон ба түүхий хүнсийг тусгаарлах
- Хоол хүнсийг гүйцэд болгох
- Зохих хэмд хадгалах
- Аюулгүй ундны ус, хүнсний түүхий эд хэрэглэх
- Цэвэр байлгах

*Хоол хүнсийг муутгахгүйгээр хэрхэн хадгалах вэ?*

| Өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн | Хадгалах нөхцөл |
|---|---|
| Өндөгний худалдаалалт, хадгалалт | Өндгийг бүрэн битүүмжлэлтэй саванд хадгалаагүй тохиолдолд бусад бүтээгдэхүүнээс тусад нь хадгалж, өндөг тус бүр дээр үйлдвэрлэсэн огноог бичиж, худалдаална |

*Эх сурвалж: Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хадгалах тухай.*
*Хүнс, хөдөө аж ахуйн хяналтын газар*

*Өндөг худалдан авах үед дээр дурдсан нөхцөлд хадгалаагүй бол чи ямар үйлдэл хийх вэ? Дугуйлаарай.*

а) Тоохгүй худалдан авна
б) Авах эсэхээ бодно
в) Хэн нэгэнтэй утсаар ярьж, зөвлөж байгаад шийднэ
г) Худалдаж авахгүй
д) Дэлгүүрийн худалдагчид санууլж хэлнэ

*Ямар тэмдэглэгээтэй саванд өндгийг хадгалдаг вэ?*






PS:Полистирол хуванцарыг ихэвчлэн өндөгний сав, кофены аяга, махны тавиур, компакс дискний хайрцаг, хөөсөрдөг бүтээгдэхүүний сав зэргийг үйлдвэрлэхэд хэрэглэдэг. Хүнд хорт хавдар үүсгэдэг хортой стерин ялгаруулдаг бөгөөд үйлдвэрлэх болон хаях үед байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг байна.

*Эх сурвалж: http://ub.inspection.gov.mn*

*Энэ мэдээллийг уншаад чамд ямар сэтгэгдэл төрж байна вэ? Иргэн хүний ямар эрх зөрчигдөж байна вэ? Хэрэв таагүй мэдрэмж төрсөн бол үүнийг өөрчлөхийн тулд чи юу хийх вэ? Саналаа бичээрэй.*

***Багшид зөвлөмж:*** Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хэлэлцэх
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай ойлголт
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд нөлөөлдөг хүчин зүйлүүд
- Хүний эрхийн асуудлуудыг ярилцах

**Даалгавар 4:** Хүнсний хүрэлцээ хангамж, хог хаягдал

Хүрээлэн буй орчноо таньж мэдэх, хүрээлэн буй орчинд сөрөг үзүүлж буй зүйлийг илрүүлэх, хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалахад оролцох чадварыг хөгжүүлэхэд чиглэнэ.

*Мэдээллийг уншаад Монголчуудын нэг өдөрт хэрэглэх өндөгний тоо хэмжээ болон Хөрш орнуудаас авч буй өндөгний тооцоог хийгээрэй.*

Монгол улс 2017 оны байдлаар хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн болох өндөгний нийт хэрэгцээний 49,7%-ийг импортоор хангасан байна.

Монголчууд жилд ойролцоогоор 100 сая ширхэг өндөг хэрэглэдэг. Гэхдээ нэг өдрийн хэрэгцээнийхээ 800-900 мянгыг бид өөрсдөө үйлдвэрлэж, үлдсэнийг нь хойд хөршөөс зөөж байна.

*Хог хаягдлыг бууруулахад чи ямар оролцоотой байх вэ?*

*Жил бүр дэлхийн хүн ам 1,3 тэрбум буюу нийт үйлдвэрлэж буй хүнсний бүтээгдэхүүний гуравны нэгийг хаяж үрэгдүүлдэг байна. Хог хаягдлын 30% нь үр тарианы, 20% нь сүү, сүүн бүтээгдэхүүний, 45% нь хүнсний ногоо, жимс жимсгэний, 20% нь мах, махан бүтээгдэхүүний хаягдал гэсэн тооцоо гарчээ.*

| | | |
|---|---|---|
| Дэлхийн хэмжээнд жилд барьдаг 100-130 САЯ ТОНН загасны 30 САЯ ТОНН загасыг | АНУ-д жилд үйлдвэрлэсэн хоол хүнсний 30 ХУВЬ БУЮУ 48,3 ТЭРБУМ доллартой тэнцэх хоол хүнсийг | Улаанбаатар хотод хог хаягдлын хэмжээ өнгөрсөн онд 800 ТОНН байсан бол энэ онд 1.4 САЯ ТОНН болж нэмэгджээ. |

| Оролцоо | Багийн ажил |
|---|---|
| Өөрийн зүгээс | |
| Гэр бүлийнхээ орчинд | |
| Сургуулийнхаа орчинд | |
| Амьдран сууж буй хот, аймаг сумандаа | |

***Багшид зөвлөмж***: Дэлхийн хүн амын хоол хүнсний хаягдал, түүний нөлөө

- Эдийн засаг байгаль орчны зардал
- Хүнсний хаягдлыг хэрхэн багасгах тухай
- Боломжит шийдэл, арга замыг эрэлхийлэх

**Үнэлгээний хуудас** (Суралцагчдын өөрийн үнэлгээ)

Бид зорилгоо нэгтгэж чадсан.



..............................................................................................................

..............................................................................................................

..............................................................................................................

Би багийн бусад идэвх санаачилгатай гишүүн, миний хийсэн ажил, үүрэг



..............................................................................................................

Би өөрийнхөө санааг бусаддаа тайлбарлаж чадсан.



..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

Хүн бүр  аливаа зүйлийг өөрийнхөөрөө ойлгож, өөр өөрийн өнцгөөс хардаг



..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

Би багийн гишүүдийн санаа бодлыг сайтар сонссон.



Маш анхааралтай

..............................................................................................................................................................

Анхааралтай

..............................................................................................................................................................




Бид багийн ажлаа хамтдаа хийснээр  илүү сайн шийдэлд  хүрсэн.

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

..............................................................................................................................................................

## ДУНД, АХЛАХ АНГИ

**Сэдэв:** Дэлхий нийтийн хоол хүнсний хангамж хүрэлцээ

**Зорилго**: Дэлхийн нийтийн хоол хүнсний хангамж, хүртээмж, тулгамдаж буй асуудлуудыг судлах явцад эдгээр асуудлууд бүс нутаг үндэстэн, орон нутгийн хувьд ямар онцлог, ялгаатай байгааг илрүүлэх, асуудлын шалтгаан үр дагаварыг мэдэх,түүнийг шийдвэрлэх замыг эрэлхийлэх, шийдвэрлэх, оролцох, хэрэгжүүлэх, дуу хоолойгоо хүргэх зэргээр дэлхийн иргэн байх чадваруудыг хөгжүүлэх.

**Түлхүүр үгс:** Хоол хүнсний хангамж, хүрэлцээ, ядуурал, өлсгөлөн, хог хаягдал

**Анги зохион байгуулалтын хэлбэр**: Дунд болон ахлах ангийн суралцагчдын нас сэтгэхүйд тохирсон багаар, хосоор, анги нийтээр зэрэг зохион байгуулалтын хэлбэрийг сонгоно. Сурагчдын оролцоог хангахад анхаарна. Хэрэв багаар зохион байгуулсан тохиолдолд багийн гишүүн бүр оролцоо үүрэгтэй байхад анхаарна.

**Хэрэглэгдэхүүн:** Даалгавар тус бүрт өгөгдсөн зургуудыг олшруулах, тарааж өгөх материал болгон бэлтгэхээс гадна үзүүлэн, кейс болон бодит түүх, баримт, видео бичлэг, сурвалжлага, ярилцлага нэмж зааж болно. Мөн зураг, мэдээллийн дор эх сурвалжийг тэмдэглэсэн.

**Арга зүй:** Суралцагчдын хуримтлуулсан туршлага, танин мэдэхүйн хөгжлийн түвшинд тохируулан аргыг сонгох ба суралцагчдын оролцоонд тулгуурласан, харилцан яриа, үзүүлэн таниулах, унших материал судлуулах, хэрэглэх, дүн шинжилгээ, бүтээх арга зүйг ашиглана.

**Үнэлгээ:** Тухайн хичээлээр эзэмших мэдлэг, хандлага, чадвар, ойлголтоос гадна дэлхийн иргэний чадваруудтай холбон үнэлэхэд чиглэгдэнэ.

Үнэлгээг хүрэх үр дүнг тооцож, дэлхийн иргэний боловсролын агуулга, чадварыг үнэлгээний рубрикт багтааж бэлтгэнэ

Үнэлгээг хийхдээ багш болон сурагчид харилцан үнэлэх боломжийг олгох нөхцлийг бүрдүүлээрэй.

*Хоол хүнс сэдвийн хүрээнд эзэмших ДИБ-ын сэдвүүд*

| № | Түвшин | Орон нутгийн хувьд | Улс үндэстний хувьд | Олон улс, дэлхийн хэмжээнд |
|---|---|---|---|---|
| 1 | Бага | - Бидний нэг өдрийн хоол хүнс<br>- Бидний биеийн бүтцийн хэсгүүдийн үүрэг<br>- Хооллох үеийн эрүүл ахуйн энгийн дадал хэвшил,<br>- Сургуулийн үдийн цай, хоолны үеийн дэг соёл | - Өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлүүдийг нэрлэх<br>- Амьд биеийн хооллох хэрэгцээ<br>- Улирлын ялгаа нь хооллолтод нөлөөлдөг эсэх | - Амьд биесийн амьдарлын орчин тэдгээрийн харилцан үйлчлэл<br>- Амьтдын үржил хөгжил |
| 2 | Дунд | - Хоол тэжээлийн бодис<br>- Хоол боловсруулах эрхтэн тогтолцоо | - Хоол хүнсний найрлага, үүрэг (GMO)<br>- Уураг өөх тос нүүрс усны үүрэг | - Дэлхийн хүн амын хоол тэжээлийн хүртээмж хангамж<br>- Ургамлын хооллолт<br>- Амьтны хооллолт<br>- Идэш тэжээлийн хэлхээ |
| 3 | Ахлах | - Хоол боловсроход бодисуудын задрах үйл явц<br>- Бодис задрахад энзимын нөлөө<br>- Эсийн түвшин дэх энергийн задрал<br>- Биоценоз | - Биогеоценоз<br>- Уураг нийлэгжих<br>- Эсийн амьсгалалт<br>- ДНХ-ийн нийлэгжилт<br>- ГФА үүсэх | - Биосфер<br>- Бусад амьд биеийн хооллох явцад бодис задрах<br>- Байгаль дах бодисын эргэлт |

**Даалгавар 1:** Хоол хүнсний хангамж  дэлхий нийтийн асуудал болох нь

Энэхүү даалгавар нь дэлхийн иргэний боловсролын асуудлыг олж харах, асуудлыг шийдэх арга замыг сонгох, аливаа юмс үзэгдлийн холбоо хамаарлыг олохыг эрхэмлэх, боломжит шийдлүүдийг илэрхийлэх, орон нутаг, үндэстэн, бүс нутаг, дэлхий дахины асуудалд шийдэл хайх чадваруудыг хөгжүүлэхэд чиглэнэ.

"Хоол хүнс" сэдвээр  оюуны зураглал хийж хүнсний бүтээгдэхүүний ангиллыг бичээд ямар шимт бодисоор баялаг болохыг ярилцаарай.




| Хүнсний бүтээгдэхүүний ангилал | Төлөөлөх бүтээгдэхүүний нэр | Шимт бодисууд |
|---|---|---|
| Үр тариа | | |
| Махны төрөл | | |
| Ногооны төрөл | | |
| Жимсний төрөл | | |
| Сүүний төрөл | | |
| Тосны төрөл | | |

Монголын ард түмний хоол хүнсний хэрэглээг 4 улирлын онцлогтой холбон ярилцаад өөрсдийн хоол хүнсний илчлэгийг тооцоорой

*Хүн амын хүнсний хэрэгцээ (мян.төг)*







*Хоолны илчлэг тооцох*

| нас | эрэгтэй | эмэгтэй |
|---|---|---|
| 10-18 | (жин кг x17.5)+651 | (жин кг x 12.2)+746 |
| 18-30 | (жин кг x15.3)+679 | (жин кг x 14.7)+479 |
| 31-60 | (жин кг x11.6)+879 | (жин кг x 8.7)+829 |
| 60-дээш | (жин кг x 13.5)+487 | (жин кг x 10.5)+596 |

Илчлэгийг тооцохын тулд дараах 2 алхамыг хийнэ.

1. Байвал зохих жинг тооцохдоо өндрийн (метрийн) квадратыг 22 гэсэн тогтмол тоогоор үржүүлнэ. Жишээ нь: 165 см өндөртэй хүний байх ёстой жин = 1.652 x 22 = 59.9 кг буюу 60 кг
2. Нас, хүйсээс хамааран өөр өөр тогтмол тоог ашигладаг. Жишээ нь: 30-61 насны 60 кг жинтэй эмэгтэй хүнд (60 x 8.7) + 829= 1351 ккал байна.

Бид хоногийн хэрэгцээгээ хангах хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэдэг үү?

Өөрсдийн хоол хүнсний хэрэглээний илчлэгийг тооцож гаргаарай .

*15-18 нас хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг*

| | Бүтээгдэхүүний нэр | Хоногт хэрэглэх хэмжээ (гр, мл) | Илчлэг (ккал) | Уураг (гр) | | Тос (гр) | | Нүүр ус (гр) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Амьтан | Ургамал | Амьтан | Ургамал | |
| | Мах, махан бүтээгдэхүүний бүлэг | | | | | | | |
| 1 | Мах | 185 | 244.6 | 36.4 | 0 | 9.8 | 0 | 0 |
| 2 | Өндөг | 20 | 31.4 | 2.5 | 0 | 2.3 | 0 | 0.1 |
| | Сүү, сүүн бүтээгдэхүүний бүлэг | | | | | | | |
| 1 | Сүү | 170 | 108.6 | 5.6 | 0 | 6.0 | 0 | 8.2 |
| 2 | Тараг, аарц, ээдэм | 200 | 187.0 | 5.8 | 0 | 6.2 | 0 | 27.0 |

*Эх сурвалж: Монгол улсын эрүүл мэндийн сайдын 113 дугаар тушаалаас*

Өөртөө тохирсон хоолны цэс зохионо уу.

| № | Хүнсний бүтээгдэхүүн | Өглөө | Өдөр | Орой | Нийт илчлэгийн хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мах | | | | |
| 2 | Өндөг | | | | |
| 3 | Сүү | | | | |

*Дэлхийн хүн амын өсөлт болон хоол хүнсний хангамж, өлсгөлөнгийн тухай ярилцаарай.*







*http://globalsupplychainconsultancy.com/?page_id=11*

Хоол хүнсний дутагдалд яагаад охид, эмэгтэйчүүд илүү өртөж байна вэ?



Өлсгөлөнгийн шалтгааны талаар ярилцаж тэмдэглээрэй. (Хамаарлыг +,++,+++гэж тэмдэглээрэй хамгийн их бол +++ байна).

| Өлсгөлөнгийн шалтгаан | Монгол | Хятад | Энэтхэг | Пакистан | Конга |
|---|---|---|---|---|---|
| Газар зүйн байршил | | | | | |
| Хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт | | | | | |
| Дэд бүтцийн хөгжил | | | | | |
| ХАА газар тариалангийн хөгжил | | | | | |
| Уур амьсгалын өөрчлөлт | | | | | |
| Байгалийн гамшиг | | | | | |
| Дайн | | | | | |
| Бусад | | | | | |

Хоол хүнсний хангамжид эзлэх хувиргасан амьд организмаас гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл чухал уу? Мэтгэлцээн зохиогоорой.




*Эх сурвалж: http:// http://discovermagazine.com/2013/april/16-seeds-of-conflict/*

Хоол идсэний дараа ихэвчлэн аль үйлдлийг хийдэг вэ ? Таны үйлдэл дэлхийн хүн амын хүнсний хангамжид нөлөөлөх үү?


1


2


3

Дэлхийн хүн амын өлсгөлөнг багасгахад чи ямар оролцоотой байх вэ ? Багийн ажил хийгээрэй






https://www.theguardian.com/

*Өлсгөлөнгийн үр дагаврыг ярилцаж, тэмдэглээрэй (+)*




| Өлсгөлөнгийн үр дагавар | Монголд | Хятад | ОХУ | Дэлхийд |
|---|---|---|---|---|
| Боловсролд | | | | |
| Эрүүл мэндэд | | | | |
| Ажил эрхлэлтэд | | | | |
| Эдийн засагт | | | | |

Багшид зөвлөмж: Энэ даалгаврын хүрээнд хоол хүнсний хангамж, өлсгөлөн, хог хаягдлын тухай асуудлуудад сурагчдын өөрсдийн үзэл бодол,байр сууриа илэрхийлэх асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхэд нь тухайлбал Энэ чиглэлээр мэдээлэл бэлтгэх,илтгэл бэлтгэх, эссэ бичих, инфографик хийх,сонинд нийтлэл бичих зэрэг үйл ажиллагааг дэмжин туслахад анхаараарай.

**Даалгавар 2:** Хоол хүнсний хаягдал, үүсэх сөрөг үр дагавар, хог хаягдлын багасгах арга зам

Энэхүү даалгавар нь дэлхийн иргэний боловсролын - Асуудлыг олж харах, асуудлыг шийдэх аргуудын эерэг, сөрөг талуудыг тооцох, боломжит шийдлүүдийг илэрхийлэх, шийдвэр гаргахад өөрийн санаа бодлыг илэрхийлэх чадваруудыг хөгжүүлэхэд чиглэнэ.

Улаанбаатар хотод хоол хүнсний хаягдал зуны улиралд нийт хог хаягдлын 36 хувь, өвлийн улиралд 23 хувийг тус тус эзэлдэг. Эх сурвалж: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба

БНХАУ-ын нийт хог хаягдлын 70 хувь нь хоол хүнснийх бөгөөд үүний 61 хувь нь өрхийн хэрэглээнээс гардаг байна . Өрхийн хэрэглээний хоол хүнсний хаягдлын хэмжээ Англи болон Сан Францискод 17.5 хувь, Хойд Ирландад 19 хувь, Японы Нагоя-д 20 хувь байдаг. http://usa.chinadaily.com.cn/

*Дэлхийн хүн ам хэр их хоол хүнсийг хэрэглэхгүй хаядаг вэ?*




*Оршин сууж буй газрынхаа хоол хүнсний хаягдлын хэмжээг гаргаж, эдийн засгийн тооцоог хийгээрэй.*







https://blog.helpling.com.au/

| Хаягдлыг багасгах арга зам шийдлүүд | Монгол улсын өнөөгийн туршлага | Дэлхийн улс орнуудын туршлага | Өөрийн шийдэл | |
|---|---|---|---|---|
| | | | Гэр бүлийн орчинд | Сургуулийн орчинд |
| | | | | |

Мэдээллийг уншаад дэлхийн хоол хүнсний хаягдлын улмаас үүсэх үр дагавар, асуудал, шалтгааныг хэлэлцэж мод дээр байрлуулна уу.

Хүнсний хаягдал нь дэлхийн хүлэмжийн хийн ялгарлын 8%-ийг эзэлдэг, Хөдөө Аж Ахуйн газрын 30% нь хүнс тариалдаг бөгөөд цэвэр усны 21 хувийг алдагдуулдаг.

*эхсурвалж:http://www.activesustainability.com/*




Хоол хүнсний хог хаягдлыг багасгах ямар арга зам, шийдэл байж болох вэ?

| Хоол, хүнсний хаягдал гардаг газруудын нэрс | Их Британи | Монгол |
|---|---|---|
| Гэрийн нөхцөлд | *700.000 тонн* | |
| Хоолны газрууд | *150.000тонн* | |
| Сургуулийн өдрийн хоол (дунд сургууль) | *123.000 тонн* | |
| Супермаркет | *300.000 тонн* | |

*Дараах зургаас сэдэвлэн хоол хүнсний хаягдлыг багасгах талаар өөрсдийн санааг дэвшүүлж схемчлээрэй. Өгөгдсөн сонголтуудаас ашиглаж болно.*



*Эх сурвалж: www.pinterest.com*

*Бусад улс орнуудын туршлагыг судлан Монгол оронд хоол хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах ямар механизм байж болох талаар төсөлт ажил боловсруулна уу.*

Хоол хүнсний хог хаягдлыг орон бүр ялгаатай дахин боловсруулдаг. Монгол оронд одоогоор дахин боловсруулах оновчтой технологи байхгүй зөвхөн хоол хүнсний хаягдлыг нохой, гахайнд өгөх, ил задгай газар хаях төдийгөөр л хязгаарлагдаж байна.

*эх сурвалж:http://www.activesustainability.com/food-waste-how-to-stop*

*Багшид зөвлөмж:*
Хүнсний хог хаягдлын хэмжээг өөрийн болон гэр бүлийн хүрээнд гаргах, тооцоолох, үнэлгээ хийх, хаягдлаас үүдэн гарах хор уршиг, урьдчилан сэргийлэхэд өөрийн болон найз, гэр бүлийн хувь нэмрийг хамтран шийдвэрлэх, дуу хоолойгоо нэгтгэхэд багш чиглүүлэх боломжтой.

**Даалгавар 3:** Хоол хүнсний экологийн ул мөр

Энэхүү даалгавар нь дэлхийн иргэний боловсролын -Хүрээлэн буй орчноо мэдрэх, зөрчлийн эх үндэс, шалтгааныг илрүүлэх, бусдыг сонсох, өөрийн байр сууриа илэрхийлэх, шийдвэр гаргах, боломжит шийдлүүдийг эрэлхийлэх, шийдэл бүрийн эерэг, сөрөг талыг тодорхойлох чадваруудыг хөгжүүлэхэд чиглэнэ.

Хоол хүнсний бүтээгдэхүүн бий болгоход зарцуулах усны экологийн ул мөрийн эдийн засгийн үнэ цэнийг тооцоорой .




| Хүнсний бүтээгдэхүүн | Зарцуулж буй цэвэр ус, л |
|---|---|
| 1кг шоколад үйлдвэрлэхэд | 17100 |
| 1кг үхрийн мах бий болоход | 15415 |
| 1кг хонь, ямааны мах бий болоход | 8763 |
| 1кг гахайн мах бий болоход | 5988 |
| 1кг цөцгийн тос | 5553 |
| 1кг тахианы мах бий болоход | 4325 |
| 1кг өндгөнд | 3265 |
| 1кг гамбургер | 2400 |
| 1кг талханд | 1608 |

Өөрийн нэг өдрийн хоол хүнсний усны экологийн ул мөрийг тооцоорой.




Хүн амын болон эдийн засгийн өсөлт, ул мөрийн хэмжээ зэрэг бүх зүйл яг энэ хэвээр үргэлжилбэл 2030 он гэхэд агаарын температур хоёр хэмээр нэмэгдэж, биологийн төрөл зүйлийн 40 хувь нь устаж үгүй болох тооцоог эрдэмтэд гаргажээ.

Хоол хүнсний экологийн ул мөрийг бууруулахын тулд та юу хийж чадах вэ ?

| Экологийн ул мөрийг бууруулахад чиглэсэн арга замууд | Монгол улсын туршлага | Дэлхийн бусад улс орнууд туршлага | Өөрийн санал санаачлага | Түгээн дэлгэрүүлэх арга замууд |
|---|---|---|---|---|
| Хоолны хаягдал | | | | |
| Усны хэрэглээ | | | | |

***Багшид зөвлөмж:***
Хүн төрөлхтний байгальд үзүүлэх нөлөө, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс үүсэх зардлыг багасгах боломжийг хайх, эрэлхийлэх, ирээдүйд үүсэх нөхцөлийг урьдчилан тооцоолох, өөрийн оролцоог бий болгох, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх арга замыг сонгоход нь дэмжээрэй.

**Даалгавар 4:** Хүнсний аюулгүй байдал

Энэхүү даалгавар нь дэлхийн иргэний боловсролын -Бусдын үзэл бодлыг хүндэтгэн сонсох, асуудлыг олж харах, асуудлыг шийдэх эерэг ба сөрөг талуудыг олж харах, бусдыг хүндэтгэх, бусдад туслах, шийдэл бүрийн эерэг сөрөг талыг тодорхойлох, орон нутаг, үндэстэн, бүс нутаг, дэлхий дахины асуудалд шийдэл хайх чадваруудыг хөгжүүлэхэд чиглэнэ.

*Өдөр тутам хэрэглэдэг жимс хүнсний бүтээгдэхүүнүүд хүнсний аюулгүй байдлыг хангасныг хэрхэн мэдэх вэ? Ярилцаарай.*








*Дараах бүтээгдэхүүнүүдийн шошгоны тайлбарыг уншиж ойлгоод өгөгдсөн бүтээгдэхүүний шошгыг уншиж тэмдэглэж ирээрэй.*









| Тэмдэглэгээ | Талх | Сүү | Тараг |
|---|---|---|---|
| хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нэр | | | |
| үйлдвэрлэгчийн нэр, хаяг | | | |
| жин, тоо ширхэг | | | |
| бүтээгдэхүүний цувралын дугаар; | | | |
| үйлдвэрлэсэн он, сар, өдөр; | | | |
| Хадгалах болон хэрэглэж дуусах хугацаа | | | |
| хадгалах нөхцөл; | | | |
| тэжээллэг чанар, орц, найрлага | | | |
| Е тэмдэглэгээний дугаар | | | |
| хэрэглэх арга | | | |
| Гаж нөлөө хориглох заалт | | | |

*Хувиргасан амьд организмаас гаралтай бүтээгдэхүүний давуу, сул талуудыг ярилцаж дүгнэлт гаргаарай.*

ДЭМБ-аас хувиргасан амьд организмын (Генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүн-ГӨБ) талаар баримтлах зөвлөмжийг гаргаад байна. Дэлхий дээр өнөөдөр генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүний тариалангийн талбай сүүлийн 10 жилийн дотор 60 дахин нэмэгдэж 110 сая га-д хүрээд байна.

Эх сурвалж : *http://www.ncph.gov.mn*




Генийн өөрчлөлт (хувиргасан амьд организм) агуулсан бүтээгдэхүүний нөлөөллийг ярилцаж тэмдэглээрэй.

| Үзүүлэх нөлөө | Эерэг (+) | Сөрөг (-) | Тайлбар |
|---|---|---|---|
| Хүний эрүүл мэндэд | | | |
| Байгаль орчинд | | | |
| Эдийн засагт | | | |
| Нийгэмд | | | |

| Европын холбоо | Тайланд | АНУ | Монгол |
|---|---|---|---|
| 500 сая хүн амтай<br>25,000 нас баралт/ жилд<br>2,5 сая ор хоног<br>Нийгэмд учирч буй нийт зардал нь | 70 сая хүн амтай<br>38.000 нас баралт/ жилд<br>3.2 сая ор хоног<br>Нийгэмд учирч буй нийт зардал нь | 300 сая хүн амтай<br>23.000 нас баралт/ жилд<br>2.0 сая ор хоног<br>Нийгэмд учирч буй нийт зардал нь | 3.2 сая хүн амтай<br>16.200 нас баралт/ жилд<br>Нийгэмд учирч буй нийт зардал нь |
| 1.5 тэр бум Евро | 1.3 тэр бум ам. доллар | 35 тэр бум ам. доллар | 645 тэрбум төгрөг |
| ГМО хориглосон | ГМО зөвшөөрсөн | ГМО зөвшөөрсөн | ГМО хориглоогүй |

Эх сурвалж: https://www.google.com/

*Дэлхийн аль улсын иргэдэд хоол шим тэжээлийн эрх илүү хамааралтай байна вэ ? Та хоол тэжээлийн эрхээ бүрэн гүйцэд эдэлж байна уу? Мэтгэлцээн зохиогоорой.*

Хоол, шим тэжээлийн эрх гэдэг нь "Хүн бүхэн эрүүл, идэвхитэй амьдрахын тулд хангалттай, шим тэжээлийн хувьд биемахбодийн хэрэгцээнд тохирсон, аюулгүй, соёл, ёс заншилд нийцсэн хоолоор хангагдах"-ыг хэлнэ. (FAO. Right to Food and Nutrition, 1972)"Дэлхий ертөнц дээр амьдарч буй бүхий л хүмүүс амьдралынхаа туршид эрүүл, тэжээллэг хоол хүнс хэрэглэх эрхтэй" (Дэлхийн хүнсний дээд хэмжээний уулзалт, 1996)

*Багшид зөвлөмж:*
Өдөр тутмын хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд шинжилгээ үнэлгээ хийх, ялган таних, гэр бүл, найз нөхдөдөө зөвлөгөө өгөх, хувиргасан амьд организмаас гаралтай бүтээгдэхүүнийг хэрэглэхдээ нөлөөг нь мэддэг байх, хүний хоол, шим тэжээлийн эрх хаана, яагаад зөрчигдөөд байгаа асуудлыг харах, шийдвэр гаргахад өөрийн болон ойр дотны хүмүүсийн дуу хоолойг хүргэхэд чиглүүлээрэй.

## Үнэлгээний хуудас

1. Хүнсний бүтээгдэхүүн сонгохдоо ямар үзүүлэлтийг харж сонгох талаар бяцхан зөвлөмж бэлдээрэй.

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

2. Ирээдүйд хоол хүнсний хангамжид гарч болзошгүй сөрөг үр дагаварыг арилгахын тулд та болон танай гэр бүл өнөөдрөөс эхлэн юу хийх вэ? Төлөвлөөрэй.

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

3. Та гэр бүл, найз нөхдөдөө хоол хүнсний хог хаягдлыг багасгах тухай ямар зөвлөгөө өгөхөөр төлөвлөсөн бэ? Зөвлөмж бичээрэй

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................

......................................................................................................................................................




4. Та найзынхаа өдөрт идэх хоолны илчлэгийг бодож өгөөрэй.

............................................................................................................................

............................................................................................................................

............................................................................................................................

5. Дараах зургаас ихэвчлэн хийдэг үйлдлээ сонгоорой. Сонголтоо тайлбарлаарай.



А.




Б.



В.

Би зураг (    )-г сонгож байна. Учир нь: ..........................................................................

............................................................................................................................

............................................................................................................................

............................................................................................................................

6. Экологийн ул мөрийг хэрхэн багасгах вэ? Төсөлт ажлын уралдаанд оролцоорой

**Хүнсний экологийн ул мөр**




1 кг шоколад, талх үйлдвэрлэхэд хүний хүч хөдөлмөр, цахилгаан эрчим хүч, хөргүүр, тээврийн ихээхэн зардал гардаг гэвэл аливаа хүнсний болон бусад бүтээгдхүүний экологийн ул мөр байгаль орчинд халтай юм.

......................................................................

......................................................................

......................................................................

......................................................................

......................................................................

......................................................................

7. Миний явсан мөр бүр дэлхийд хамааралтай “Би дэлхийн иргэн” сэдвээр эссэ бичээрэй

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

..........................................................................................................................................

## Ашигласан материал


1. БСШУЯ. (2014). Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Улаанбаатар
2. БСШУЯ. (2015). Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Улаанбаатар
3. БСШУЯ. (2016). Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр Биологи. Улаанбаатар
4. Энхтогтох, А., Батчулуун, Е., Баярмаа, Г., нар. (2014). Хүн ба орчин I. Улаанбаатар хот. Мөнхийн үсэг ХХК.
5. Батчулуун, Е., Баярмаа, Г., Болорчимэг, Ө., нар. (2014). Хүн ба орчин I Багшийн ном. Улаанбаатар хот.
6. Энхтогтох, А., Батчулуун, Е., Баярмаа, Г., нар. (2014). Хүн ба орчин II. Улаанбаатар хот. Мөнхийн үсэг ХХК.
7. Батчулуун, Е., Баярмаа, Г., Болорчимэг, Ө., нар. (2014). Хүн ба орчин II Багшийн ном. Улаанбаатар хот.
8. Энхтогтох, А., Батчулуун, Е., Баярмаа, Г., нар. (2014). Хүн ба орчин III. Улаанбаатар хот. Экимто ХХК.
9. Энхтогтох, А., Батчулуун, Е., Баярмаа, Г., нар. (2014). Хүн ба орчин III Багшийн ном. Улаанбаатар хот. Экимто ХХК. Гэрээний дугаар
10. Энхтогтох, А., Батчулуун, Е., Баярмаа, Г., нар. (2014). Хүн ба орчин IV. Улаанбаатар хот. Экимто ХХК.
11. Энхтогтох, А., Батчулуун, Е., Баярмаа, Г., нар. (2014). Хүн ба орчин IV. Багшийн ном. Улаанбаатар хот. Экимто ХХК.
12. Пагмасүрэн, Ц., Алтанцэцэг, Д., Батчулуун, Е.,Мягмаржав.У., нар. (2014). Хүн ба байгаль V Багшийн ном. Улаанбаатар хот. Мөнхийн үсэг ХХК.

13. Пагмасүрэн, Ц., Алтанцэцэг, Д., Батчулуун, Е.,Мягмаржав.У., нар. (2014). Хүн ба байгаль V Улаанбаатар хот. Мөнхийн үсэг ХХК.
14. Гэндэнжамц, С., Батболд, Д., Амартайван, Ц., нар. (2015). Байгалийн ухаан VI. Улаанбаатар хот. Битпресс ХХК.
15. Тэрбиш, Х., Цогбадрах, С., Болдгив, Б., нар (2015). Биологи VII. Улаанбаатар хот.
16. Цогбадрах, С., Тэрбиш, Х., Болдгив, Б., нар. (2014). Биологи VIII. Улаанбаатар хот. Таван богд менежмент ХХК.
17. Тэрбиш, Х., Мөнхбаатар, М., Саранцэцэг, Г., нар. (2015). Биологи IX. Улаанбаатар хот.
18. Юнеско. (2016). Тогтвортой хөгжлийн зорилго 4- боловсрол 2030- ийг дэлгэрүүлэн ойлгох нь гарын авлага УБ. 10.
19. Юнеско. (2015). Дэлхийн иргэний боловсрол, сэдвүүд ба суралцахуйн зорилтууд. \ орчуулгын материал., 2017\ УБ. 31-45
20. (2017). Санжаабадам.С., нар. Дэлхийн иргэний боловсрол, багшид зориулсан гарын авлага.УБ.Соёмбо принтинг.
21. Данида төсөл. (2000). Идэвхтэй сургалтын зуун нэгэн арга.УБ.Боловсролын хөгжлийн сургуулийн хэвлэх цех.
22. http://e-book.must.edu.mn/lecture/show/id/1572
23. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
24. Монгол Улсын Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, 2012
25. http://www.legalinfo.mn/law/details/8912?lawid=8912
26. http://www.legalinfo.mn/law/details/10704
27. http://ub.inspection.gov.mn
28. http://md-forum.eu
29. http://www.activesustainability.com/food-waste-how-to-stop

## ДИЗАЙН ТЕХНОЛОГИ

### ДИБ болон судлагдахууны суралцахуйн зорилт, агуулга, арга зүйн интеграцийн тодорхойлогдсон байдал

ДИБ-ын суралцахуйн зорилт болон сэдвийн хамаарлыг авч үзэн дизайн технологийн агуулгыг дараах байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно.

**ДИБ–ын сэдэв:** Ялгаатай байдалд хүндэтгэлтэй, зохистой хандах

*Хүснэгт 1. ДИБ-ын суралцахуйн зорилт, сэдэв болон судлагдахууны агуулгын хамаарал*

| Бага боловсрол | Суурь боловсрол | Бүрэн дунд боловсрол |
|---|---|---|
| | **ДИБ–ын суралцахуйн зорилт** | |
| Янз бүрийн хүмүүс болон нийгмийн бүлэгтэй сайн харилцаатай байхыг эрмэлзэх | Ялгаатай болон олон талт байдлын бэрхшээл ба ашиг тусын талаар мэтгэлцэх | Ялгаатай бүлгүүдтэй харилцах үнэт зүйл, хандлага, чадварыг хөгжүүлэх, хэрэглэх |
| | **ДИБ–ын холбогдох сэдэв** | |
| Хүмүүс хамтдаа энхтайвнаар хамтран амьдрах чадвар, үнэт зүйлд суралцах (хүндэтгэл, тэгш байдал, бусдыг ойлгох) | Өөр өөр онцлог шинжүүд (үндэсний, соёлын) болон бусад хүчин зүйлс бидний хамтаар амьдрах чадварт хэрхэн нөлөөлж буй тухай | Янз бүрийн нийгэм, соёлын хүрээн дэх амьдралын олон янзын холбоо хамаарал, саад бэрхшээл (тэгш бус байдал, эдийн засгийн ялгаатай байдал, зөрчил, нийгмийн тогтсон хандлага) |
| | **Судлагдахууны суралцахуйн зорилт** | |
| Ажил мэргэжлийн талаар ойлгож мэдэх[1] | Үндэсний хэв загвар тусгасан бүтээл хийх хэрэгцээг тодорхойлж, анхны санаагаа гаргах | Тээглүүрт механизмын ач холбогдол хэрэглээг ойлгох |

### Арга зүйн сонголт:

Багшийн үүрэг бол сурагчдыг суралцаж байгаа зүйлээ өөрсдөө ойлгож, танин мэдэхэд чиглүүлэх, амьдралын туршид үргэлжлэн суралцах үйл явцад хэрэгтэй ур чадварыг хөгжүүлэх явдал юм. Тухайн хичээлийн арга зүйг сонгохдоо суралцахуйн зорилт, ДИБ-ын зорилт, сэдвийн хамаарал болон тухайн насны суралцагчийн сонирхол хэрэгцээ, онцлогийг харгалзсан. Агуулга, арга зүй хоёр нь амин холбоотой. Агуулгыг эзэмшүүлэх технологи нь арга зүй буюу арга юм. Арга бүр өөр өөрийн онцлогтой бөгөөд зорилго чиглэлтэй эрэмбэлэгдсэн үйлүүд юм. ДИБ болон судлагдахууны суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд арга зүйн сонголт маш чухал юм. Судлагдахууны суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх энэхүү арга зүйг сонгохдоо агуулга, арга зүйн шүтэлцээ болон үйл

1 БСШУЯ. (2014). Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ. 82.

ажиллагааны үе шат, үйлийн алхам бүрд ДИБ-ын чадамжийг дэмжих байдлыг харгалзан үзсэн болно.

## БАГА БОЛОВСРОЛ

*Хичээлийн жишээ*: 5 дугаар анги

**ДИБ-ын сэдэв** → Ялгаатай байдалд хүндэтгэлтэй, зохистой хандах

**ДИБ-ын суралцахуйн зорилт** ↓ Янз бүрийн хүмүүс болон нийгмийн бүлэгтэй сайн харилцаатай байхыг эрмэлзэх

**Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт, хичээлийн сэдэв** ↑ Ажил мэргэжлийн талаар ойлгож мэдэх[2]

Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт, ДИБ-ын суралцахуйн зорилт ба сэдвийн дээрх харгалзуулсан байдлыг “ажил мэргэжлийн онцлог болон ялгаатай байдалд дүн шинжилгээ хийх замаар бусадтай хүндэтгэлтэй, зохистой хандах чадвар, ойлголтоо нэмэгдүүлэхийн хамт янз бүрийн хүмүүс болон нийгмийн бүлэгтэй сайн харилцаатай байхыг эрмэлзэх нь” ДИБ-тэй холбогдох тал гэж авч үзэв.

“Ажил мэргэжлийн талаар ойлгож мэдэх” гэсэн энэхүү суралцахуйн зорилтын хүрээнд сурагчид ажил мэргэжлүүд түүний онцлог болон ялгаатай байдалд шинжилгээ хийх, асуудал дэвшүүлэх, хэлэлцэх замаар өөрсдийн ойлголтоо нэмэгдүүлэхийн хамт тэдний янз бүрийн хүмүүс болон нийгмийн бүлэгтэй сайн харилцаатай байхыг эрмэлзэх, бусадтай хүндэтгэлтэй, зохистой хандах, бусдыг ойлгох чадварт нь тодорхой хувь нэмэр оруулна.

***Багшид санамж:***

Бусдыг ойлгох гэдэг нь өөр хүний амьдрал, туршлага болон мэдрэмжийг төсөөлөх, ойлгох, өөрөө тодорхойлох чадвар юм. Уг ур чадварыг эзэмшсэнээр найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ илүү сайн харилцаатай байх, өөрөөсөө ялгаатай хүнийг илүү ойлгож хүлээн авах хандлагатай болдог. Энэ нь соёл иргэншил болон нийгмийн ялгаатай нөхцөл байдлын үед зөрчил үүсэхээс сэргийлдэг. Түүнчлэн, бусдыг ойлгох чадвар нь гадуурхагдаж дорд үзэгдэх магадлалтай хүмүүсийг хүлээн зөвшөөрөх, ойлгох, туслалцаа дэмжлэг хэрэгтэй хүмүүст анхаарал халамж тавих үзлийг дэмжин урамшуулдаг.

2 *БСШУЯ. (2014). Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ. 82.*

*Зураг 1. Арга зүйн сонголт.*

| Арга зүйн | ✓ Савар зураглал(санаа гаргах, дэлгэрүүлэх, олон талаас нь харах, ангилах)<br>✓ Венийн диаграмм(харьцуулах,ангилах)<br>✓ Цөөн хүнтэй багаар ажиллах(санаа гаргах, олон талаас нь харах, шүүмжлэлт сэтгэлгээ, хамтран ажиллах, өөртөө итгэх итгэл нэмэгдүүлэх) |
|---|---|

**Хичээлийн сэдэв:** Ажил мэргэжлийн тухай

## Арга зүйн төлөвлөлт

*Сургалтын зохион байгуулалтын хэлбэр:* Хэсгээр (Суралцагчдыг 4-6-аар нь баг болгон зохион байгуулна).

***Багшид санамж:***
Багаар ажиллах арга нь тухайн агуулга, сэдвүүдийн талаар санал бодлоо баг дотроо хуваалцах, өөрийн болон багийн гишүүдийн үзэл бодлын ялгаатай болон ижил талуудыг мэдэх, санал бодлоо багийн хүрээнд илэрхийлэх боломжийг сурагчдад олгодог. Сурагчдыг багаар ажиллах хооронд багш тэдний дундуур явж өгсөн даалгаврыг ойлгож, хийж байгаа эсэхийг нягтлах ба даалгавраа зөв гүйцэтгэхэд нь чиглүүлж өгөх хэрэгтэй юм.

**Сэдэлжүүлэх үе шат:** Багш сурагчдад гэр бүлийн гишүүдийнхээ ямар ажил эрхэлдэг талаар бусадтайгаа хуваалцах даалгавар өгч баг тус бүрээс 1 сурагчийн хариултыг авна. Дараа нь хичээлийн сэдвийг сурагчдад танилцуулна.

***Багшийн санамж**:* Багш сургалтад ашиглах видео бичлэг эсвэл зурагт үзүүлэнг бэлтгэсэн байна. Сургалтад хэрэглэх (хүмүүстэй холбоотой) зурагт үзүүлэн болон видео бичлэгийг сонгон авахдаа: Арьс өнгө, хүйсийн тэнцвэртэй байдал зэргийг харгалзахын хамт хүмүүсийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, эзэлж буй байр суурийн тэгш байдлыг бодолцох хэрэгтэй. Учир нь тухайн хичээлийн үйл ажиллагаа, үйлийн алхам бүрт ДИБ-ыг агуулга, чадамжийг дэмжиж байхыг мартаж болохгүй юм. Тухайлбал:

А. Хүүхдүүдийг харуулсан зурагт үзүүлэн бол:



Б. Ажил, мэргэжлийг харуулсан зурагт үзүүлэн бол:



**Даалгавар 1.** Ажил, мэргэжлийг харуулсан видео бичлэг эсвэл зурагт хуудас үзэж ярилцана. *(Багш, үйлчлэгч, малчин, инженер, зураач, зохион бүтээгч, нисгэгч мөн техниктэй холбоотой ажил мэргэжлүүд гэх мэт.)*

*Хүснэгт 3. Даалгаврын хувилбар.*

| *Даалгаврын хувилбар 1.*<br>*Видео бичлэг ашиглах* | *Даалгаврын хувилбар 2.*<br>*Зурагт үзүүлэн болон тараах материал ашиглах* |
|---|---|
| Видео бичлэг: *https://www.youtube.com/results?search_query=Jobs+and+Occupations)* гэсэн хаягаар авч болно./ |    |
| • Ажил мэргэжлүүд тэдгээрийн онцлогийг харуулсан видео бичлэг үзнэ.<br>• Бичлэг дээр гарсан ажил мэргэжлүүдийг нэрлэх зэрэгцээ тэдгээрээс баг тус бүр 4 мэргэжлийг сонгон авч тэдгээр мэргэжлүүдийн онцлог болон хаана, юу хийдэг болох, ямар ажлын багаж хэрэглэгдэхүүн хэрэглэдэг талаар багаараа ярилцан савар зураглал ашиглан санаагаа дэлгэрүүлнэ.<br><br> | Зураг үзэж ярилцдаа:<br>• Багш баг тус бүрт өөр өөр 4 төрлийн ажил, мэргэжлийн зургийг тараан өгнө.<br>• Багийн гишүүд зураг дээрх ажил мэргэжлүүдийг нэрлэх, тэдгээр ажил мэргэжлүүдийн онцлог болон хаана, юу хийдэг, ямар ажлын багаж хэрэглэгдэхүүн хэрэглэдэг талаар хамтран ярилцаж, савар зураглал ашиглан санаагаа дэлгэрүүлнэ.<br><br> |

- Багууд хийсэн ажлаа танилцуулна. *(Жич: Багийн 1-р гишүүн)*
- Багш багуудын танилцуулгын явцад тэднийг нэрлэсэн ажил, мэргэжлүүдийг самбарт жагсаан бичнэ.

**Даалгавар 2.** Танилцуулгын дараа багш сургууль дээрх ажил, мэргэжлүүдийг нэрлэх даалгавар өгнө.

- Багууд өөр өөрийн хариултаа бэлтгэн хэлнэ. Тухайлбал: Захирал, сургалтын менежер, багш, эмч, үйлчлэгч, *манаач, жижүүр гэх мэт.* (Жич: Багийн 2-р гишүүн)
- Багш багуудын хариултыг нэгтгэнэ. Мөн самбар дээрх жагсаалтад байхгүй ажил, мэргэжлийг нэмэж тэмдэглэнэ.

**Даалгавар 3.** Багш ажил, мэргэжлүүдийн онцлог болон нийтлэг талыг харьцуулах даалгаврыг багуудад өгнө. *(Венийн диаграмм ашиглаарай.)*

- Самбарт жагсаан бичсэн ажил, мэргэжлүүдийн нэрийг А хэсэгт- ажил, Б хэсэгт- мэргэжлүүдийг ялган жагсаан бичнэ.
- Ажил болон мэргэжлийн онцлог болон нийтлэг талыг “Венийн диаграмм” ашиглан гүйцэтгэнэ.

*Зураг 2. Венийн диаграмм.*

**А/ Ажил**

- Үйлчлэгч




А-гийн тухай, Б-гийн тухай

**Б/ Мэргэжил**

- Багш






А-гийн онцлог тал | А болон Б-н нийтлэг тал | Б-гийн онцлог тал

***Багшийн санамж:*** Багш сурагчдад тухайн агуулга, даалгавартай холбоотой үйл ажиллагааг удирдан явуулахдаа хүмүүсийн ажил мэргэжлийн талаарх хэвшмэл ойлголтод баригдахгүй байхыг анхаарна. Өөрөөр хэлбэл, ажил мэргэжлийн талаарх хэлэлцүүлгийг чиглүүлэхдээ, тодорхой нэг хүйсэд л хамаарах шинжтэй эмэгтэй эсвэл эрэгтэй хүний мэргэжил гэсэн жендэрийн хэвшмэл ойлголтоос ангид байх юм. Тодруулбал, үйлчилгээний ажилтан (цэцэрлэгийн болон дунд сургуулийн багш, сувилагч, худалдагч гэх мэт)-г зөвхөн эмэгтэйгээр; удирдах ажилтан, техник, технологийн мэргэжилтэн (улс төрч, инженер гэх мэт)-г зөвхөн эрэгтэйгээр төлөөлүүлдэг хэвшмэл ойлголтоос зайлсхийх хэрэгтэй.




- Багууд даалгаврын гүйцэтгэлээ танилцуулна.*(Жич: Багийн 3-р гишүүн)* Багш багуудын танилцуулгын дараа багийн бусад гишүүд өөрсдийн гүйцэтгэл дээр нэмэлт тодруулга хийх боломжийг олгоно.

**Даалгавар 4.** Сургуулийн хүрээнд ажил мэргэжлүүдийн хувьд ялгаатай хүмүүстэй зохистой харилцах талаар хэлэлцэх

*Хүснэгт 4. Даалгаврын хувилбар.*

| *Даалгаврын хувилбар 1.* | *Даалгаврын хувилбар 2.* |
|---|---|
| Сургууль дээрх ажил, мэргэжлүүдээс (сургуулийн удирдах ажилтан (захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан), *багш нар* (ангийн багш, бусад мэргэжлийн багш нар) Туслах ажилтнууд (эмч,нярав, үйлчлэгч, манаач)) баг тус бүр нэгийг сонгон авч дараах асуултын дагуу багаараа хамтран ажиллана.<br><br>Асуулт:<br><br>- Сурагчид та нар тэднийг хэрхэн хүндэлж харилцдаг вэ?<br>- Илүү хүндэтгэлтэй харилцах талаарх та нар өөрсдийн бодлоо хуваалцана уу? | Багш дараах шүлгийг сурагчдад уншиж өгнө.<br>**Шүүрийн чимээ**<br>... Арван хуруугаа хөлдөж, цэврүүттэл гудамж шүүрдсэн ч<br>Алтан гадас бүү хэл баярын бичиг ч горьдоогүй<br>Амралтын хомсхон, цалингийн цэсэндээ яараагүй хирнээ<br>Ажил хэцүүдлээ гэж гудам руугаа л яардаг аа<br>Жавартай үдшээр гудмаа цэвэрлэчихээд харих<br>Жаргал минь тэр шүү гэж хуучлах<br>Маргааш нь цэлийсэн гудмаар хүмүүс алхахыг харах<br>Магтаал минь тэр шүү гэж хөөрөх<br>Гудамжны цэвэрлэгч гэж дуудуулчихаад гутардаггүй<br>Гутрах нь байтугай ичдэггүй<br>Тархин дотроо дүүрэн хогтой<br>Таримал хүмүүс ичээгүй байхад<br>Тэр цэвэрлэгч юунаас ичих юм бэ?...<br>*Мөнхбат.Ж. "Шүүрийн чимээ" шүлэг*<br>*Багш сурагчдад* асуултын дагуу багаараа хамтран ярилцаж даалгавар өгнө.<br>- Шүлэгт ямар ажил эрхэлдэг хүний тухай гарч байна вэ?<br>- Хүмүүс тэдний ажилд хэр хүндэтгэлтэй ханддаг гэж чи бодож байна вэ?<br>- Тэдний ажилд хүндэтгэлтэй хандах талаар өөрсдийн бодлоо хуваалцана уу. |

- Асуултын дагуу багийн гишүүд хоорондоо ярилцаж, нэгдсэн санаагаа танилцуулна. *(Жич: Багийн 4-р гишүүн)* Багийн бусад гишүүдэд санал хэлэх болон нэмэлт тодруулга хийх боломжийг багш олгоно. *(Жич: Багийн 5, 6-р гишүүн сонгох)*
- Багш даалгаврын гүйцэтгэлээс чухал санааг тодруулан хэлэх ба тухайн хичээлийн зорилго хангагдсан эсэхэд дүгнэлт өгнө.

**Хэрэглэгдэхүүн:**

- Зурагт болон видео үзүүлэн
- Ажлын хуудас тараах материал

**Үнэлгээ**: Дараах шалгуураар үнэлнэ.

- Багийн гишүүдийн оролцоог үнэлэх: Оролцоо бага, дунд зэрэг, идэвхтэй оролцсон
- Багийн гишүүдийн танилцуулга утга төгөлдөр санааг бүрэн илэрхийлж буй байдал
- Багуудын хариултаа баримтад тулгуурлан дэлгэрүүлэн тайлбарлаж буй байдал
- Сэдэв, агуулгатай холбоотой асуудал дэвшүүлж, ухааран ойлгож буй байдал

## Багшид өгөх нэмэлт зөвлөмж

*Сурагчдын оролцоог хангах:*

Сурагчийн идэвх, оролцоог багш ажиглалтын дараах хуудсаар үнэлж болох юм. Ажиглалтын хуудсыг хөтөлснөөр сурагчдын оролцоог хангахад чухал ач холбогдолтой байх юм, “1” үйл ажиллагаанд оролцсон сурагчийн байршлын хажууд “1+”, тухай үйл ажиллагаанд өмнөх сурагчаас арай өөр хэлбэрээр оролцсон бол сурагчийн хажууд “1√” гэж тэмдэглэх байдлаар “2”, “3” үйл ажиллагаанд гэх мэтээр тэмдэглэх юм.

*Зураг 3. Ажиглалтын тэмдэглэл*




## Нэмэлт даалгавар:

*Зураг 4. Ажлын хуудас*

Зургийг сайтар ажиглан зураг дээрх хүмүүст хэрэгтэй байгаа гэрлийг (чийдэнг) олж холбоорой.





Хүмүүс ямар ажил мэргэжил эрхэлдэг болох, юу хийж байгаа зэргээс хамааран хүний хэрэгцээ өөр өөр байдаг байна гэдгийг ойлгох юм.

## СУУРЬ БОЛОВСРОЛ

**Хичээлийн жишээ:** 9 дүгээр анги

*Хүснэгт 5.Суралцахуйн зорилт ДИБ-ын суралцахуйн зорилт, сэдэв харгалзах байдал*

*ДИБ-ын сэдэв* → Ялгаатай байдалд хүндэтгэлтэй, зохистой хандах

*ДИБ-ын суралцахуйн зорилт* ↓ Ялгаатай болон олон талт байдлын бэрхшээл ба ашиг тусын талаар мэтгэлцэх

*Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт* ↑ Үндэсний хэв загварыг тусгасан бүтээл хийх хэрэгцээг тодорхойлж, анхны санаагаа гаргах

“Үндэсний хэв загвар тусгасан бүтээл хийх хэрэгцээг тодорхойлж, анхны санаа гаргах” гэсэн энэхүү суралцахуйн зорилтын хүрээнд сурагчдад өөрийн хийх эдлэлээ зорилготойгоор сонгож, хэрэгцээг илрүүлж, анхны санаа гаргах явцдаа үндэсний, соёлын онцлог шинжүүдийг хүндэтгэх, ялгаатай байдалд зохистой хандах, бусадтай хамтран ажиллах чадварыг нь хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ба энэ нь ДИБ-той холбогдох тал болно.

**Хичээлийн сэдэв:** Миний санаа

**Арга зүйн төлөвлөлт**:

**Хичээлийн зохион байгуулалт:** Анги зохион байгуулалтыг ТОЙРОГ хэлбэрээр явуулна.

Энэ хэлбэрээр зохион байгуулснаар

- Сурагчид өөд өөдөөсөө харж элдэв хаалтгүй, шууд харьцах боломжтой.
- Сурагчид хичээлийн төгсгөлд хосоор ажиллах боломжтой.

- Багш сурагч нэг бүрт хүрч ажиллах боломжтой.
- Багш сурагчдын дунд сууснаар албархуу байдал арилж, багшийн үүрэг багасч, сурагчдын оролцоог нэмэгдүүлдэг.



## 1. Зорилгоо тодорхойлох үе шат:

***Багшийн санамж:***

Эзэмшүүлэхэд чиглэсэн чадвар

Үндэсний хэв загвар тусгасан бүтээл хийх зорилгоо тодорхойлох

Үндэстний, соёлын онцлог шинжүүдэд хүндэтгэлтэй, зохистой хандах

Улс, үндэсний хувцас, эд хэрэглэлээс өөрийн хийх эдлэлийг зорилготойгоор сонгохдоо улс үндэснийхээ өв соёл, уламжлалт технологиос суралцах хүсэл эрмэлзлэлийг сурагчдад төрүүлэхэд чиглүүлж нэмэлт мэдээлэл, тайлбар хийж болно.

## Даалгавар 1.

Багш даалгаврыг хэрхэн гүйцэтгэх талаар тайлбарлан сурагч бүрт ажлын хуудас тараан өгнө.

*Зураг 4. Ажлын хуудас*

Доорх зургуудыг ажиглаад хүснэгтэд өгөгдсөн даалгаврыг гүйцэтгээрэй.



*Зураг 1*



*Зураг 2*



*Зураг 3*



*Зураг 4*



*Зураг 5*



*Зураг 6*



*Зураг 7*

| | | | |
|---|---|---|---|
| Үндэсний хувцас, эд зүйлсийн нэрийг бичнэ үү. | Аль улс, үндэстний хувцас, эд зүйлс вэ? Нэрийг бичнэ үү. | Доорх хувцас, эд зүйлсийг хялбар хийцтэйгээс нь эхэлж 1-7 хүртэл эрэмбэлж дугаарлана уу. | Төслийн ажлаар өөрийн хийх эдлэлийг сонгож, яагаад сонгох болсон шалтгаанаа тайлбарлаж бичээрэй. |

## 2. Хэрэгцээгээ илрүүлэх үе шат:

**_Багшийн санамж:_**

*Эзэмшүүлэх чадвар:*

*Хийх эдлэлийн хэрэгцээг илрүүлж учир шалтгааныг олох*
*Ялгаатай байдлыг дэмжих*

Сурагчдын хүсэлсонирхолд тулгуурласан бүтээлийн эрэлт хэрэгцээг илрүүлэхдээ бусдын ялгаатай санал бодлыг сонсож, ойлгож, хүндэтгэлтэй хандаж, учир шалтгааныг тайлбарлах боломж олгох зорилготой КАРТ-ын аргыг сонгосон.

### Даалгавар 2.

- Сурагч бүрт карт /цаас /өгнө.
- Сурагчид картан дээр Даалгавар 1-ийн үр дүнд тодорхойлогдсон сонгосон эдлэлийн нэрийг бичнэ.

*КАРТ*
*Даалгавар 1-ийн үр дүнд тодорхойлогдсон сонгосон эдлэлийн нэрийг бичнэ үү.*
.......................................................................................................................................

- Цаасаа цагийн зүүний дагуу чиглэлээр дамжуулна. Сурагчид картыг ирэнгүүт уншиж үзээд сонгосон эдлэлийн санаа хэрэв өөрт таалагдсан, ач холбогдол бүхий байвал "√" гэж тэмдэглэн дараагийн хүндээ шилжүүлнэ.
- Сурагчийн өөрийнх нь карт өөрт нь эргэж ирэхэд хүн бүр бүх хүний саналтай танилцах бүрэн боломжтой болно.
- Олон удаа тэмдэглэгдсэн картуудыг ялгаж сонголтын талаар ярилцана.
- Ингэж сонгоход чамд юу нөлөөлөв? гэсэн асуултыг сурагчдад тавьж тэднийг нухацтай бодуулж, цаадах учир шалтгааныг гаргаж баримт нотолгоотой тайлбар өгөхөд нь багш чиглүүлнэ. Бусад сурагчид тухайн санааны талаар өөр өөрийн өнцөг, байр суурinaас авч үзэх боломж олгох байдлаар Яагаад чамд энэ санаа таалагдсан бэ? Чи ямар зүйлийг олж харсан бэ? гэсэн асуулт тавьж хариулт авна.

**_Багшийн санамж:_**

*Багшийн хамгийн гол зорилго бол тайлбарыг олох, үндэслэлтэй батлах, бусдын ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандаж учир шалтгааныг олоход сурагчдад дэмжлэг үзүүлэх явдал юм.*

## 3. Анхны санаагаа илэрхийлэх үе шат:

**_Багшийн санамж:_**

*Эзэмшүүлэх чадвар:*

*Хийх эдлэлийн анхны санаагаа илэрхийлэх, сайжруулах*
*Сурагчид өөрөөсөө ялгаатай бусадтай хамтран ажиллах*

Энэ үе шатанд сурагч бүр хийх эдлэлийн анхны санаагаа зурган болон бичвэр хэлбэрээр

илэрхийлнэ. Хувилбартайгаар ч илэрхийлж болно.

Багш сурагчдад бодлынхоо дагуу ямар нэг саадгүйгээр төрсөн санаагаа зурах, бичих хугацааг тооцож өгнө.

Сурагчдыг хос хосоор нь хуваарилан, тухайн даалгавар дээр ажиллах зааварчилгаа өгнө.

Даалгаврыг гүйцэтгэх явцад сурагчид өөрийн шийдэл, санаагаа чөлөөтэй илэрхийлж, бусдаас суралцах, бусдын ялгаатай санал бодлыг хүндэтгэн сонсох, хамтарч ажиллах бололцоотой болно.

### Даалгавар 3.

*Зураг 5. Ажлын хуудас.*

.... ангийн сурагч ...............................

**АЖЛЫН ХУУДАС**

1. Хийх эдлэлийн анхны санаагаа бичгэн болон зургаар илэрхийлээрэй.

..............................................................................................

..............................................................................................

..............................................................................................

..............................................................................................

..............................................................................................

**Үнэлгээний хуудас**

1. Шалгуурын дагуу өөрийн анхны санаагаа үнэлээрэй.
2. Найзынхаа төслийн ажлаар хийхээр сонгосон эдлэлийн санааг шалгуурын дагуу үнэлж, санал бодлоо хэлж, зөвлөгөө өгөөрэй.
3. Найзынхаа санал, зөвлөгөөний дагуу анхны санаагаа сайжруулаарай.

Зөвлөгөө өгсөн..........................

***Багшийн санамж:*** *Сурагчид өгөгдсөн шалгуурт илүү тохиромжтой, нийцтэй зүйл нь юу болох, нийцгүй зүйл нь юу болох тал дээр дүгнэлт хийн үнэлж, зөвлөгөө өгөхөд чиглүүлж зааварчилгаа өгнө.*

## БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

**Хичээлийн жишээ:** 10 дугаар анги

*Хүснэгт 6. Суралцахуйн зорилт ДИБ-ын суралцахуйн зорилт, сэдэв харгалзах байдал.*

**ДИБ-ын сэдэв**

Ялгаатай байдалд хүндэтгэлтэй, зохистой хандах

**ДИБ-ын суралцахуйн зорилт**

- Дэлхийн идэвхтэй иргэн байж, өөрийгөө болон нийгмийг хэрхэн өөрчлөхөд суралцах
- Үндэстэн орон нутагт тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийх
- Нийгмийн ялгаатай бүлгүүдийн дунд энхтайванчаар оршин амьдрах

Тээглүүрт механизмын ач холбогдол хэрэглээг ойлгох

**Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт, хичээлийн сэдэв**

Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилт, ДИБ-ын суралцахуйн зорилт ба сэдвийн дээрх харгалзуулсан байдлыг үндэстэн орон нутагт тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийх, асуудалд бүтээлчээр хандах замаар тухайн агуулгын хүрээн дэх мэдлэг чадвар, ойлголтоо нэмэгдүүлэхийн хамт дэлхийн идэвхтэй иргэн байж, өөрийгөө болон нийгмийг өөрчлөх эрмэлзэлтэй болох нь ДИБ-тэй холбогдох тал юм" гэж авч үзэв.

*"Тээглүүрт механизмын ач холбогдол хэрэглээг ойлгох"* гэсэн энэхүү суралцахуйн зорилтын хүрээнд сурагчид орон нутагт тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийх, асуудал дэвшүүлэн хэлэлцэх ба механизмын ажиллах зарчимд үндэслэн худгаас ус татах төхөөрөмжийн анхны санаа гаргах замаар тээглүүрт механизмын ач холбогдол хэрэглээг ойлгох юм.

**Хичээлийн сэдэв:** Тээглүүрт механизмын ач холбогдол

### Арга зүйн төлөвлөлт

Сургалтын зохион байгуулалтын хэлбэр:Хэсгээр (Суралцагчдыг 5-6-аар нь баг болгон зохион байгуулна).

**Хичээлийн хэрэглэгдэхүүн:**
Дамжуулгын механизмууд, Интернэт сайтууд, Баримт мэдээлэл

**Сэдэлжүүлэх үе шат:**
Сурагчид зураг ажиглан дараах асуултын дагуу ярилцаж хариулт өгнө.(Багийн гишүүн бүрт өөр өөр зураг өгнө)

- Чи юу харж анзаарсан бэ?
- Тухайн зурагт ямар үйл явдал болж байна вэ?

- Зурагтай холбоотой ямар нэг асуулт чамд төрөв үү?
- Багийн гишүүдийнхээ нийтлэг хариулт нь юу байгааг илрүүлэн хэлнэ үү.

*Зураг 6. Тараах материал.*

*Зураг №1*



*Зураг №2*




*Зураг №3*




*Зураг №5*

Худгаас ус татаж буй Судан эрчүүд.



Африкийн Сахель дахь ган гачигаас үүдсэн хямрал. Чилла тосгоны эрэгтэйчүүд хүүхдүүд мал услахад зориулж худгаас ус татаж байна. Энэ худгийг 20 хүн 7 хоногийн дотор ухжээ. *Зураг №6*



**Даалгавар 1.** Гар аргаар худгаас ус татахын эерэг болон сөрөг талыг багаараа ярилцаж, санаагаа нэгтгэн бичнэ.

*Зураг 7. Ажлын хуудас*

| Эерэг тал | | Сөрөг тал |
|---|---|---|
| | Гараар худгаас ус татах | |

Видео бичлэг үзүүлж ярилцана. (Эх сурвалж: *https://www.youtube.com/watch?v=LdvysdJJXW0)*

*Зураг 8. Дамжуулгын механизм.*



## Даалгавар 2

Баг тус бүр тухайн орчинд дүн шинжилгээ хийх, ямар нэгэн эрчим хүчний эх үүсвэргүй нөхцөлд худгаас ус гаргах талаар ярилцах.

Баг тус бүр тээглүүрт болон бусад дамжуулгын механизмын тусламжтай ус татах төхөөрөмжийн тойм зураг төсөл гаргах.

- Онол арга зүйд туслах
- Багш явцын зааварчилгаа өгөх
- Багийн гишүүдийн оролцоог хангаж ажиллах талаар багуудад зөвлөх

*Зураг 9. Ажлын хуудас*

д/д Өгөгдөл | Тойм зураг

1 


Дараах механизмуудаас сонгон худгаас ус гаргах төрөөрөмжний тойм зураг гаргаарай.

2 

Жишээ :






3 


4 


**Даалгавар 3.** Багийн гишүүд ажлын хуудсанд хийсэн даалгаврын гүйцэтгэлийг бусаддаа танилцуулах, ярилцах

| д/д | Асуулт | Сурагчийн бодол |
|---|---|---|
| 1 | Энэ бүтээл хэнд хэрэгтэй вэ? Яагаад? | |
| 2 | Тээглүүрт механизм түүний ач холбогдлыг тайлбарлаарай. | |
| 3 | Гараар татаж ус гаргасанаас төхөөрөмж ашиглаж ус гаргах нь ямар давуу талтай вэ? | |

## Өөрийгөө үнэлэх хуудас:

Хичээлээр мэдэж авсан зүйлээ товч бичээрэй.

.........................................................................................................................

## *Багшийн үнэлгээ:*

Багш хичээлд идэвхтэй оролцох, ярих, хариулах байдлыг үнэлнэ.

***Нэмэлт мэдээлэл***: Малчид болон мал сүргийн 60 хувийн усны хэрэглээг гар худгаас хангаж байна. Манай улсад 2017 оны байдлаар нийт 4300 гол горхи, 2920 орчим нуур, ус тоологдсон байна. Харин хүн ам болон бэлчээрийн зориулалттай 30 мянга гаруй худгийг ашиглаж байгаа юм. Монгол улс 60 сая толгой малтай үүний 60%усны хэрэглээг гар худаг дангаараа хангадаг.

Агуулгын хүрээнд багшид зориулсан мэдээлэл: *Зураг 9. Дамжуулгын механизмын ангилал*



### Ашигласан ном, гарын авлага


БСШУЯ. (2014). Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ. 82.
БСШУЯ. (2015). Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ. 100-109
БСШУЯ. (2016). Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ. 82.
Юнеско. (2016).Тогтвортой хөгжлийн зорилго 4- боловсрол 2030- ийг дэлгэрүүлэн ойлгох нь гарын авлага УБ. 10.
Юнеско. (2015).Дэлхийн иргэний боловсрол, сэдвүүд ба суралцахуйн зорилтууд. (орчуулгын материал., 2017) УБ. 31-45
Санжаабадам.С., нар. (2017). Дэлхийн иргэний боловсрол, багшид зориулсан гарын авлага. УБ.Соёмбо принтинг.
Данида төсөл. (2000).Идэвхтэй сургалтын зуун нэгэн арга.УБ.Боловсролын хөгжлийн сургуулийн хэвлэх цех.
Чулуунаа.Г нар. (2016). "Дизайн технологи IX" сурах бичиг., УБ. 34-48.
Чулуунаа. Г нар. (2016). "Дизайн технологи IX" багшийн ном., УБ. 25-39.
(2017). Иргэний нийгмийн үндэсний эвсэл.Бүх нийтийн боловсролын төлөө: Нийгмийн ялгаатай байдлыг сургалтын хөтөлбөр, сурах бичигт тусгах удирдамж, УБ. 8-9.
*https://www.youtube.com/results?search_query=Jobs+and+Occupations*
*https://www.pinterest.co.uk/pin//*
*https://www.google.mn/*
https://www.youtube.com/watch?v=LdvysdJJXW0

# ГАРИГ ДЭЛХИЙ

## МОНГОЛ ХЭЛ

Монгол хэлний хичээлийн агуулга арга зүйгээр дамжуулан суралцагчийн дэлхийн иргэний боловсролын чадварыг хөгжүүлэх нь

**Суралцахуйн зорилт:** Хүн төрөлхтний нэг гишүүн би дэлхийн иргэн гэдгээ ухааран, орон нутаг, улс үндэстэн, дэлхий ертөнцтэй харилцан уялдаатайг ойлгон бусдын соёлыг хүндэтгэн, тэсвэр тэвчээртэй байх чадварт суралцах.

*Хүснэгт 1. Монгол хэл, 5 дугаар анги*

| | |
|---|---|
| Монгол хэлний хичээлийн хөтөлбөр дэх холбогдох агуулга | - Хэрэглээний эх унших, нэг сэдвийн талаарх ялгаатай үзэл бодлыг харьцуулж дүгнэх |
| Монгол хэлний хичээлийн хөтөлбөр дэх холбогдох чадвар | - Асуудлыг сэтгэгдэл, үзэл бодолтойгоо холбон олон талаас нь эргэцүүлэх<br>- Бусдын яриаг анхааралтай сонсох, харсан сонссоноо задлан шинжилж тайлбарлан загварчлах |
| Дэлхийн иргэний боловсролын чадвар | - Хүний эрхэм сайхан чанар, зан аашийг ялгах, өөрийн зан суртахууныг эргэцүүлэн бодох, шүүмжлэлтэй хандах<br>- Бусдыг ойлгон, бусдын байранд өөрийгөө тавьж эргэцүүлэн тэсвэр тэвчээртэй зан чанарт суралцах |
| Үйл ажиллагаа (хувилбар) | - Сэдэлжүүлэх тоглоом тоглонгоо өөрийгөө эргэцүүлэх<br>- Хүн төрөлхтний нэг гишүүн би дэлхийн иргэн гэдгээ ойлгон ухаарах<br>- Орон нутаг, улс үндэстэй, дэлхий ертөнцийн харилцан хамаарал уялдаатайг ойлгон бусдын соёлыг ойлгох |
| Арга зүй | - Мэдээллийн эх сурвалжтай ажиллах<br>- Харьцуулалт, дүн шинжилгээ хийх<br>- Хосоор, багаар ажиллах арга |
| Ашиглах материал, хэрэглэгдэхүүн | - Мэдээ, фломастер, самбарын цаас, цавуутай цаас, өндөг |
| Үнэлэх хэлбэр ба шалгуур | Үнэлэх хэлбэр:<br>Өөрийн үнэлгээ-бодол, мэдрэмж, ухаарал, туршлагаа хуваалцаж ярилцах<br>Багшийн үнэлгээ- явцын ажиглалт, тэмдэглэгээ<br>- Бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандаж буй байдал<br>- Бусдын ялгаа онцлогийг ойлгож, хүндэтгэж буй байдал<br>- Бусдын сайн сайхны төлөөх хандлага |

| | |
|---|---|
| Багшийн анхаарах зүйл | - Багш урьдчилан үйл ажиллагаа тус бүрд хэрэглэх материалуудыг бэлтгэсэн байна.<br>- Багш хичээлийг удирдан чиглүүлэхдээ суралцагчид өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, бие биенийхээ үзэл бодолд хүндэтгэлтэй хандах, хүлээн зөвшөөрөх, багийн ажилд хариуцлагатай бүтээлч оролцох арга барилд суралцуулахад онцгой анхаарч орчныг бүрдүүлнэ.<br>- Асуудлыг сэтгэгдэл, үзэл бодолтойгоо холбон олон талаас нь эргэцүүлж, бусдын яриаг анхааралтай сонсох, харсан сонссоноо задлан шинжилж тайлбарлан загварчлангаа хүний эрхэм сайхан чанар, зан аашийг ялгах, өөрийн зан суртахууныг эргэцүүлэн бодох, шүүмжлэлтэй хандах, бусдыг ойлгон, бусдын байранд өөрийгөө тавьж эргэцүүлэн тэсвэр тэвчээртэй зан чанарт суралцахад чиглүүлэхэд анхаарна. |

*Хүснэгт 2. Монгол хэлний хичээлээр дамжуулан сурагчдын тэсвэр тэвчээртэй байх чадварыг хөгжүүлэх хөтөлбөр*

| | | | |
|---|---|---|---|
| Хичээлийн нэр | Монгол хэл | | |
| Хичээлийн сэдэв | Бидний давуу тал | | |
| Хичээлийн зорилго | - Хүн тэсвэр тэвчээртэй байхын ач холбогдлыг ухаарах, мэдрэх<br>- Өөрийн зан чанарын онцлог, хүсэл сонирхол, ур чадвар, давуу ба сул тал, байр суурь гэх мэт өөрийн талаарх ойлголтоо батлатгах, бусдаас суралцах<br>- Тоглоомоор дамжуулан дэлхийн иргэний боловсролын анхны ойлголттой болох | | |
| Үе шат | **Ойлголт болон аргачлал** | | **Хэрэглэгдэхүүн** |
| I<br>**Дэлхийтэй өөрийгөө холбох** | **Тоглоом 1:**<br>"Өндөгний хальсыг хагалах"<br>1. Чанаж болгосон өндөгний хальсан дээр фломастраар зураг зурна.<br>2. Зурсан өндөгнүүдээ нэг сагсанд цуглуулж хийнэ.<br>3. Бүх сурагчид хийсний дараа тогтоосон хугацааны дотор (1мин)сагсан дотроос өөрийн өндгөө олж авна. Багш сүүлчийн хүүхдийн авсан хугацааг тэмдэглэнэ<br>4. Зурсан өндөгний хальсыг салгаад дахин сагсанд хийхийг хүснэ.<br>5. Мөн тогтоосон хугацааны дотор өөрийн өндгийг олж авахыг хүснэ. | "Өндөгний хальсыг хагалах" тоглоом тоглосны дараа:<br>• *Мэдсэн , мэдэрсэн зүйлээ болон өөрт бодогдсон зүйлээ чин үнэнээр нь бичээрэй. Яриарай* | <br> |

| | | | |
|---|---|---|---|
| I<br>**Дэлхийтэй өөрийгөө холбох** | *Тэд авч чадах болов уу?*<br>*Багш сүүлчийн хүүхдийн авсан хугацааг тэмдэглэнэ.*<br>1. 5-р алхамд өөрийн өндгийг олоход яагаад хэцүү байсан, эсвэл олж чадаагүй тухай ярилцах. | Тэдний ойлголт:<br>*Нэгэн дээвэр дор (Дэлхий дээр) амьдарч буй хүмүүс зүс царай, хэл яриа, өнгөөрөө ялгаатай ч бид бүгд ижил зүрх сэтгэлтэй хүүхэд, хүн, хүмүүс юм.*<br><br>***Тиймээс бид хүн төрөлхтний нэг гишүүн ба Дэлхийн иргэн юм.*** | Хүүхэд бүрийн тоогоор чанасан өндөг бэлтгэх ба өөрсдөөр нь авчруулж болно. Мөн багш 2-4 өндөг авчирна. Нөхцөл байдалд багш уян хатан зохион байгуулалт хийнэ.<br>• Өндгөн дээр ямар нэгэн зүйл зурах<br>• Өөрийнхөө өндгийг хайх цагийг багш тооцоолно. Бичиж тэмдэглэнэ.<br>• Зурсан өндгөө олж авсан ба хальсалсан өөрийн өндгөө олж авсан цагийг харьцуулах |
| II<br>**Асуудлыг ойлгох, санал нэгдэх** | Орчлон ертөнц нэгдмэл уялдаатай болохыг мэдэрч, тэгснээр Дэлхийн хаана ч дасан зохицож амьдрах чадвартай иргэн болох талаар санаа бодлоо хуваалцана.<br><br>**Даалгавар 1:**<br>• Буриад, халх, англи хэл дээр тэсвэр тэвчээр, хатуужил гаргасан нэгэн иргэний идэвхтэй оролцооны тухай телевизийн мэдээг үзүүлж сонирхуулна. *(Видео бичлэг, кейс сонсгох)*<br><br>• **Ажиглалт судалгаа 1:** Бичлэг болон кейс сонсож байх үед сурагчдын оролцоог багш тэмдэглэнэ. Загвар хавсаргав.<br><br>Нэгдсэн ойлголт:<br>Буриад, казак хэл = үндэсний цөөнхийн хэл<br>Халх аялга = монгол улсын үндэсний хэл<br>Англи хэл = дэлхийн хэл | Чиглүүлэг:<br>- 3 мэдээний талаарх өөрсдийн бодол санаа, юуг ойлгосон тухай харилцан ярилцана.<br>- Бусдын бодлын талаар дахин өөрийн бодол санааг хэлнэ.<br>- Энэхүү мэдээ нь чамд хэрхэн нөлөөлж байна вэ?<br>- Буриад хэлээр уншсан мэдээг сонсоход ямар мэдрэмж төрсөн бэ?<br>- Халх аялгаар уншсан мэдээг сонсоход харин ямар санагдсан бэ?<br>- Дээрх мэдээг англи хэлээр уншсаны учир шалтгаан юу вэ? | ТҮ, проектор, дуу өсгөгч<br><br>Мэдээг дүрсжүүлсэн бичлэг<br><br>Мэдээг цаасаар хэвлэж бэлтгэх<br><br>Веннийн диаграммаар харьцуулж үзүүлж болно. |

<table>
<tr>
<td>III<br>**Шийдвэрлэх арга зам эрэлхийлэх**</td>
<td>▪ Гурван хэл дээрх мэдээг сонсоход өөрсдөд нь мэдрэгдэж буй эерэг ба сөрөг талууд хэрхэн илэрч байгаа талаар чөлөөтэй яриулах<br>▪ Бусдад эерэг, сайн нөлөө үзүүлэхийн тулд шаардлагатай зүйл юу болох талаар бодуулах<br>▪ Бид хэрхэн шийдэж болох вэ?<br><br>**Дадлага 1:**<br>▪ “Давуу талын худалдаа” тоглоом тоглоцгооё.<br>Тоглоомын зорилго: Гурван мэдээг сонсох үед өөрт илэрсэн давуу ба сул талыг ялган таних, өөртөө итгэх итгэлээ нэмэгдүүлэх<br>1. Ижил энгийн 4 цаас тус бүрт өөрт байгаа 4 давуу талыг бичнэ.(Цаасны дээд хэсэгт өөрийн нэрийг заавал бичих)<br>2. Өөр энгийн 4 цаасан дээр найз нар дээрээ очин давуу талыг нь бичиж солилцоно.<br>3. 8 цаас бүр дээр давуу талуудыг бичсэний дараа хөгжмийн аянд найз нартайгаа давуу талуудаа солилцох. (Найзынхаа давуу талыг сонсоод дэлгэрэнгүйгээр магтаж өгөөд солилцох, нэг найзтайгаа л нэг давуу талаа солилцохыг анхаарах)<br>4. 8 төрлийн давуу талаа бүгдийг солилцоод байрандаа очно.<br>5. Энгийн цаасан дээрх давуу талуудаас хамгийн ихээр өөрийн болгохыг хүсэж байгаа давуу тал юу болох, хэнээр бичүүлсэн давуу тал болох, яагаад энэ давуу тал сэтгэлд нийцэж байгаа тухайгаа ярих</td>
<td>Чиглүүлэг асуулт:<br>▪ Мэдээний аль хэсгээс сонирхохоо больсон бэ?<br>▪ Яагаад өөр зүйл хийхэд хүргэсэн гэж бодож байна?<br>▪ Тухайн үед өөрийгөө хянаж, удирдаж чадсан уу?<br>▪ “Давуу талын худалдаа” тоглоом ба чиглүүлэг асуултаас<br><br>*Тэдний ойлголт:*<br>*Энэхүү тоглоомоор дамжуулан өөрийн сайн, муу талыг мэдэж, энэ нь эргээд бидний шийдэх асуудал болж байдгийг ойлгох.*<br>*Өөрөөр хэлбэл : Анги хамт олон → Сургууль → орон нутаг → Улс орон дэлхийн иргэдээ хүлээн зөвшөөрч, харилцан ойлгох, хүлцэн тэвчиж аюулгүй ертөнцийг бий болгоход өөрийн хувь нэмэр хамгаас чухал гэдгийг ухаарах*</td>
<td>• Хүн бүрт ватуум цаас, тэмдэглэл хөтлөх цавуутай цаас 8 ш<br>• Хоорондоо ялгаатай 2 энгийн цаас<br>• Сурагчдын сонирхолд нийцсэн ая бэлдэх<br><br></td>
</tr>
<tr>
<td rowspan="4">IV<br>**Өөрийгөө үнэлэх**</td>
<td>▪ Хичээлийн төгсгөлд өөрсдийн бодлыг бусадтайгаа хуваалцана.</td>
<td colspan="2">Мэдээг үзэж дуустал бусдыгаа хүлээн зөвшөөрч хүндэтгэн,тэсвэр тэвчээр гаргасан сурагчдын давуу талуудаар бахархах</td>
</tr>
<tr>
<td rowspan="3">Өөрт мэдрэгдсэн өөрчлөлт, ойлголтыг зөв тэмдэглэгээгээр тэмдэглэнэ үү.</td>
<td colspan="2">Дэлхийн улс орон, хүн амын хоорондын харилцаа</td>
</tr>
<tr>
<td colspan="2">Бид хүн төрөлхтний нэг хэсэг гэдгийг мэдрэх</td>
</tr>
<tr>
<td colspan="2">Бид тогтвортой ертөнцийн төлөө идэвхтэй, хариуцлагатай байх</td>
</tr>
</table>

Дадлага 1: Давуу талын худалдаа Нэр............................

1. Танд байдаг 4 давуу талаа бичнэ үү.

2. Найз нартайгаа давуу талаа солилцох үед найзуудынхаа давуу талаас хамгийн их өөрийн болгохыг хүссэн давуу тал юу байсан бэ?

3. Энэхүү тоглоомыг тоглох үед төрсөн сэтгэгдлээ бичнэ үү.

* Танд баярлалаа.

## МОНГОЛ ХЭЛ

Монгол хэлний хичээлийн агуулга арга зүйгээр дамжуулан суралцагчийн дэлхийн иргэний чадварыг хөгжүүлэх нь

**Суралцахуйн зорилт:** Сайхан сэтгэл, өгөөмөр зан, өөрийгөө захирах байдлаа хөгжүүлбэл хүлцэн тэвчих боломжтойг ухаарч, зан үйлийг хэрэгжүүлэх, дадал хэвшил болгохын чухлыг ойлгон хэрэгжүүлэх чадварт суралцах.

**Холбогдох хөтөлбөр:** Монгол хэл

*Хүснэгт 1. Монгол хэл*

| | |
|---|---|
| Монгол хэлний хичээлийн хөтөлбөр дэх холбогдох агуулга | - Үзэл бодлоо илэрхийлэн бичиж сурья<br>- Өөрт хэрэгтэй мэдээллийг цуглуулъя<br>- Далд утгыг таамаглаж тайлбарлая |
| Монгол хэлний хичээлийн хөтөлбөр дэх холбогдох чадвар | - Нэг сэдвийн талаар ялгаатай үзэл бодлыг харьцуулах<br>- Үзэл бодлоо хүлээн зөвшөөрүүлэх үндэслэлээ төлөвлөх<br>- Эхээс өөрт хэрэгтэй мэдээллийг цуглуулах, танилцуулах<br>- Нэг сэдвийн хүрээнд харсан, сонссон хэд хэдэн зүйлийг харьцуулж нэгтгэн дүгнэх<br>- Далд утгыг таамаглаж тайлбарлах |
| Дэлхийн иргэний боловсролын чадвар | - Мэдээллийн олон эх сурвалжтай ажиллан мэдлэг ойлголтоо цэгцлэн, бусадтай хуваалцах, дүгнэлт хийх, нийтэд мэдээлэх чадвараа хөгжүүлэх<br>- Хүмүүсийн ялгаатай байдал, арьс өнгө, шашин шүтлэг, үзэл бодлыг хүндэтгэх дэлхийн иргэний чадвараа нэмэгдүүлэх<br>- Сошиал, медиа, портал сайт, фэйсбүүкийн баталгаагүй мэдээлэлд анализ дүгнэлт хийх, нэг мэдээллийг өөр өөр хувилбараар хүргэж байгааг хэлэлцэх |
| Үйл ажиллагаа (хувилбар) | - Оюуны довтолгооны аргаар хоол хүнстэй холбоотой өөрсдийн мэдэх зүйлийг түлхүүр үгээр гаргуулна.<br>- Бага, дунд, ахлах ангид агуулгын хүрээнд гүнзгийрэн өргөсч хоол хүнстэй холбоотой агуулга жэндэр, хүний эрх, шашин шүтлэгтэй холбоотой гарч ирнэ<br>- Түлхүүр үгээр гаргаж ирсэн ойлголтоос хосоор, багаар, ангиараа ярилцан судлах 3 чиглэлийг сонгоно.<br>- Сонгосон чиглэлийн хүрээнд ажлын төлөвлөгөө гарган мэдээллийн эх сурвалжаас мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүгнэх тайлагнах үйл явцыг хийнэ.<br>- Тодорхой арга зүй, шалгуурыг боловсруулна. |
| Арга зүй | - Оюуны довтолгооны арга<br>- Зэрэгцүүлсэн тэмдэглэл хөтлөх арга<br>- Матриц арга<br>- Эх сурвалжтай ажиллах арга<br>- Постер бэлтгэх арга |
| Ашиглах материал, хэрэглэгдэхүүн | - Хэрчмэл үг, хоол хүнстэй холбоотой тодорхой эх сурвалж |

| | |
|---|---|
| Үнэлэх хэлбэр ба шалгуур | Үнэлэх хэлбэр:<br>Өөрийн үнэлгээ-ажлын төлөвлөлтийн дагуу<br>Багшийн үнэлгээ- явцын ажиглалт<br>- Мэдээллийн эх сурвалжтай ажиллаж буй байдал<br>- Мэдээллээ боловсруулах шалгуураа багаар гаргаж буй байдал<br>- Мэдээллээ нэгтгэн дүгнэж, тайлагнаж буй байдал<br>Эцсийн үнэлгээ: Дүгнэж тайлагнаж буй байдал, өөрсдийгөө эргэцүүлэн бодож бусдыг хүндэтгэж буй хандлага, бусдын ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандан хамтран ажиллаж буй байдал |
| Багшийн анхаарах зүйл | Багш хичээлийг удирдан чиглүүлэхдээ суралцагчид өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, бие биенийхээ үзэл бодолд хүндэтгэлтэй хандах, хүлээн зөвшөөрөх, багийн ажилд хариуцлагатай бүтээлч оролцох арга барилд суралцуулахад онцгой анхаарч орчныг бүрдүүлнэ.<br>- "Хоол хүнс"- тэй холбоотой түлхүүр үгээр гаргасан ойлголтоос сонгон мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүгнэн тайлагнах явцыг удирдан чиглүүлэхдээ тодорхой шалгуур гарган чиглүүлэхэд анхаарна. |

**Загвар төлөвлөлт:** Ерөнхий төлөвлөлттэй танилцан тухайн ангид ээлжит хичээлийн төлөвлөлтийг багш монгол хэлний хичээлтэй холбон хийх боломжтой.

*Хүснэгт 2*

| Түвшин | Бага | Дунд | Ахлах |
|---|---|---|---|
| Үнэт зүйл | Аяганы хариу өдөртөө<br>Агтны хариу жилдээ | Яаравч явж иддэггүй, Жаргавч хэвтэж иддэггүй | Гэнэт идвэл гэдсэнд цөвтэй, Гэнэт баяжвал насанд цөвтэй |
| Сэдэв | • Орц найрлага<br>• Эрүүл ахуй<br>• Ёс заншил | • Ажиллах хүчин<br>• Соёл<br>• Мөнгө, санхүү | • Эрчим хүч<br>• Тээвэрлэлт<br>• Хүний эрх |
| Товч агуулга | Хоол хүнсний /тодорхой нэг хоолыг сонгон/ орц найрлага, эрүүл ахуй, ёс заншилтай холбоотой мэдээллийг олон эх сурвалжаас цуглуулан авчирч, тодорхой шалгуурын дагуу боловсруулалт хийнэ | Хоол хүнстэй холбоотой соёл, ажиллах хүчин, мөнгө санхүүгийн талаарх мэдээллийг олон эх сурвалжаас цуглуулан авчирч, тодорхой шалгуурын дагуу боловсруулалт хийнэ. | Хоол хүнстэй холбоотой хүний эрх, эрчим хүч, тээвэрлэлтийн талаар тодорхой мэдээллүүдийг олон эх сурвалжаас цуглуулан авчирч, тодорхой шалгуурын дагуу боловсруулалт хийнэ. |
| Хамаарах эрх | Хувийн аюулгүй байдлаа хангуулах эрх | Нийгмийн хамгаалал авах эрх | Хүний эрхийг хүндэтгэх |
| Зорилго | Хоолны орц найрлага, эрүүл ахуй, орон нутаг, улс үндэстний ялгааг мэдсэнээр хүмүүсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх чадварт суралцана. | Хоол хүнсний үйлдвэрлэл, ажиллах хүчний талаар судлангаа бусдын байр суурינд өөрийгөө тавих бусдын хөдөлмөрийг хүндэтгэх, хүмүүсийн ялгаатай байдлыг хүндэтгэх зан чанарт суралцана. | Хоол хүнсний үйлдвэрлэл, тээвэр, эрчим хүчний талаар судлангаа улс дамнасан хоол хүнсний үйлдвэрлэл, хүний эрх, шашин шүтлэгийн талаарх ойлголтоо нэмэгдүүлж амьдралын хэв маягаар ялгаатай хүмүүст хүндэтгэлтэй хандах чадварт суралцана. |

| | | | |
|---|---|---|---|
| Сургалтын хэрэглэгдэхүүн | Мэдээллийн эх сурвалж: Ном, сэтгүүл, интернэт, бодит орчин, ахмадууд, кино, бичлэг, сурвалжлага, ярилцлага, гарын авлага, мэргэжлийн байгууллагын судалгаа | | |
| Сургалтын арга | • Мэдээлэл цуглуулах- Зэрэгцүүлсэн тэмдэглэл хөтлөх арга<br>• Мэдээлэл боловсруулах- Матрицын арга | • Мэдээлэл цуглуулах- Эх сурвалжтай ажиллах арга<br>• Мэдээлэл боловсруулах- Постер бэлтгэх арга | • Мэдээлэл цуглуулах- Эх сурвалжтай ажиллах арга<br>• Мэдээлэл боловсруулах- Постер бэлтгэх арга |
| Зааварчилгаа: | - Бодит амьдралтай холбоотой асуудлаас /жишээ болгон хоол хүнс/ өөрсдөө сонгон авч, багаар хамтран хийх арга, алхмаа өөрсдөө төлөвлөнө.<br>- Төлөвлөгөөний дагуу ажиллана, үйлдэнэ.<br>- Ажлынхаа үр дүнг танилцуулж, 3 түвшинд дүгнэнэ. Орон нутаг, улс үндэстэн, дэлхийн хэмжээнд асуудлыг олж харахад чиглүүлнэ. | | |

### Үйл ажиллагаа 1:

Оюуны довтолгооны аргаар "ХООЛ ХҮНС-тэй холбоотой санаануудыг суралцагчдаар нэрлүүлнэ. Хооронд нь холбоосжуулж, зураглал хийж болно. Оюуны зураглал хийнэ. Нөхцөл байдалдаа тулгуурлан багш ямар ч хэлбэрээр гаргаж болно. (Үүсч болох жишиг загварыг хавсаргав (Зураг 1)



## Үйл ажиллагаа 2:

*Хүснэгт 4. Хоол хүнстэй холбоотой цуглуулах мэдээллийн ерөнхий чиглэл*

| № | Түвшин | Хоол хүнстэй холбоотой агуулга | Орон нутгийн хувьд | Улс үндэстний хувьд | Олон улс, дэлхийн хэмжээнд |
|---|---|---|---|---|---|
| 1 | Бага ангид | Орц найрлага<br>Эрүүл ахуй<br>Ёс заншил | - Манай улс, аймаг, суманд амьдардаг үндэстэн ястан, тэдний ёс заншил<br>- Хоолны орц, найрлага улирлаас шалтгаалах нь<br>- Хооллох үеийн эрүүл ахуйн энгийн дадал хэвшил, сургуулийн үдийн цай, хоолны үеийн дэг соёл | - Монгол үндэстний хоол, ёс заншилтай холбогдох нь<br>- Хоолны орц, найрлага улирлаас шалтгаалах нь<br>- Эрүүл ахуйн энгийн дадал хэвшлийг хэрэгжүүлж ирсэн уламжлал | - Япон, Хятад, Орос, Солонгос үндэстний уламжлалт баяр ёслол<br>- Баяр ёслолын үеийн хүндэтгэлийн зоог идээ, орц найрлага, зан заншил, цаг агаартай хэрхэн холбогддог тухай<br>- Хоолны эрүүл ахуйн дадал хэвшил, дэглэмийг орчин үед хэрхэн үзэж байгаа талаар |
| 2 | Дунд ангид | Ажиллах хүчин<br>Үйлдвэрлэл<br>Мөнгө, санхүү | - Манай орон нутаг, бүс нутагт буй хоол үйлдвэрлэлийн ажил үйлчилгээ эрхэлдэг газрууд<br>- Тэдгээрийн ажиллах хүчин, жэндэрийн харьцаа<br>- Ажилчдын хөдөлмөр, ажлын хөлс, хоолны үнэ | - Манай улсын хувьд олонд танигдсан сүлжээ бүхий хоол үйлдвэрлэлийн ажил үйлчилгээ эрхэлдэг газрууд<br>- Тэдгээрийн ажиллах хүчин, жэндэрийн харьцаа<br>- Ажилчдын хөдөлмөр, ажлын хөлс, хоолны үнэ | - Олон улс, дэлхийн хэмжээнд ажиллаж манай улсад хоол үйлдвэрлэлийн үйлчилгээ эрхэлдэг газрууд<br>- Тэдгээрийн ажиллах хүчин, жэндэрийн харьцаа<br>- Ажилчдын хөдөлмөр, ажлын хөлс, хоолны үнэ |
| 3 | Ахлах ангид | Эрчим хүч<br>Тээвэрлэлт<br>Хүний эрх | - Манай орон нутгийн хоол хүнс үйлдвэрлэдэг аж ахуйн нэгж байгууллагын эрчим хүчний зарцуулалт<br>- Хоол хүнсэнд ордог бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт хамгаалалт, чанар<br>- Шашин шүтлэг хоол хүнстэй хамаарах нь /Цагаан хоолтон, ногоон хоолтон/ | - Манай улсын хоол хүнс үйлдвэрлэдэг томоохон аж ахуйн нэгж байгууллагын эрчим хүчний хэрэглээ, зарцуулалт<br>- Хоол хүнсэнд ордог бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт хамгаалалт, чанар<br>- Шашин шүтлэг хоол хүнстэй хамаарах нь | - Дэлхийн хоол хүнс үйлдвэрлэл эрхэлдэг байгууллагын эрчим хүчний хэрэглээ, зарцуулалт, нарны, салхины эрчим хүч ашиглалт<br>- Хоол хүнсний тээвэрлэлт, хадгалалт хамгаалалт, чанар, үйлчилгээ, технологийн хөгжил<br>- Шашин шүтлэг хоол хүнстэй хамаарах нь. |

Үнэт зүйл
Хоол хүнстэй холбоотой зүйр цэцэн үг

- Хүн хоолоор
  Хүлэг өвсөөр
- Давс хийвэл уустал
  Ажил хийвэл дуустал
- Аяганы хариу өдөртөө
  Агтны хариу жилдээ
- Зажилж идвэл хоол болно
  Залгиж идвэл хор болно
- Яаравч явж иддэггүй
  Жаргавч хэвтэж иддэггүй
- Ажил хийвэл ам тосдоно
  Болсон идээнээс бүү буц

- Бадарч явсан газар балагтай.
  Батгана суусан газар өттэй
- Нүдээ байхад нь үз
  Шүдээ байхад нь зажил
- Гэм хийсэн гэдэс биш
  Гэнэт олдсон хоол биш
- Гэнэт идвэл гэсэнд цөвтэй
  Гэнэт баяжвал насанд цөвтэй
- Хоол хороож хоног нөгцөөх
  Цай уух цаг нөгцөөх
- Хоолоо элбэгт нь гамна
  Унагаа тарганд нь гамна

**Та үүнийг мэдэх үү?**

Энэ нь ямар бүтээгдэхүүн, нарийвчлаад ямар тэжээллэг чанартай хоол хүнс надад болон манай гэр бүлд хэрэгтэй ямар хэмжээгээр гэхээс өгсүүлээд хаанаас ямар хүнсний бараа бүтээгдэхүүнийг худалдаж авах, түүнийг хэрхэн боловсруулах, хадгалах вэ гэх мэт энгийн хүн бүрийн мэдэж байх ёстой хэрэглээний соёл болоод байна. Хүнсний бүтээгдэхүүн нь ихэнхдээ ил задгайгаар буюу хайрцаглаж савалсан байдалтайгаар худалдаанд гардаг. Ил задгай байгаа бүтээгдэхүүнийг та сонгож худалдаж авахдаа мэдрэхүйн эрхтэн /амт, үнэр, өнгө, гадаад байдал, биежилт/-ний үзүүлэлтээр, харин сав баглаа боодолтой бүтээгдэхүүнийг түүн дээрх хаяг шошигоос таньж мэдэж болох юм. Бүтээгдэхүүний хаяг шошго бүтээгдэхүүнийг хэрэглэгчтэй холбодог нэрийн хуудас ба /ID/ байдаг болохоор бид хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодолтой бол дээрх хаяг, шошгийг сайн харж, бүрэн бүтэн хайрцаг савтай, хаяг шошготой, он сар хугацаатай бүтээгдэхүүнийг худалдаж авч байх ёстой. Тиймгүй тохиолдолд худалдаж авахаас татгалзаж байх нь зүйтэй юм.

- Эрүүл хүнс гэдэг нь бидний бие махбодын хэвийн өсөлт хөгжилтийг хангахад зориулагдсан, үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлтийн үндсэн шаардлагыг хангасан, хүний эрүүл мэндэд ямар нэг сөрөг нөлөөгүй бүхий л төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг хэлнэ.
- Манай улсын нутаг дэвсгэр 1,5 сая кв км. Малын бэлчээр хадлангийн талбай 120,0 орчим сая га, тариаланд тохиромжтой газар 2,0 сая га. Таван хошуу мал 1990 оноос эхлэн тасралтгүй өсөж, 2015 оны байдлаар 56,0 сая болов. Бүх малын 86,6% нь хонь, ямаа. Буудай, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл тогтворжиж байгаа. Газар нутгийн хэмжээ, мал сүргийн тоо, байгалийн баялгийн нөөцийг тоймлон үзэхэд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр өөрийгөө хангаад зогсохгүй, мах, сүү, үр тариа, төмс, хүнсний ногооны бэлэн бүтээгдэхүүн, малын болон ургамлын гаралтай биологийн идэвхит бэлдмэлийн экспортоор дэлхийн хүнсний зах зээлд оролцох боломжтой. Мах, сүү, өндөгний үйлдвэрлэлт тогтвортой өсч байгаа манай оронд амьтны гаралтай уургийн нөөц байна. Мах сүүний нэг хүнд ногдох үйлдвэрлэлт нь зохистой хэрэглээний жишгээс бараг 2 дахин илүү байна. Гэхдээ хэрэгцээг энэ хэмжээгээр хангаж байгаа гэсэн үг биш. Газар тариалангийн үйлдвэрлэл байгаль цаг уураас хэт хамааралтай ч импортын

хараат байдал багасч байна. Манай улс хүн амын хэрэгцээг мах, махан бүтээгдэхүүн, төмсөөр бүрэн, сүүгээр 92,2%, гурилаар 89,9%, хүнсний ногоогоор 72,7%, өндгөөр 61,7% хангаж харин төрөл бүрийн ундаа, чихрийн зүйл, жимсний хэрэгцээг үндсэнд нь импортоор хангаж байна. Монгол улсын хүнсний бодлого нь Үндсэн хуулийн үзэл санааны дагуу хүний аюулгүй байдал, эрхийг хамгаалах, хүн эрүүл, аз жаргалтай, бүтээлч амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэж, хүнсний эрхзүйн орчин олон улсын зарчмын дагуу бүрдэж байна. Монгол улсад хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр өөрийгөө хангах нөөц, боломж байгаа ч бүрэн ашиглаж чадахгүй, хүнсний үрэгдэл хаягдал их, хүнсний сүлжээнд бүтээгдэхүүний аюулгүй байдлын зөрчил гарсаар байна.  Хүн амын хоол хүнсний талаарх боловсрол дутмаг, амьжиргааны баталгаажих төвшингөөс доогуур орлоготой өрх, ядуу иргэдийн хүнсний эрх зөрчигдөж байгаа нь хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

## Оролцооны арга зүйн талаар зөвлөмж

Оролцооны арга нь хүн бүр өөрийн гэсэн тодорхой түвшин бүхий суралцах чадвартай болохыг хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Оролцоонд тулгуурласан сургалт нь суралцагчид,  багш, сургалтын материалуудын хоорондын идэвхтэй харилцаанд тулгуурласан 3 талт үйл явц юм.

Бүдүүвчээр харуулбал:




Эндээс харахад сургалт нь суралцагч болон багшид хоёуланд нь нөлөөлдөг болох нь харагдаж байна. Багшийн хувьд суралцагчдын байнга өсөн нэмэгдэж буй мэдлэг, чадвар, хандлагын хэрэгцээнд хариулахын тулд идэвхтэй сургалтын стратеги баримтлах шаардлагатай байдаг бол суралцагчдын хувьд багшийн шинэчлэгч байр сууринаас хамааран олон талд сурах барилуудаа хөгжүүлж байдаг.

Суралцагч төвт арга зүйн үндсэн шинж нь:

- Суралцагчийн идэвхтэй оролцоо
- Багшийн зөвлөгч, туслагч байх үүрэг
- Бүлгийн ажиллагаа
- Эрэл хайгуул хийх боломж
- Амьдралын арга ухаанд баримжаалсан байдал
- Сурагчдын хэрэгцээнд тулгуурласан хөтөлбөр
- Хяналт шалгалтад төдийлөн ач холбогдол өгдөггүй байдал
- Бие даан суралцах, эрэл хайгуул хийхэд урам, дэмжлэг өгөх зэрэг байдлаар илэрч байдаг байна.

## НИЙГМИЙН УХААН

**Бэрхшээлийг даван туулсан хүүгийн түүх**

Хүү амьсгалын дутагдалд орж эндэх шахсан ажээ. Хүү амьд гарсан ч төрөлтийн хүндрэлээс болж тархи, нуруу, нугасны саажилттай болжээ. Хүүг төрсөн даруйд эмч нар ээжид нь үрээсээ татгалзахыг санал болгосон гэдэг. Хүүг нь том болоод хэнд ч хэрэггүй нэгэн болж өснө гэж тэд хэлжээ. Гэвч хүү нь ээжийнхээ итгэлийг хөсөрдүүлэхгүйн тулд маш их хичээн зүтгэсэн ажээ. Ээж нь хүүгийнхээ төлөө ядрах гэдгийг мартан ажиллаж байлаа. Ээжийнхээ авч өгсөн оюун ухааныг хөгжүүлэх тоглоомоор хүүхэдий ядарч байсан ч тоглож өөрийгөө хөгжүүлж байв. Бэрхшээлээ ялан дийлэх урам ээж нь хүүдээ өгч байв. Хүү ч ээжийнхээ итгэлийг алдахгүйг цаг мөч бүрт хичээж байлаа.

Ээж нь түүнийг "Хөгжлийн бэрхшээлээсээ болж бусдаас ичээсэй гэж хүсээгүй. Олон зүйлээр бусдаас тааруу чадвартай ч түүнийг тэдгээр бэрхшээлүүдийг давна туулж тэсвэрлэх хэрэгтэй талаар байнга зөвлөдөг байв. Ээжийн дэмжлэг, өөрийн тэсвэрээр бие махбодын олон бэрхшээлийг даван туулж чадсан. Тэрээр ШУТИС-ийн инженерийн ангийг төгсөөд магистрт сурсан байна. Тэгээд нэг жил гаруй ажил хийж ээждээ тусалжээ. Гэвч ээж нь Харвардын их сургуульд суралцахыг ятгаснаар Харвардын их сургуулийн Хуулийн ангид элсэн суралцсан билээ. Ээж минь надад үргэлж урам зориг хайрладаг. Намайг аливаа зүйлд тэсвэртэй байх чадварыг ээж минь сургасан хэмээн хүү өгүүлжээ.

*Эх сурвалж: "Саажилттай хүүгээ Харвард руу хөтөлсөн ээж түүх"-ийг үндэслэв.*

### Хүлээцтэй байх чадварыг хөгжүүлэх жишиг даалгавар

1. Хүү биеийн бэрхшээлийг хэрхэн даван туулсан бол...

   ........................................................................................................................

2. Та дээрх хүүтэй адил бусад хүүхдүүдэд юу гэж зөвлөх байсан бол...

   ........................................................................................................................

3. Аливаа бэрхшээлийг тэсвэртэйгээр давж туулах нь ямар амжилтад хүрдэг болох талаар өөрийн санал бодлоо илэрхийлээрэй.

| Бусдын дэмжлэг, урамшуулал: | Өөрийн бэрхшээлийг даван туулах тэсвэр | Ямар, ямар амжилтад хүрсэн бэ? |
|---|---|---|
| .................................... | .................................... | .................................... |
| .................................... | .................................... | .................................... |

1. Том цаасан дээр хүний дүрс зурж, дараах зүйлийг зураарай.
   - Оюун ухаан –Хүний тархи
   - Нийгэм- Ам
   - Сэтгэл хөдлөл-Зүрх

- Бие мах бодь- Булчин
- Ёс суртахуун – Хэвлий

2. Дээрх үгийг дараах байдлаар тайлбарлаарай.
   - Бидний адил сэтгэн бодож, бидний адил хүсэж мөрөөддөг талаар
   - Тэд бусдын адил бусдын төлөө санаа зовж, ажиллаж, амьдардаг талаар
   - Тэд бусдын адил бусдыг хайрлаж, баярладаг, гомдож, гутардаг талаар
   - Бидний адил мах цусанд төрж, өвдөж, зовдог талаар
   - Тэд сайн, муу зөв, буруугийн талаар бусдын адил мэддэг, хэм хэмжээг дагаж мөрддөг талаар
3. Тэдэнд тулгарч буй саад бэрхшээлийг шийдэх боломжийн талаар өөрийн санал бодлоо илэрхийлээрэй.

   Заавар:

   Сурагч бүр 1-2 саадыг гаргана. Өөрийн онцолж буй 3 саадыг сонгох талаар санал болгоно. Энэ саад нь шийдлийг мухардалд оруулахаар байх ёстой гэдгийг анхаараарай. Шийдвэрлэх арга замыг хамтдаа ярилцана. Шийдэл гэсэн нүдэнд шийдэлд хүрэх санааг бичнэ.

| | Саад 1 | Саад 2 | Шийдлүүд |
|---|---|---|---|
| Орон нутгийн түвшинд | | | 1. ...<br>2. ... |
| Үндэсний түвшинд | | | 1. ...<br>2. ... |
| Бүс нутгийн түвшинд | | | 1. ...<br>2. ... |
| Олон улсын түвшинд | | | 1. ...<br>2. ... |

## АНГЛИ ХЭЛ

### *Learning objective:*

Resilient person - to know and observe about resilience, describe simply, learn, follow and accomplish

*Table 2: relevance of GCED and core curriculum objectives*

| *GCED objective* | *Core curriculum objective* | *Relevance* |
|---|---|---|
| Recognise how we fit into and interact with the world around us and develop intrapersonal and interpersonal skills | Children are motivated to become mature, motivated, ethical and decision-making individuals. | Become a good citizen by developing intrapersonal and interpersonal skills |

*Graph 1: content: local, national and global levels*




## Grade 5

**Subtopic**: I am........- at school (my personality).

**Learning objectives:**

- To know about some adjectives of personalities and feelings, ask and answer the questions, conclude own personality and make a simple decision.
- To distinguish between good and bad and be encouraged to make simple decisions in daily life in English language learning process.

**Expected result:** Communicate with others, describe how to adapt and recognize how to come over unknown situation.

**Methods:**

- Communication
- Talk, work together, share
- Compare and conclude
- Create

**Resources:**

worksheets, pictures, a short video, colored papers, markers, handouts (bucket, paper flowers), assessment and feedback sheets.

**Assessment methods:**

Traffic lights/ Smile – self-assessment, peer assessment

Teacher's feedback –observations

Listen to other's ideas and thoughts

Respect and communicate with others.

Make simple conclusions and decisions

Warm up

*Teacher*: Shows pictures and ask the questions and talk about what difference at home and at school.

Where is she/he? –

Are you happy at home?-

Are you friendly with your brother or sister?

Are you happy at school?

Are you friendly with your classmates/friends at school?



*Students:* Look at the photos, answer the questions and can describe (possible answers: She/ He is at home.Yes, Iam/ No, I am not. etc.)

***Note for teachers***

- Give instructions to the students to understand what personalities are showed, let them to know positive and negative sides.
- The following link can be used: Describing personality-Learning English for kids /www.youtube.com/
- Try to guide the students to get an idea about person's personality.

Presentation

*Teacher:* Give the students thewords using pictures(brave/shy; friendly/unfriendly; talkative/ quiet; patient/impatient; hardworking/lazy).

| Дараах хүмүүсийн зураг бүрт тохируулан асуулт зохиож, асуултуудыг жагсаан бичнэ.<br>1. ...<br>2. ...<br>3. ...<br>4. ...<br>Хүмүүсийн нүүр хувирлын зураг нь сурагчдад ямар сэтгэгдэл төрүүлж болох талаар ярилцана. | Багш баримтаар хариулах асуултаас илүү эрэл хайгуул руу хөтөлсөн асуулт дэвшүүлэхэд чиглүүлнэ.<br><br>Зурагнуудын аль нь чамд эерэг, сөрөг сэтгэгдэл төрүүлж байна вэ? |

Дараах хүмүүсийн нүүр хувирлын нэрлээрэй. Аль нь танд эерэг сэтгэгдэл төрүүлж буй талаар тэмдэглээрэй.



## Үйл ажиллагаа 2.

| Сурагч | Багш |
|---|---|
| А. Дөрвөн гишүүнтэй баг болно.<br>I танилцуулга: Багийн 1, 2, 3, 4 дүгээр сурагч тус тус өөрийнхөө талаар 2 минутад танилцуулна. Бусад сурагчид анхааралтай сонсоно. Танилцуулж буй сурагчид дэмжлэг үзүүлнэ. | Багш сурагчдыг зохион байгуулах чиглүүлэх үйлийг гүйцэтгэнэ. Үүнд: Багш толгой дохих, дэмжлэг үг хэрэглэх, танилцуулж буй сурагч руу харах г.м үйл хийж дэмжиж болохыг сонсогч сурагчдад танилцуулна. (Багш нэмж баяжуулж болно.) |

А. Дөрвөн гишүүнтэй баг болно.

I танилцуулга: Багийн 1, 2, 3, 4 дүгээр сурагч өөрийнхөө талаар танилцуулга хийнэ.




II танилцуулга: Багийн 1, 2, 3, 4 дүгээр сурагч өөрийнхөө анх танилцуулсан зүйлээ дахин 2 минутад танилцуулна. Бусад сурагчид анхааралгүй сонсож буй дүр үзүүлнэ. 1 дүгээр сурагч уурласан дүр төрх гаргаж буруу харж сууна. 2 дугаар сурагч гуниглсан дүр төрх үзүүлж хөлөө ачиж анхааралгүй сууна. 3 дугаар сурагч дургүйцсэн дүр төрх үзүүлж ямар нэг юм хийх г.м (Багш нэмж баяжуулж болно.)

Та өөрт төрсөн сэтгэгдэлээ өнгөөр илэрхийлнэ үү. (Үнэлгээний хуудасны холбогдох хэсэгт тэмдэглэнэ)
**Хар өнгө-таагүй, Улаан өнгө-таатай, Ногоон өнгө-ойлгомжгүй**
/эрхий хуруугаа тойргийн голд байгаа савтай усаар норгоод усан будган дээр дарж өнгөөр илэрхийлнэ/
*Сурагчид үнэлгээний хуудсыг тойргоор дамжуулан хамгийн сүүлд багшид өгнө.*



*Сурагчдад ямар сэтгэгдэл төрсөн талаар бичээрэй.*

| Анхааралтай сонсох үед | Анхааралгүй сонсох дүр үзүүлэх үед |
|---|---|
| Өөрийг нь ярьж байхад бусад сурагчид анхааралтай сонсож байх үед<br>............................................................................ | Өөрийг нь ярьж байхад бусад сурагчид анхааралгүй байх үед<br>............................................................................ |
| Найзыгаа ярьж байхад анхааралтай сонсож байх үед<br>............................................................................ | Найзыгаа ярьж байхад анхааралгүй байх үед<br>............................................................................ |

## Үйл ажиллагаа 3.

| Сурагч | Багш |
|---|---|
| 2 сурагч оролцоно.<br>Сурагчид даалгаврын заавартай танилцаж, гүйцэтгэнэ. | Оролцогч 2 сурагчид даалгаврын зааврыг танилцуулна. |

Б. Ангиас 2 сурагчийг сонгож оролцуулна. (2 минут)

I танилцуулга: Нэгдүгээр сурагчийн танилцуулгыг нэг алхмын зайд хоёрдугаар сурагч сууж сонсоно.




II танилцуулга: Нэгдүгээр сурагч 20-40 см-ийн зайд танилцуулгаа хийнэ. Сонсогч сурагч зогсоод сонсонгоо долоовор хуруугаараа чичих, түрэмгий төрх гаргах, уурласан, инээсэн г.м зохисгүй үйлдлийг үзүүлнэ.




Танд ямар сэтгэгдэл төрсөн талаараа бичээрэй.

| | Танилцуулж буй сурагчид төрсөн бодол | Сонсож буй сурагчид төрсөн бодол |
|---|---|---|
| I танилцуулгыг хийх үед | | |
| II танилцуулгыг хийх үед | | |

## Үйл ажиллагаа 4.

| Сурагч | Багш |
|---|---|
| Багууд уншиж буй тохиолдлын дүрийн онцлог шинжийг бичнэ.<br><br>Бусад багийн танилцуулж буй тохиолдол бүрийн дүрийн ялгаатай, нийтлэг шинж байгааг тэмдэглэнэ. | Багт нэг тохиолдол сонгож уншуулна.<br><br>Багш тохиолдолд гарч буй дүрийг анхаарч уншихыг зөвлөнө. Бусад багийн танилцуулж буй тохиолдлын дүрд ямар ялгаатай, нийтлэг тал байгааг анхааран сонсохыг зөвлөнө. |

Сурагчид өмнөх үнэлгээний хуудсаа дамжуулан дахин хурууны хээг дараад хуудсаа багшид өгнө.
Багш үнэлгээний хуудсан дахь өнгө өмнөхөөсөө хэрхэн өөрчлөгдснийг харуулаад ЯАГААД ингэж өөрчлөгдсөн тухай ярилцана.

В. Дараах тохиолдлыг шинжлээрэй.

| | |
|---|---|
| А өөрийгөө их яриа, илэн далангүй, хүмүүстэй харилцахдаа маш сайн гэж боддог. Гэвч ангийнхнаас асуувал тэд үүнийг жаахан “түрэмгий” “бусдад үзэл бодлоо тулгадаг” гэж хэлсэн. Тэр хүмүүсийг ятгахыг оролдож, заримдаа үнэн худал нь мэдэгдэхгүй их юм ярьдаг. Бас хүмүүсийг явуулахгүй хоргоох зэргээр түвэгтэй байдаг гэж зарим хүүхэд хэлжээ. А олон найзтай байхыг дотроо хүсдэг боловч түүний харилцааны энэ байдал нь зарим хүүхдийг үргээдэг байна. | М бусадтай найрсаг харилцдаг нэгэн. Ангийн хүүхдүүд нь түүнийг тусч, сайхан сэтгэлтэй охин гэж хүндэлдэг. М-ийн хувьд өөрийн санаа бодлыг бусдад тууштай илэрхийлж, хүмүүсийн өмнө чадварлаг илтгэх хүсэлтэй боловч дотроо үүнээсээ эмээж явдаг байна. М хэд хэдэн удаа хүүхдүүдийн өмнө танилцуулга хийхдээ ихэд хичээсэн боловч өөрөө түүндээ сэтгэл хангалуун бус байв. Учир нь дуу сул, өөртөө итгэлгүй харагдсан байх гэж бодджээ. |
| Ю хичээлээ маш сайн хийж, ангидаа сурлагаараа тэргүүлдэг хүүхдүүдийн нэг. Ю гэрийн даалгавраа сэдвийн дагуу маш сайн бэлтгэж, танилцуулга хийж, хэлэх үгээ бичдэг. Ингээд бичсэн зүйлсээ нэгэн жигд уншиж, танилцуулгаа гүйлгэж харуулна. Гэвч танилцуулга нь хүүхдүүдэд төдийлөн сонирхолтой болж чадахгүй байгааг Ю анзаарч санаа нь зовох болжээ. | Л хүүхдүүдийг юм асуухад эелдгээр хариулж, тусламж хүсэхэд нь чадлаараа тусалдаг нэгэн. Тэр олны анхаарлын төвд орох ховор. Л олон найз нөхөдтэй байхыг хүсдэг. Гэвч хүсэж байгаагаа илэрхийлж хэлэхийн оронд бусдыг аяндаа таaж мэднэ, эсвэл асууна байх гэж найддаг. Заримдаа Л-д бусдын үгээр хийсэн зүйлээ бодоод бусдад ашиглуулж байна гэсэн мэдрэмж төрөх тохиолдлууд байдаг. |

*Эх сурвалж: Нийгэм судлал IX анги сурах бичиг 13 дугаар тал УБ.,2017*

Жишээ нь: Хүүхдүүдийн зан чанарын зураглал хийж болох юм.




1. Хүүхдүүдийн ялгаатай, нийтлэг талуудыг ярилцаарай.

| | Хүүхдийн ялгаатай тал | Хүүхдийн нийтлэг тал |
|---|---|---|
| А | | |
| М | | |
| Ю | | |
| Л | | |

## Үйл ажиллагаа 5.

| Сурагч | Багш |
|---|---|
| Ангийн найзууддаа зориулж зөвлөмж бичиж, танилцуулна. Зөвлөмж бэлтгэхдээ “Нийгэм судлал IX” сурах бичгийн 13-15дугаар талыг уншина. | Орон зай, дуу хоолой, гар хөлийн байрлал, хөдөлгөөн, нүүр хувирал зэрэгт анхаарал хандуулахыг зөвлөнө.<br>Бүдүүвчийн дагуу сурах бичиг дэх мэдээлэлтэй уншиж танилцахыг зөвлөнө. |



2. Дараах хүснэгтийг дагуу ангийн сурагчдад зориулж зөвлөмж бичиж танилцуулаарай.

| | Өөрийгөө илэрхийлж буй сурагчдад та ямар зөвлөгөө өгөх вэ? | | Ангийн сурагчдаа дэмжих талаар ямар зөвлөгөө өгөх вэ? | |
|---|---|---|---|---|
| | Үгэн харилцаа | Үгэн бус харилцаа | Үгэн харилцаа | Үгэн бус харилцаа |
| А | | | | |
| М | | | | |
| Ю | | | | |
| Л | | | | |

Сурагчид өөрсдийн хариултыг хэрхэн,яагаад өөрчлөгдсөнийг дүгнэн ярилцах нь чухал юм.
*Сурагчдын дүгнэлтийн* дараа багш өөрийн дүгнэлтээ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДСАНД тулгуурлан хийнэ

## Үнэлгээний хуудас

| | I танилцуулга | | II танилцуулга | |
|---|---|---|---|---|
| | Танилцуулсан сурагч | Сонссон сурагч | Танилцуулсан сурагч | Сонссон сурагч |
| А | | | | |
| Б | | | | |

Та өөрт төрсөн сэтгэгдэлээ өнгөөр илэрхийлнэ үү.
*Хар өнгө-таагүй, муу* *Улаан өнгө-таатай, сайн* *Ногоон өнгө-ойлгомжгүй*

## НИЙГМИЙН УХААН

### БАГА БОЛОВСРОЛ (5-р анги)

"Бүтээлч сэтгэлгээний зарим арга"-аар суралцагчийн дэлхийн иргэний чадварыг хөгжүүлэх

**Суралцахуйн зорилт:** Хүлцэн тэвчдэг хувь хүн (Tolerant Person) – Ялгаатай байдлыг ямар нэгэн ташаа бодол, ялгаварлан гадуурхалтгүйгээр хүлээн зөвшөөрч, хүндэтгэж, зэрэгцэн амьдрах чадварт суралцах

*Хүснэгт 1. Хүн ба нийгэм, бага боловсрол (5-р анги)*

| Хүн ба нийгэм хичээлийн хөтөлбөр дэх холбогдох агуулга | Хүмүүсийн ялгаатай байдлыг мэдэж харилцаж чаддаг болох |
|---|---|
| Хүн ба нийгэм хичээлийн хөтөлбөр дэх холбогдох чадвар | - Бусдыг сонсож, ойлгож, үзэл бодол, байр суурийг хүндэтгэж чаддаг байх<br>- Бусадтай харилцахдаа сэтгэл хөдлөлөө хянаж, зохицуулж чаддаг болох<br>- Бусадтай хамтран ажиллахдаа хүлээцтэй хандаж, туслаж дэмжиж, бусдаас дэмжлэг авч чаддаг байх |
| Дэлхийн иргэний чадвар | - Хүлцэн тэвчихүйн талаар мэдэх,<br>- Хүмүүсийн ялгаатай байдал, үзэл бодол, үнэт зүйлд хүндэтгэлтэй хандах, хүлээн зөвшөөрөх<br>- Дэлхийн хүн бүрийн сайн сайхны төлөө өөрийн санаачилга гаргах, үйл ажиллагаанд оролцох хүсэл эрмэлзлэлтэй болох |

**Арга зүй:** Бүтээлч сэтгэлгээний аргууд

- Инсерт уншлагын арга
- Бод, хамтар, хуваалц
- Эрэл хайгуул хийх
- Оюуны довтолгоо

**Ашиглах материал, хэрэглэгдэхүүн**

- Монгол хэлний тайлбар толь
- Ухагдахууны тайлбар Юнеско
- Соёлын ялгааг харуулсан тохиолдол
- Дэлхийн иргэний боловсролын чиглэлээр ном, гарын авлага, нэмэлт мэдээллийг www.apceiu.orgхаягаар нэвтрэн авч болно. Тухайлбал:
  - o The ABCs of Global Citizenship Education UNESCO,2016/gcedclearinghouse.org/resources/abcs-global-citizenship-education/
  - o Schools in Action, Global Citizens for Sustainable Development – A Guide for Teachers UNESCO, 2016. http://unesdoc.unesco.org/images/0024/002468888e.pdf
  - o Schools in Action, Global Citizens for Sustainadle Development – A Guide for Students UNESCO,2016.http://unesdoc.unesco.org/images/0024/002463/246352e.pdf

**Үнэлэх арга, хэлбэр, шалгуур:**

- "Рубрик"- Өөрийн үнэлгээ
- Багшийн үнэлгээ – явцын ажиглалт
  - o Бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандаж буй байдал
  - o Бусдын ялгаа онцлогийг ойлгож, хүндэтгэж буй байдал
  - o Бусдын сайн сайхны төлөөх хандлага

***Багшид санамж***

- Багш хичээлийг удирдан чиглүүлэхдээ сурагчид өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандах, хүлээн зөвшөөрөх, багийн ажилд хариуцлагатай, бүтээлч оролцох арга барил эзэмшүүлэхэд анхаарна.
- Хүлцэн тэвчихүй гэдэг ойлголтын талаар тодорхой ойлголттой болсон байна.
- Хүүхдүүдийн ойлголтыг нэгтгэж өгнө.
- Хүлцэн тэвчихийн давуу талыг холбогдох ном, гарын авлагаас судалсан байна.
- Хичээлийн зорилго руу сурагчдыг чиглүүлнэ.
- Хүүхэд болгоны саналыг сонсох нь чухал гэдгийг хичээлийн явцад анхаарна уу.
- Сурагчдыг урамшуулж, чиглүүлж ажилна уу.

**Үйл ажиллагааны хувилбарууд:** Дэлхийн иргэний хүлцэн тэвчихүйн чадварыг хөгжүүлэх даалгавар.

**Үйл ажиллагаа 1**. Хүлцэн тэвчихүй гэдэг үгийг юу гэж ойлгож байна вэ? Хариултаа бичнэ үү?

________________________________________

________________________________________

**Үйл ажиллагаа 2.** Хүлцэн тэвчихийн давуутал хэрхэн илэрч байна вэ?



**Үйл ажиллагаа 3**. Тохиолдлыг шинжлээрэй

Сурагч солилцооны хөтөлбөр

Манай сургууль Увс аймгийн төвийн I арван жилийн сургуультай “Сурагч солилцооны хөтөлбөр” зохион байгуулав. Манай ангийн Баяраа Увс аймаг руу явж, түүний оронд Туяа гэдэг сэргэлэн цовоо, бор охин манай ангид ирлээ.

Тэр үргэлж инээмсэглэж явдаг бөгөөд хэлж ярих бүрдээ хүүхдүүдийг инээлгэх юм. Туяа: -Күүкдүүд ээ, наарийч нарийч гэж дуудсанаас болж Нарийч Туяа гэдэг нэр авав. Яагаад гэвэл Туяа ярихдаа нутгийн аялгаар үгээ хэлж байлаа. Эхлээд хөгжилтэй байсан ч эцэст нь Туяа биеэ барьж, үг хэлэхдээ ч бусдаас санаа зовдог болов.

Тэр удахгүй нутаг буцах болж, сэтгэл өндөр байсан ч, үдэлтийн уулалтан дээр ярих зүйлээ дэвтэр дүүрэн бичиж ирсэн боловч, ярьж чадахгүй, нүдэнд нь нулимс цийлэгнэн сууна.

- Хүүхэд бүр янз бүрийн газар нутагт, гэр бүлийн ялгаатай орчинд өсөж хүмүүждэг гэдэгтэй та санал нийлж байна уу?
- Туяад туслахын тулд та юу хийж чадах вэ?
- Туяагийн оронд та байсан бол яах байсан бэ?

**Үйл ажиллагаа 4.** Сургуулийн орчинд сурагчдын ялгаатай байдлыг үл хүндэтгэн, тэдний эрхийг зөрчиж байгаа ямар жишээ байна вэ? Түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар саналаа илэрхийлнэ үү.



## СУУРЬ БОЛОВСРОЛ (9-р анги)

| | |
|---|---|
| Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөр дэх холбогдох агуулга | Хувь хүн ба нийгэм агуулгын хүрээнд:<br>- Хүмүүс хоорондын харилцааг ажиглах замаар үйл ойлголцол, маргаан зэргийн учир шалтгааныг судлан, эдгээр зөрчлийг шийдвэрлэх үр нөлөөтэй аргуудыг харилцаандаа ашиглах чадвар эзэмшин, стресс бухимдлаас ангид байхыг эрхэмлэн, үйл ажиллагаагаараа илтгэн харуулна.<br>Хувь хүн ба соёл агуулгын хүрээнд:<br>- Соёлын олон төрөл тэдгээрийн харилцан нөлөөлөл, өөрчлөлтийг илрүүлэх таамаглал дэвшүүлэн шинжлэн судлах, өөрийн үнэлэлт дүгнэлт өгөх, олон соёлын нөхцөлд дасан зохицох амьдрах чадварт суралцана. |
| Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөр дэх холбогдох чадвар | - Нийгмийн үйл явдал, үзэгдлийн шалтгаан, үр дагавар болон холбоо хамаарал, нөлөөлөл, өөрчлөлтийг илрүүлэхийн тулд бие даан  асуудал таамаглал дэвшүүлэх, мэдээлэл эрж хайх, цуглуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, нотлох, няцаах, тайлбарлах |
| Дэлхийн иргэий чадвар | - Нийгмийн бүлгүүдийн олон янз байдлын талаар гүнзгий мэдлэгтэй болох, ойлгох<br>- Нийгмийн бүлгүүдийн онцлог, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэлтэй хандах<br>- Нийгмийн бүлгүүдийн ялгаатай байдалд тулгарч буй асуудал, бэрхшээлийг шийдвэрлэхэд өөрийн хувь нэмрийг оруулах<br>- Олон янзын нийгмийн бүлгүүдийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, хамтран ажиллах |

**Арга зүй:** Бүтээлч сэтгэлгээний аргууд

- Шинжлэн судлах арга (асуулт зохиох, мэдээлэл цуглуулах, мэдээллээ шинжлэх, нэгтгэн дүгнэх, нотлох, тайлбарлах)
- Оюуны аялал
- Бинго асуулт хариулт
- Венн диаграмм

**Ашиглах материал, хэрэглэгдэхүүн:**

- Нийгмийн олон янзын бүлгүүдийн жишээ, кейс
- Сэдэвтэй холбоотой мэдээллийн эх сурвалжууд (Интернет сайт, ном, гарын авлага)

**Үнэлэх арга, хэлбэр, шалгуур:**

**Үнэлэх арга хэлбэр:** Багшийн үнэлгээ,  Эссэ бичлэг

- Сэдэв агуулгадаа тохирсон байдал
- Өвөрмөц, шинэлэг санаа
- Баримт, нотолгоо
- Хэл найруулга
- Дүгнэлт

***Багшид санамж***

- 9-р ангийн түвшинд суралцагчид нийгмийн бүлгүүдийн ялгаатай байдал, тэдний онцлог, үнэт зүйл болон тэдэнд тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг шинжлэн судалж, тэдгээрийг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулж чаддаг болоход анхаарах
- "Ялгаатай байдал ба хүлцэн тэвчихүй"-н талаар дэлгэрүүлж уншиж, судлах нэмэлт мэдээлэл, эх сурвалжийг урьдчилан бэлтгэх
- Мэдээллээ хэрхэн цуглуулах, боловсруулах, танилцуулахад сурагчдад зөвлөх

## Үйл ажиллагааны хувилбарууд:

**Үйл ажиллагаа 1.** Хүмүүс ямар ямар хувийн болон нийгмийн шинжээрээ ялгаатай байдгийг жишээ болгож бичнэ үү?

| Хувийн шинж | Нийгмийн шинж |
|---|---|
| | |
| | |
| | |
| | |

**Үйл ажиллагаа 2.** Нийгмийн бүлгүүдийн онцлог болон нийтлэг үнэт зүйлсийг тодорхойлон, ямар зүйлсээрээ нэгдэж байгааг хэлэлцэнэ үү.









**Үйл ажиллагаа 3.** Тухайн нийгмийн бүлгүүдэд тохиолдож буй асуудал, бэрхшээлийг шинжлэх, нэгтгэн дүгнэх, түүнийг шийдвэрлэхэд өөрийн байр суурийг илэрхийлнэ үү.

**Үйл ажиллагаа 4.** Нийгмийн бүлгүүдийн нийгэмд үзүүлж буй нөлөөллийг дараах загварын (Орон нутаг, бус нутаг, улс үндэстэн, олон улс) дагуу тайлбарлана уу



## БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ (12-р анги)

| | |
|---|---|
| Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөр дэх холбогдох агуулга, чадвар | Нийгмийн тэгш бус байдал агуулгын хүрээнд:<br>- Нийгмийн давхраажилт, угсаатан, жендерийн тэгш бус байдлын уялдаа холбоо хийгээд тэгш бус байдалд хүргэж буй шалтгаан, хувийн амьдралд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох<br>Эрхзүйн харилцаа агуулгын хүрээнд:<br>- Эрхзүйн харилцааг нийгмийн бусад харилцаанаас ялган зааглаж, өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвартай иргэний үндсэн шалгуурыг тодорхойлох<br>Эрхзүйн зөрчил ба хариуцлага агуулгын хүрээнд:<br>- Эрхзүйн хэм хэмжээг зөрчихгүй байх, зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага хүлээдэг болохыг тохиолдол шинжлэх замаар тодорхойлон, хуулиа дагаж мөрддөг хариуцлагатай иргэн байхын ач холбогдлыг тайлбарлах<br>Дэлхий нийтийн глобаль асуудал агуулгын хүрээнд<br>- Ядуурал, өлсгөлөн, экологийн хямралын талаар статистик мэдээлэлд шинжлэл хийж эдгээрийг гэтлэх арга замын тухай санал дэвшүүлэх<br>- Дүрвэгсэд, хүний эрх, терроризм, цөмийн зэвсэглэлийн талаар баримт нотолгоо, тохиолдол шинжилж хувийн байр суурийа илэрхийлэх |
| Дэлхийн иргэний чадвар | - Хүний эрх, тэгш байдлын талаарх мэдлэгээ гүнзгийрүүлэх<br>- Хүний эрхийг дээдлэн, тэгш байдлыг хангах чиглэлээр гарсан хууль, дүрэм журмыг сахих биелүүлэх<br>- Асуудалд шүүмжлэлтэй хандах, асуудал шийдвэрлэх<br>- Хүний эрхийг дээдлэн, тэгш байдлыг хангахад хариуцлагатай, оролцоотой дэлхийн иргэн байх |

**Аргазүй**: Бүтээлч сэтгэлгээний аргууд

- Шинжлэн судлах арга (Асуудал дэвшүүлэх, мэдээлэл цуглуулах, мэдээллээ шинжлэх, нэгтгэн дүгнэх, нотлох, тайлбарлах үзэл бодлоо илэрхийлэх)
- Инсерт уншлагын арга

**Ашиглах материал, хэрэглэгдэхүүн**

- Монгол Улсын Үндсэн хууль
- Хүүхдийн эрхийн тухай конвенц
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Хүний эрхийн конвенц
- Хүүхэд хамгааллын хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай /шинэчилсэн найруулга/
- Боловсролын тухай хууль

**Үнэлэх арга, хэлбэр, шалгуур:** Эссэ бичих

- Сэдэв, агуулгадаа тохирсон байдал
- Өвөрмөц шинэлэг санаа
- Баримт, нотолгоо
- Хэл найруулга
- Дүгнэлт

**Багшид санамж**

- 12-р ангийн түвшинд сурагчид нийгмийн ялгаатай бүлгүүд, ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэйгээр тэдний эрх зөрчигдөж, тур засгийн хамгаалал, ивээлийг авч чадахгүй байгаад шүүмжлэлтэй хандан, цаашид шийдвэрлэх арга замын талаар өөрийн байр суурь, үзэл бодлоо илэрхийлэх чадвараа нэмэгдүүлэхэд анхаарна.
- Хүний эрхийн зөрчлийг харуулсан зураг, видео, тохиолдлыг бэлтгэх
- Өөрийн үнэлгээний хуудас бэлтгэх
- Сурагчдын мэдээлэл цуглуулах, боловсруулах, үр дүнг танилцуулах зэрэг чадваруудыг хөгжүүлэхэд анхаарна уу .

## Үйл ажиллагааны хувилбарууд

**Үйл ажиллагаа 1.** Эх сурвалжтай ажиллаж, хүснэгтийг бөглөөрэй.

| Хууль, конвенц-д тусгагдсан байдал | Бидний ямар эрхийг хамгаалсан бэ? | Тэмдэглэл |
|---|---|---|
| Монгол улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно.<br>МУ-ын Үндсэн хууль 16- *I* дэх заалт | | |
| Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно.<br>МУ-ын Үндсэн хууль 16-3 дахь заалт | | |
| "... хүний үндсэн эрх, эрхэм зэрэг, үнэ цэнэ болон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, том жижиг үндэстэн бүгд адил тэгш эрхтэй гэдэгт итгэх итгэлийг нотлох... зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хүч чармайлтаа нэгтгэхээр шийдвэрлэв.<br>*НҮБ-ын дүрэм, оршил хэсгээс* | | |
| Оролцогч улсууд хүүхдийн амьдрах, эсэн мэнд хөгжих боломжоог дээд зэргээр бүрдүүлэн хангана.<br>Хүүхдийн эрхийн конвенц 6-2 дахь заалт | | |

**Үйл ажиллагаа 2.** Дүн шинжилгээ хийцгээе

Судалгаагаар эрэгтэйчүүд ажлын цагийн 84 хувийг, эмэгтэйчүүд 56 хувийг цалин хөлс олох ажил хийхэд зарцуулж байна. Мөн эмэгтэйчүүд гэр орны ажил эрэгтэйчүүдээс 2.5 дахин их цаг зарцуулж байна. Хөдөөгийн охид хотын охидтой харьцуулахад гэрийн ажил хийхэд 1.6 дахин цаг зарцуулдаг байна.

*Эх сурвалж: Зохистой хөгжлийн жендэр төв. МУ-ын хөдөлмөрийн эрхзүйд үл ялгаварлан гадуурхал, жендэрийн тэгш байдлыг дэмжих нь Жендерийн асуудал. Дугаар 2. 2011.(23-24-р тал)*

**Шийдвэрлэх асуудал**

1. Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн хооронд цаг ашиглалтын ялгааны учир шалтгаан юу вэ?
2. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн цаг ашиглалтад илэрч буй ялгаа нь ямар үр дагавартай байж болох вэ?

Гэртээ Аав, ээж, ах, эгч, эмээ, өвөөгийнхөө цаг ашиглалтыг хүснэгтээр мэдээлэл цуглуулах

**Үйл ажиллагаа 3.** Ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй хүний эрхийн зөрчлийг харуулсан зургуудийг асуулгын дагуу шинжилнэ үү.

1. Ялгаварлан гадуурхалтын ямар хэлбэр болохыг тодорхойлох
2. Олон улсын гэрээ, конвенцод заагдсан ямар эрх зөрчигдөж байгааг тодруулах
3. Эдгээр хүмүүст төр засаг, олон нийтийн байгууллгууд хэрхэн хандаж байгааг тодруулах
4. Цаашид хэрхэн шийдвэрлэх талаар үзэл бодлоо илэрхийлнэ үү.

|  |  |
|---|---|
| 1. | 1. |
| 2. | 2. |
| 3. | 3. |
| 4. | 4. |

**Даалгавар 4.** Хүний эрх, тэгш байдлыг хангахад цаашид хэрэгжүүлэх ажлын талаар өөрийн санал, санаачилга гаргана уу.



## АНГЛИ ХЭЛ

# Grade 9

**Sub topic:** Are we different or same?

**Objectives**:

- Students will identify and appreciate differences and similarities between people.
- Students will understand the meaning of tolerance and how it can be applied to their lives.

*Table 1: relevance of GCED topics&learning objectives and Core curriculum learning objectives*

<table>
<tr><td colspan="2">Global citizenship education topics<br>Global citizenship education objectives</td><td colspan="2">Difference communities people belong to and how these are connected</td></tr>
<tr><td colspan="2">Demonstrate appreciation and respect for difference and diversity</td><td colspan="2">Core curriculum learning objectives<br>- Support personal development<br>- Respect for diversity<br>- To have the ability to use, communicate, and study creatively with foreign language own interests and needs.</td></tr>
<tr><td>Pre-primary &Lower primary</td><td colspan="2">Lower secondary</td><td>Upper secondary</td></tr>
<tr><td colspan="4">Global citizenship education learning objectives</td></tr>
<tr><td>Recognize how we fit into and interact with the world around us and develop intrapersonal and interpersonal skills</td><td colspan="2">Distinguish between personal and collective identity and various social groups, and cultivate and sense of belonging to a common humanity</td><td>- Understand diverse groups, respect value attitude<br>- Learning to change society problems and be a global citizen.<br>- Analyze issues of local and national levels</td></tr>
<tr><td colspan="4">Global citizenship education topics</td></tr>
<tr><td>Despite of Where I live communicate in range in the world</td><td colspan="2">You have a duty to participate in different activities and communicate different people</td><td>Values to influenced in a citizen participation (individual, interesting, attitude and skill)</td></tr>
<tr><td colspan="4">Core Curriculum learning objectives</td></tr>
<tr><td>1. Receive information- Concentration<br>2. Receive information- Observe, compare, use the gesture<br>3. Express and guess information – Work in pairs and groups, exchange and communicate information</td><td colspan="2">1. Receive information- make in notes key words<br>2. Receive information- Find out causes, consequences and solutions<br>3. Receive information - Exchanging some information in pairs and groups</td><td>1. Receive information-</td></tr>
</table>

**Assessment methods**:

Smile – self-assessment, peer assessment

Teacher's web question –observations

Make simple conclusions and decisions

## Warm-up

*Teacher*: Present game instruction to students and calls out someone, who has the same things and opinions such as: birthday, hobby, sweets, sports, favorite star ....etc. The teacher's discretion should be used when calling out serious *categories.*

*Students*: Should be seated in circle and listen to teacher instruction carefully and stand up by the same categories. Emphasis to pupils that it is okay to be the only child standing or sitting.

***GAMES GAMES GAMES***

***Stand up If...***

"Stand up if your birthday is in June"

"Stand up if you like sweets", etc.

"Stand up if you think boys are better at sports" or "Stand up if you think school rules are unfair".




## Presentation

*Teacher:* Prepare short movie about someone, who lost wallet and Japan children found it and gave back. Resource from FB: https://www.facebook.com/janbolatkh/videos/10208640474306550/

Before video: teacher ask some question: Have you found anything? What did you do that moment? How about your friend? Do you have friends? Are their good or bad? Now, we start video? Is it good or bad? Why? If you have like these friends? .... etc.

During the video: The teacher do some segment. Discuss how Japanese friends tolerate bad things? How about you?

After watching: Turn and talk compare bus stop environment. Is it noisy or peaceful? Why? .... etc.

*Students:* Watch the movie carefully and they found out what parts of video can express tolerance action, peace, and respect others?

## Activity 1:

*Teacher:* Divide the students into 5 groups and give each group "Differences/Similarities" worksheet and describes describe their differences. Explain activity direction. Students have to classify into categories *How we may be different?/ How we are all the same?*

*Students:* Describe and express *How we may be different?/ How we are all the same?* What is the bad and good points that we are different/all the same things.

### Suggested answers

| How we may be different? | How we are all the same? |
|---|---|
| Physical differences<br>Food eaten<br>Language<br>Music listened to<br>Homes<br>Schools<br>Families<br>Games played<br>Methods of travel | Bodies<br>Feelings<br>Need family<br>Friendship<br>Learning<br>Need to work<br>Sickness/disability<br>Leisure/music – enjoyment |

GOOD THINGS SAME THINGS BAD THINGS

### Activity 2: *Party Mingling*

*Teacher:* give instruction for students and ask each questions question.

*Students:* Choose own partners as if at a party, stopping to talk whenever someone else is available

*Suggested questions:*

- what might be different about you if you had been born in...(name of country chosen)?
- what things might be the same if you lived in (insert country)?
- how might a child from (insert country) feel at our school?
- how would you feel if you had to go to school in (insert country)?

### Activity 3: Role Play

*Teacher*: Make copies of the Role Play Cards. Divide the class into small groups (maximum of five) and give each group a role play card. Each role play illustrates someone being "left out" or in the minority.

*Students:* Should be given time to organise and practice their role play. Each group can then perform in front of the whole class. After each performance the teacher should ask questions such as:

### Role play cards

| | |
|---|---|
| A new girl in your class is being teased about not having the correct school uniform. | Your dad is overweight and the other children make jokes about him. |
| Everyone has a pair of trendy trainers except you. They tease you about having untrendy trainers | You have had your hair cut in a new style. Everyone makes fun of you. |
| You have been involved in a car accident and have a small scar on your face. The others make fun of you. | Your school jumper has a rip and everyone teases you about it. |
| You have dark skin, the only person in the class. The others call you names | You are teased for being shorter than everyone else in the class. |

Activity 4: Three- steps interview

*Teacher:* Give instruction to the students to stand in three facing lines. Middle line students run over and ask a question of those, who are facing them, then run to those behind who ask and receive answers about the other.

*Students:* Follow the teacher's instruction and use question sheet, talk each other.

Sample questions:

- how would you feel if you were the person left out?
- how would you feel if you were part of the other group?
- what could the person feeling left out do to improve his/her position?
- what should the others do? Discuss the consequences of particular actions.

Assessment: Students should not be a graded, only one that allows you is to understand who grasped the concepts and who might need extra help.

Conclusion: *Toast ball activity*

*Teacher:* Teacher will throw the ball to the nearest student ( there will be questions glued to the ball)

- o It was cold in the room. But your friend likes cool environment but you like hot inside? In this case what would you do?
- o You want to study some task but in the room your friends make noise? In this case what would you do?
- o Your friend was his birthday. He likes going movie theater but you want go PC game. In this case what would you do?.....etc

*Students:* will answer the question which is nearest to his/her thumbs. After answering the student passes the ball to another one.

## Grade 12

*Table 1: Learning objectives of GCED and core curriculum*

| *GCED objective* | *Core curriculum objective* | *Relevance* |
|---|---|---|
| • Values and attitudes of empathy and respect beyond groups to which you belong<br>• Personal identities and memberships in local, national, regional and global contexts through multiple lenses | Respect culture and traditions of own and different countries | Empathy and respect in local, national and global contexts |

### Expected result

Increasing knowledge and skills in content within the context of the learning objectives and core learning objectives of the PCs and analyzing issues of concern in local, national and country contexts and actively addressing issues in a matter of life and make a decision to change society

**Topic**: Giving and sharing

**Learning objectives:**

According to the topic *"Giving and sharing"* students analyze the people's different daily life in the country, region, and the world. Discuss the real life situations, willing to be a main part of the society and solve the troubles, express and share own thoughts. Make a decision to be a person who is responsible for the social life.

**Methods:** methods based on real tasks, communicative, individual work, knee to knee, group discussion.

**Resources:** some facts, short video, LCD, sheets of paper, markers, pictures, glue,

### Warm up:

*Teacher:* Show the students the numbers of population of own country, Asia and the world. Let the students talk about these numbers, asking them what these numbers are representing, how these people live in the world, they are all happy, they have any problems in their life.












Fastest Growing Asian Populations

| Detailed Group | 2000-2010 Growth |
|---|---|
| Bhutanese | 9070% |
| Nepalese | 532% |
| Burmese | 499% |
| Mongolian | 213% |
| Bangladeshi | 157% |
| Maldivian | 149% |

Share of Asian and Asian American Population by Detailed Group, 2010




Growth Among Largest Groups

| Detailed Group | 2000-2010 Growth |
|---|---|
| Indian | 68% |
| Filipino | 44% |
| Vietnamese | 42% |
| Chinese | 40% |
| Korean | 39% |
| Japanese | 14% |

*Students:* Talk about people's life situations, feelings and problems.

> *Note for teacher*
>
> Teacher guide the students to think about troubles which happen around the earth, furthermore encourage the students how they could get new ideas to solve it. The main ideas is the students must understand that they are a part of the country, they have an opportunity to participate in social life and be an initiative person not only country but also in the world.

.

## Presentation

*Teacher:* Play the video WwwyoutubeHeroes Tribute: Doc Hendley/Wine to Water, Doc Hendley

wwwyoutubeCNN Heroes: Gerard Butler in Liberia. Guide the students to think of problems around the world.

*Students:* Watch a short video about water scarce. Then talk about what this video about and share ideas there are many problems in the world.

## Activity 1: *Practice- Pair work*

*Teacher*: Show some pictures, words and expressions in order to get ideas to the students.

Sample pictures




















*Students:* Work in pairs "Knee to Knee". Students make a list of some troubles in own country, Asia and around the world using the pictures.

Students' suggested answers.

| In my country | In the world |
|---|---|
| Unemployment | Endangered species |
| Homeless people | Unhealthy food |
| Air pollution | Water scarce/pollution |
| Disability | Drugs |
| Crime | Starving |
| Garbage | Global warming |

Activity 2: Individual work

*Teacher:* Suggest the students to watch another short movie. Ask them to catch the information, pay attention to the event and try to get the message/main point of this video. After showing the video teacher asks some questions. (www.youtube.CNN Heroes Tribute Narayanan Krishnan)

Express thoughts about the people's life

Where are these people?
What kind of people are there?

Express feelings about the man

What does he think?
When did he start this activity?

What is he doing for the people?
Why does he help these people?

*Students:* After watching the video the students answer the questions using own ideas.

Activity 3: Discussion- group work

*Teacher:* Give the students some questions and guide them can mention different campaign activity on the poster due to the questions. Then suggest each group member's role such as time keeper, writer, creator and presenter.

- Why have you chosen this problem?
- Is there any possible to solve this problem?
- Do you have to participate in this situation?
- If you want to involve in it how can you organize it?

*Students:* Students are divided into 4 groups talk about each student's idea that he/she has made in the list and choose the most important problem. Groups make a poster using teacher's questions. Having made the posters students show and report to class.

| | |
|---|---|
| Problem in society. | |
| How can you do? | |
| Activity: | |
| Duties: | |
| Solution | |

Activity 4: Individual work

*Teacher:* Elicit the students they have faced and want to give a hand to the Making a decision to be a good person who wants to give and share.

*Students:* Think of real problems in the society and choose a problem. Then make a motto that call the classmates to participate in charity and volunteer works for the problem in our country. *For giving and sharing*

Conclusion: Self assessment- Explain what you have learned: "2 stars and One wish"

Define two advantages and one disadvantage of the class.

- 2 stars
- One wish

## БИОЛОГИ

*Хүснэгт 1. Хүлцэн тэвчихүй сэдэвтэй холбоотой ДИБ-ын хам сэдэв болон чадварууд*

| Түвшин | Бага | Дунд | Ахлах |
|---|---|---|---|
| ДИБ-ын хам сэдвүүд | Байгал орчин, Эрүүл мэнд, Соёл | Боловсрол, Байгаль орчин Эрүүл мэнд, Ядуурал, Ажил хөдөлмөр эрхлэлт, Мал аж ахуй, Соёл, Шашин | Даяарчлал, Хөгжил, Байгаль орчин, Эрүүл мэнд Иргэн түүний оролцоо, Соёл |
| Дэлхийн иргэний чадвар | Оролцогч байх, Өөрийгөө илэрхийлэх, Нээлттэй байх, Хариуцлагатай байх, Шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэх, Орчиндоо хүндэтгэлтэй хандах, | Бусдыг хүндэтгэх, Нээлттэй байх, Өөрийгөө илэрхийлэх байдал Ярилцах Асуудлыг ойлгох, Задлан шинжлэх, Ялгаатай байдлыг ойлгох, Нэгтгэн дүгнэх, Хэлэлцэх, Хүлээцтэй байх Хүрээлэн буй орчноо мэдрэх, Шийдвэр гаргах, Хүрээлэн буй орчинд сөрөг үзүүлж буй зүйлийг илрүүлэх, Багаар ажиллах, Шийдэл бүрийн эерэг сөрөг талыг тодорхойлох, Эцсийн шийдэл түүнийг сонгох шалтгаан, Ёс суртахууны хэм хэмжээг сахих байдал, Хариуцлагатай байх | Бусдыг хүндэтгэх, Нээлттэй байх, Өөрийгөө илэрхийлэх байдал Хүлээцтэй байх, Нээлттэй хариуцлагатай байх, Ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах, Олон талт соёлыг ойлгох Шийдвэр гаргах, Хүрээлэн буй орчноо мэдрэх, Хүрээлэн буй орчинд сөрөг үзүүлж буй зүйлийг илрүүлэх, Багаар ажиллах, Нэгтгэн дүгнэх, Хэлэлцэх, Ёс суртахууны хэм хэмжээг сахих байдал, Хариуцлагатай байх |

*Хүснэгт 2. Хүлцэн тэвчихүй сэдэвтэй холбоотой биологийн хичээлийн агуулга*

| Түвшин | Хүлцэн тэвчих сэдэвтэй холбоотой агуулга |
|---|---|
| Бага боловсрол | Миний найз, Миний бие, Манай гэрийнхэн, Өсөлт хөдөлгөөн, Уур амьсгал |
| Суурь боловсрол | Бодис эрүүл мэндэд нөлөөлөх нь, Амьсгал, Мэдрэлийн зохицуулга Шингэний зохицуулга, Байгалийн шалгарал, Амьд бие ба орчин |
| Бүрэн дунд боловсрол | Мэдрэлийн зохицуулга, Шингэний зохицуулга, Удамшил, хувьсал ба шалгарал Биотехнологи ба генийн инженерчлэл, Байгаль дахь бодисын эргэлт Экосистемд хүн төрөлхтөний үзүүлж буй нөлөө, Хийн солилцоо Өвчний тухай ойлголт, Энерги ба экосистем, Биологийн олон янз байдал ба байгаль хамгаалал, Ген технологи, Зохицуулга ба хяналт, Хүний нөхөн үржихүй |

**Зорилго:**

1. Хүлцэн тэвчихүй тухай ойлголт
2. Арьс өнгөний ялгаа, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах тухай
3. Насны ялгаварлалтын тухай ойлгох
4. Эрүүл мэндийн байдлаар ялгаварлан гадуурхах
5. Ялгаатай байдлыг хүндэтгэн үзэх үзэл бодолтой болох
6. Дэлхийн иргэний чадварыг эзэмшинэ

**Түлхүүр үгс:** арьс өнгө, насны ялгаварлалт, ялгаатай байдал, хүлцэн тэвчих

**Зохион байгуулалт:** анги нийтээр ярилцах, ганцаарчлан ажиллах, багаар ажиллах

**Хэрэглэгдэхүүн:** арьс өнгөөр ялгаатай байдлыг харуулсан зураг, МХТ-ийн хэрэгслүүд: компьютер, зургийн аппарат, хувилагч машин

**Арга зүй:** Суралцагчдын хуримтлуулсан туршлага,танин мэдэхүйн хөгжлийн түвшинд тохируулан аргыг сонгоно**.** Суралцагчдын насны онцлогтой уялдуулан сургалтын аргын бүх хэлбэрүүдийг хослуулан хэрэглэх боломжтой. Тухайлбал: Суралцагчдын оролцоонд тулгуурласан, харилцан яриа, үзүүлэн таниулах, унших материал судлуулах, турших, тоглоомын арга, дүрд тоглох,эвлүүлгийн арга, булангийн арга, хэлэлцүүлэг, мэтгэлцээн гэх мэт идэвхтэй сургалтын аргуудыг ашиглах

**Үнэлгээ:** Тухайн хичээлээр эзэмших мэдлэг ойлголтоос гадна дэлхийн иргэний чадвартай холбон үнэлэхэд чиглэгдэнэ.

**Үйл ажиллагаа 1.** Бид ямар зүйлийг хүлцэн тэвчдэг вэ?

- "Хүлцэн тэвчихүй" тухай сурагчдад ойлгуулах
- Идэвхтэй сургалтын арга ашиглан хүмүүсийн хүлцэн тэвчдэг зүйлүүдийг нэрлүүлэх
- Зураглал хийх

Жишээ 1.

1. Манай дэлхий хэдэн тивтэй вэ? Монгол улс аль тивд байрлаж байгаа талаар асуух
2. Дэлхийн тивүүдийг эвлүүлдэг тоглоом тоглуулан сурагчдаар эвлүүлүүлэх
3. Аль тивд ямар арьстай хүмүүс амьдардаг болохыг ярилцах
4. Манай дэлхий дээр олон янзын хүмүүс байдаг бөгөөд хэл соёл, ёс заншил, арьс өнгө, гадаад дүр төрхөөрөө ялгаатай гэсэн ерөнхий дүгнэлтэд чиглүүлэх
5. Дэлхийн хүмүүс хэдийгээр хар, шар, цагаан зэрэг арьс өнгөөрөө ялгаатай боловч нэг дэлхий дээр хамтран аж төрж, зэрэгцэн амьдардаг гэсэн санааг гаргуулахад багш чиглүүлэх.



6. 6. Иймд бид бусдыг ойлгож бусдад хүндэтгэлтэй хандах, ялгаатай байдлын хүндэтгэлтэй хандах чадвартай нь зүйтэй гэсэн санааг сурагчдад төлөвшүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх

Жишээ 2. Арьс өнгө, нас, биеийн эрүүл мэндийн байдлаар ялгаварлан гадуурхалтыг хүлцэн тэвчих

- Оршин амьдарч буй газар нутаг, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхалтыг хэрхэн хүлцэн тэвчиж байгаа байдалын тухай ярилцах
- Орон нутаг, бүс нутаг, улс үндэстэн, олон улс орны асуудал болохыг ярилцах

*Даалгавар: Чамд ийм зүйл тохиолдож байсан уу? Тийм бол хэрхэн даван туулсан тухайгаа ярилцаарай.*

**Эрх чөлөө ба Нелсон Мандела**



*1918 оны долоодугаар сарын 18-ны өдөр. Өмнөд Африкийн Тембу овгийн Мвеза тосгонд Холилала Далибунга хэмээх бяцхан хүү мэндэллээ. .....Бороог хүсэмжилсэн он жилүүд ар араасаа өнгөрч, Холилала Далибунга хүү сургуульд оров. Энэ үед өмнөд Африкт иргэншиж нийгэмших үйл явц хүчтэй өрнөж хүүхдүүдийг боловсрол эзэмшүүлж эхэлсэн юм. Энэ нь өрнийн соёлын нөлөө байсан хийгээд Холилала Далибунга хүүг багш нь Нелсон Мандела гэж нэрлэжээ.*

*Тэрээр дээд боловсрол эзэмшихийг хүсэн Йоханнесбург хотноо ирж, тухайн үед цагаан арьстнууд голдуу суралцдаг байсан томоохон их сургуульд хуулийн чиглэлээр элсэн оров. Үнэндээ түүний энэ үйлдэл санаанд багтамгүй зүйл байжээ. Учир нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлээр өвчилсөн Африк тивд хар арьст оюутан цагаан арьстнуудын дунд, тэдэнтэй эрх тэгш суралцаж, зарим нэгнээс нь бүр хол давуу амжилт үзүүлж байсан нь бусдын атаа хорслыг багагүй хөдөлгөв. Манделад одоо зөвхөн тэсч, тэвчиж, заримдаа бүр нүдгүй, чихгүй мэт явах шаардлага гарч ирэв. Үүнийгээ ч тэр сайтар ухаарч байв.*

Яагаад улс орнуудад арьс өнгөөр ялгаварлан гадуурхах хандлага байсаар байна вэ? "Арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтад би өртвөл" сэдвээр эссэ бичээрэй.




Жишээ 2. Насны ялгаварлалтын тухай ойлгох

- Залуу ба хөгшин хүмүүсийн хоорондын ялгаатай байдлын талаар ярилцах (ялгаатай байдлыг ойлгох)
- Хөгшрөлт бол биологийн процесс хүн бүрт тохиолдох тухай ярилцах (хүлээцтэй байх, ялгаварлахгүй хандах)
- Хөгшин болон залуу хүмүүсийн оюун ухаан, бие бялдарын хүч, гадаад байдлаар тэдний эрхийг хаах нь насны ялгаварлан гадуурхалт болох тухай ярилцаж суралцагчдын гэр бүл, хамаатан саданд тохиолдож байсан эсэх талаар ярилцах
- Насны ялгаварлан гадуурхалт хүнд хэрхэн нөлөөлж болох тухай ярилцах
- Үүнийг бүх хүмүүс хүлцэн тэвчдэг эсэх, ямар зан чанартай хүмүүс хүлцэн тэвчдэг тухай ярилцаарай. (ялгаатай байдлыг ойлгох, хүлцэн тэвчихийн эерэг талыг ойлгох)
- Хүн бүр тэгш эрхтэй

Амьд бодисын өсөлт дуусаж аажим алгуураар эхлэн явагдах биологийн байгалийн жам ёсны процессыг хөгшрөлт гэдэг. Эрдэмтдийн судалгаагаар 25 нас хүрч өсөлт зогссоноос хойш хүний бие махбодын 70 гаруй үйл ажиллагааны системд жил бүр 0.8 %-ийн хурдцаар хөгшрөл явагддаг гэж үзжээ. Энэ нь биологийн чанартай буюу амьд бодисын зайлшгүй явагдах хөгшрөлт юм.

*Даалгавар: Ирээдүйн 40-50 жилийн дараа чамд гарах өөрчлөлтүүдийг төсөөлөн бичээрэй. Насны ялгаа нь ялгаварлан гадуурхах үндэслэл болох уу? өөрийнхөө хандлагад дүгнэлт хийгээрэй.*



Жишээ 3.

- Ялгаварлан гадуурхалтыг даван гарахад өөрийн үнэлэмж, өөртөө итгэлтэй байдал маш чухал
- Өвчилсөн хүний гэр бүл, хамаатан өвчтөний гаргаж буй зан авирыг хүлцэн тэвчдэг
- Өвчин тусахгүй байхаас сэрэмжилж, болгоомжлох тухай ярилцах

Хүнд өвчнөөр өвдсөн хүмүүс бусдын таагүй харилцаа, уур уцаар, ял зэмлэлийг хүлцэн тэвчдэг.

*Даалгавар: Танд эдгээр хүмүүст туслахыг хүсэж байна уу? Хэрэв туслахыг хүсэж байвал хэрхэн туслах тухай төлөвлөгөө зохиогоорой.*

*Эх сурвалж http://uadm.mn*



Жишээ 4. Түлхүүр үгс

- Ялгаварлан гадуурхахтай холбоотой туйлширсан бодлыг төрүүлдэг үгсийн талаар ярилцах
- Нэгнийгээ нэр хоч өгөн шоолох нь шууд бус замаар ялгаварлан гадуурхаж байгаа гэдгийг ойлгуулах
- Хочлуулж байсан хүүхэд байгаа эсэхийг асууж тэд ямар хариу үйлдэл үзүүлж болох тухай ярилцах.(чимээгүй өнгөрөх, уурлах, муудалцах гэх мэт)
- Эдгээр гаргаж буй зан авирын аль нь хүлцэн тэвчих байдал вэ?

*Даалгавар: Хэн нэгнийг хоч өгч шоолох нь шууд бус замаар ялгаварлан гадуурхаж буй нэг хэлбэр гэж бодож үзсэн үү, таньд тийм тохиолдол байгаа бол уучлалт хүссэн захиа бичээрэй.*

**Үйл ажиллагаа 2.** Хүүхдүүд шилжилтийн насанд бие махбод, сэтгэл санаанд гарсан өөрчлөлтийг хэрхэн дасан зохицдог талаар ярилцах, жүжигчилсэн тоглолт хийлгэх ...

- Шилжилтийн насанд бие махбодод гарах өөрчлөлт нь биологийн процесс болох тухай тайлбарлаарай.
- Гарч буй өөрчлөлт нь хэвийн үзэгдэл гэдгийг хүлээн зөвшөөрөх, хүлцэн тэвчих талаар ярилцаарай. (бусдыг ойлгох, ялгаварлан гадуурхахгүй байх)
- Хүмүүс бие биедээ хэрхэн хандах, бусдыгаа хэрхэн дэмжих боломж байгаа талаар ярилцаарай.



*Өсвөр насанд бие махбод эрчимтэй өсөх бөгөөд үүнтэй зэрэгцэн Өөрийнхөө биеийг хэт анзаарах, Хэт мэдрэмтгий болох, Бодол санаа зөрчилдөх, Сэтгэл санаа хувирамтгай байх зэрэг өөрчлөлтүүд гардаг бөгөөд энэ байдал нь зөрчилдөмхий, түрэмгий зан чанаруудаар илэрдэг.*




*Даалгавар: Танд ийм зүйл тохиолдвол хэрхэн шийдвэрлэх вэ?*

**Үйл ажиллагаа 3.**

- Бэлгийн замаар халдварлах өвчний талаар ярилцах явцдаа шалтгаан үр дагаварын талаар сурагчдад ойлгуулах
- Хүсээгүй жирэмслэлт
- Үнэнч шударга зан чанарын тухай
- Тохиолдлын, түр зуурын сэтгэл хөөрөлд автахгүй , өөрийгөө хянаж хүлцэн тэвчиж чадвал хайртай хүмүүсээ хамгаалж чадах боломжийн тухай ярилцах

Улаанбаатар хотын хэмжээнд 2016 оны эхний 3 сарын байдлаар зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдварын 1964 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 14.9 хувийг эзэлж байна.

*Даалгавар: Бэлгийн замаар халдварлах өвчний талаар ярилцаж өөрийгөө болон найз нөхдөө хэрхэн хамгаалах тухай бичээрэй.*



### Үйл ажиллагаа 4.

- Монголчуудын байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах сэтгэлгээ нь тэдний амьдралын хэв маягт туссан тухай, үүний ач холбогдлыг тодруулан ярилцах -хүлцэн тэвчихийн сайн талыг тодруулан ярилцах (хүрээлэн буй орчиндоо мэдрэмжтэй хандах)

Мал амьтан: Малын заяа гомдоно гэж үзэж малтай догшин ширүүн харьцахыг хүлцэн тэвчиж иржээ.

Ургамал: Зэрлэгээр ургадаг үр жимс, хүнсний ургамлыг боловсроогүй байхад түүх, үр үндсээр нь таслах, сая урган соёолж байгаа ургамлыг таслах, залуу ногоон ой модыг огтлохыг ыг хүлцэн тэвчдэг.

Ус: Гол горхи, булаг шандын эхний газрыг хөндөх, чулууг ховхлох, мод ургамлыг хугалах тайрахыг цээрлэж хүлцэн тэвчдэг.

### Үйл ажиллагаа 5.

Аливаа асуудлын учир шалтгааныг мэдэх - Бид юуг хүлцэн тэвчиж болох, юуг хүлцэн тэвчих шаардлагагүй талаар ярилцах (ялгаатай байдлыг ойлгох, зөрчлийн эх үндэс шалтгааныг илрүүлэх)

Жолооч нар бензин хийдэг хувингаараа худгийн уснаас хутгаж, уухын аргагүй үнэртэй болгодог. Өөр худаг байхгүй учир аргагүй эрхэнд л ууж байна.
*(Хүний эрхийн Үндэсний Комиссын шалгалтын дүн. Гурвантэс сумын малчин Ц-тэй хийсэн ярилцлага, 2011 он. http://www.mn-nhrc.org/uploads/info_sheet.pdf*

| Д/Д | Багууд | Хүлцэн тэвчиж буй асуудлууд | Шалтгаан | Хүлцэн тэвчиж болохгүй асуудлууд |
|---|---|---|---|---|
| 1 | орон нутагт | | | |
| 2 | улс оронд | | | |
| 3 | дэлхийд | | | |

**Үйл ажиллагаа 6.** Өөрийн дуу хоолойгоо хүргэх

- Бид ямар эрхтэй вэ? гэсэн асуултын дагуу ярилцах
- Хүлцэн тэвчиж болохгүй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцах
- Эрх зүйн  хэм хэмжээнд үйлдэл хийх
- Бидний ямар эрх зөрчигдөж байна бид хэрхэн шийдвэрлэж болох тухай ярилцах, хэлэлцүүлэг  хийх

**Монгол улсын олон улсын гэрээ**

Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц

*5 дугаар зүйл: Шүүх болон шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлж буй бусад бүх байгууллагын өмнө тэгш байх эрх;*

*(1) Төрийн албан тушаалтан буюу аливаа бүлэг хүмүүс эсхүл байгууллагын зүгээс хүчирхийлэх, бие махбодид гэмтэл учруулах явдлаас төрөөр хамгаалуулж, хувийн аюулгүй байдлаа хангуулах эрх;*

*(2) Улс төрийн эрх,*

*(3) Иргэний бусад эрх,*

*(4) Эдийн засаг, нийгэм болон соёлын эрх,*

*(5) Тээвэр, зочид буудал, зоог, цайны газар, үзвэрийн газар, цэнгэлдэх хүрээлэн зэрэг нийтийн үйлчилгээний аливаа газраар үйлчлүүлэх эрхтэй.*



*Даалгавар: Бидний ямар эрх зөрчигдөж байна вэ? бид хэрхэн шийдвэрлэж болох тухай ярилцаад “Хүчирхийллийн тойрог” сэдвээр хэлэлцүүлэг хийгээрэй.*




*Даалгавар “НҮДЭЭ НЭЭ”*

*Энэхүү уриалгын талаар ярилцаад өгөгдсөн сэдвээр эссэ бичээрэй.*

***Багшид зөвлөмж:*** Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох санал санаачлагуудын талаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, өөрсдийн оролцооны талаар санал гаргах гэх мэт үл ажиллагаанд чиглүүлээрэй.

Тэмдэглэл

Тэмдэглэл

Тэмдэглэл